

# “ЭРҮҮЛ МЭНД” БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ



Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын

## УДИРДАМЖ



ДЭМБ-ын Номын сангийн каталоги

Хамт Олонд Түшиглэн Сэргээн Засах Хандлага: ХОТСЗ хандлагын Удирдамж

1.Сэргээн засалт. 2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн. 3.Хамт олонд түшиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээ. 4.Эрүүл мэндийн бодлого. 5.Хүний эрх. 6.Нийгмийн шударга ёс. 7.Хэрэглэгчийн оролцоо. 8.Удирдамж. I.Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. II.НҮБ-ын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Байгууллага. III.Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага. IV. Хөгжлийн бэрхшээл, Хөгжлийн олон улсын консорциум

ISBN 978 92 4154805 2

(NLM ангилал: WB 320)

### © Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага 2010

Бүх эрх хадгалагдсан. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын хэвлэлийг WHO Press, World Health Organization, 20 Avenue, 1211 Geneva 27, Switzerland (tel: +41 22 791 3264; fax: +41 22 791 4857; e-mail: bookorder@who.int) -аас авч болно. ДЭМБ-ын хэвлэлийг орчуулах эсвэл дахин боловсруулж зарах эсвэл арилжааны бус байдлаар хэрэглэх алинд нь ч зөвшөөрөл авах ба ДЭМБ-ын Хэвлэлийн газарт дээр дурдсан хаягаар (fax: +41 22 791 4806; e-mail: permission@who.int) хандана.

Энэхүү хэвлэлийн дотоод агуулга нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын үзэл бодлыг илэрхийлэхгүй. Газрын зурган дээрх цэгэн зураас хилийг ойролцоогоор төлөөлсөн.

Үүнд дурдагдсан тухайн онцгойлсон компани эсвэл үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас зөвлөсөн эсвэл зөвшөөрсөн гэсэн үг биш.


Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага энэхүү хэвлэлд орж буй мэдээллийг баталгаажуулж бүх боломжит урьдчилан сэргийлэх аргуудыг авсан хэдий ч уг хэвлэлийг ямар нэгэн илэрхийлэл, зөвшөөрлийн баталгаагүйгээр тараасан болно. Орчуулгын хариуцлага болон уг материалыг ашиглах эрх нь уншигч танд буй. Үүнийг ашиглахад гарах ямар нэгэн хохирлыг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага хариуцахгүй.

Хэвлэлийн дизайн, загварыг Inis Communication

[www.iniscommunication.com](http://www.iniscommunication.com)

Мальтад хэвлэв.





Энэхүү товхимлыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвшөөрөлтэйгөөр Дэлхийн Зөн Монгол Олон Улсын Байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй” төслийн санхүүжилтээр 600 хувь хэвлэв.

## **СЗСҮТ**

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, Эрхүүгийн гудамж, Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв  
20-р салбар, Ш,х: №364  
Утас:352423  
Цахим шуудан: info@nrc.gov.mn  
Цахим хуудас: www.nrc.gov.mn

## **АИФО**

Холбоо барих хаяг:  
АИФО байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар  
Улаанбаатар 210648, Ш,х:75  
Утас: 70153058

## **Дэлхийн зөн**

Холбоо барих хаяг:  
Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороолол, 15-р хороо, (133-70), Энхтайвны өргөн чөлөө, 49-р барилга, Соманг плаза, 4-р давхар, Улаанбаатар 15160,  
Шуудангийн хайрцаг 705  
Вэб: <http://www.wvi.org/mongolia>

Орчуулсан: Б.Түмэнжаргал, Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй” төслийн ажилтан, докторант

Хянасан: Д. Тулгамаа, АИФО байгууллагын суурин төлөөлөгч, нийгмийн ухааны магистр, докторант

Г.Түвшинжаргал, СЗСҮТ-ийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

С.Баярбат, СЗСҮТ-ийн Бодлогын хэрэгжилт, нийгмийн оролцооны хэлтсийн дарга, хууль зүйн ухааны магистр

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Жавхлан, СЗСҮТ-ийн Мэдээлэл технологийн мэргэжилтэн

ХАМТ ОЛОНД ТҮШИГЛЭН СЭРГЭЭН  
ЗАСАХ ХАНДЛАГЫН УДИРДАМЖ

**“Эрүүл мэнд”** бүрэлдэхүүн хэсэг

**Агуулга:**

Өмнөх үг.....

Эрүүл мэндийг дэмжих.....

Урьдчилан сэргийлэх.....

Эмнэлгийн тусламж.....

Сэргээн засалт.....

Туслах хэрэгсэл.....

## ӨМНӨХ ҮГ

Ямарваа нэгэн ялгаварлан гадуурхалгүйгээр хүн бүр эрүүл байх эрхтэйг олон улсын баримт бичгүүдэд заасан байдаг. Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага (ДЭМБ)-ын үндсэн хуулинд заасны дагуу хүн бүрийн үндсэн эрхийн нэг нь гарал угсаа, шашин шүтлэг, улс төрийн итгэл үнэмшил, эдийн засаг болон нийгмийн байдлаас үл хамааран эрүүл мэндээ боломжит дээд хэмжээнд хүргэх явдал юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийн эрхийг тусган тэмдэглэсэн байдаг. 25-р зүйлд зааснаар Оролцогч улсууд “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжлийн бэрхшээлийн улмаас нь ялгаварлан гадуурхалгүйгээр эрүүл мэндийн хүрч болох боломжит дээд түвшинд хүрэх эрхтэйг хүлээн зөвшөөрнө”, мөн 20-р зүйл (хүртээмж), 26-р зүйл (Сэргээн засалт ба амьдралын чадварт бэлтгэх явц) дээр Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүл мэндийн сэргээн засалт болон хүйсийн мэдрэмжтэй эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломжоор хангана гэж заасан байна.

Харамсалтай нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь нийт хүн амаас доогуур түвшний эрүүл мэндийн үйлчилгээг авдаг бөгөөд эрүүл мэндийн эрхээ бүрэн дүүрэн эдлэхэд бэрхшээлтэй тулгардаг нь нотлогдож байна.

Эрүүл мэндийн эрх гэдэг нь дан ганц эрүүл мэндийн үйлчилгээ авах тухай асуудал биш, харин энэ нь эрүүл мэндийн гол тодорхойлогч зүйлүүд болох аюулгүй ундны ус, шаардлага хангасан эрүүл ахуй болон орон байртай байх зэрэг асуудал юм. Мөн эрүүл мэндийн эрхэнд эрх, эрх чөлөө багтана. Эдгээр эрх чөлөөнд туршилт судалгааны зорилготой нийтээр хүлээн зөвшөөрөгдөөгүй эмийн эмчилгээнээс ангид байх эрх, эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх багтана. Эрүүл мэндтэй холбоотой эрхэнд эрүүл мэндийг хамгаалах системийн эрх, урьдчилан сэргийлэх, эмчлүүлэх болон өвчинг хянах эрх, зайлшгүй шаардлагатай эм хэрэглэх болон эрүүл мэндтэй холбоотой шийдвэр гаргахад оролцох зэрэг хамаарна.

Хамт олонд түшиглэн сэргээн засах (ХОТСЗ) хөтөлбөр нь эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж, сэргээн засах ба туслах хэрэгсэл гэсэн таван гол салбарт ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүл мэндийн боломжит дээд түвшинд хүрэхэд нь дэмжлэг үзүүлнэ. ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүст хүрэхийн тулд эрүүл мэндийн салбартай хамтран ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг эдлүүлэхийн тулд эрүүл мэндийн үйлчилгээнд нөлөөлөл үзүүлж, хариу үзүүлэх чадвартай, хамт олонд түшиглэсэн, оролцоог хангасан бүгдийг хамруулсан эрүүл мэнд болгохын төлөө ажиллана.



## Жишээ 1 Тайланд

### Хамт олонд эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх нь

Тайланд нь анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээг амжилттай хэрэгжүүлдэг, олон шинэлэг стратеги, үйл ажиллагааг санаачилж өөрчлөлт хийсэн түүхтэй орон юм. Ихэнх орон нутагт анхан шатны эрүүл мэндийн тусламж нь хиймэл дагуулын сүлжээнд тулгуурлаж томоохон эмнэлэгүүдтэй холбогдсон байдаг. 2006 онд эдгээр эмнэлгүүдийн нэг болох Сичон эмнэлэг нь анхан шатны тусламжийн нэгжийн сүлжээнд ХОТСЗ хандлагыг танилцуулжээ. Та–Хин анхан шатны тусламжийн нэгж нь энэхүү сүлжээний нэг хэсэг нь юм. Тосгонд байрлах уг нэгж нь өрхийн эмч, эм зүйч, сувилагч болон эрүүл мэндийн ажилтан зэргээс бүрдэнэ. ХОТСЗ хандлагыг хэрэгжүүлэхээс өмнө уг баг нь ихэвчлэн эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг явуулдаг байсан. ХОТСЗ хандлагыг хэрэгжүүлж эхэлснээр тэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг илрүүлэх, ерөнхий ба тусгайлсан эрүүл мэндийн тусламжийн үйлчилгээний хэрэгцээнд анхаарлаа хандуулдаг болсон.

ХОТСЗ хандлага нь гол анхаарлаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрүүл мэндийн үйлчилгээг “хаалган дээр” нь хүргэхэд чиглүүлсэн юм. Сичон эмнэлэгтэй шууд холбох гэрийн эрүүл мэндийн тусламжийн систем (өндөр настай хүмүүс болон архаг хууч өвчинтэй хүмүүс)-ийг байгуулсан. Та–Хин багийн гишүүд ба Сичон эмнэлгийн хөдөлгөөн засалч гэрээр тогтмол очин хүмүүсийг шаардлагагүй мөн өндөр зардал гаргахаас сэргийлэх боломжийг олгосон. Мөн гэрийн нөхцөлд сэргээн засах үйлчилгээг бий болгосон. Орон нутгийн сайн дурын ажилчид болон гэр бүлийн гишүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлэх сэргээн засалтын үндсэн зүйлийг (өдөр тутмын амьдралын ур чадварын сургалт) зааж өгч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш хамруулан сургах боловсролыг дэмжсэн. Олон салбарын хамтын ажиллагааны үр дүнд бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрүүл мэндийн тусламж, сэргээн засалтын үйлчилгээг өөрийн амьдарч байгаа газраа авах, мөн шаардлагатай үед тэднийг Сичон эмнэлэгт илгээх үйлчилгээг авах боломжтой болсон.

2008 оны үнэлгээгээр ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрт илрүүлэх, үйлчилгээг аль болох эрт үзүүлэх, сургалт зохион байгуулах, туслах хэрэгслээр хангаж эрүүл мэндийг дэмжих болон сэргээн засах үйлчилгээ үзүүлэх зэрэг төрөл бүрийн эрүүл мэндийн тусламжийн үйлчилгээгээр хангасан байна гэж дүгнэжээ. Эцэст нь дүгнэхэд, бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын чанар сайжирч, тэдний бие даасан байдал, хөдөлгөөний байдал болон харилцааны чадварт ахиц дэвшил гарчээ. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг, эх илүү сайн дэмжлэг тусалцаа авдаг болсон. Бүх гол түншлэгчид (Сичон эмнэлэг, анхан шатны тусламжийн нэгж, хамт олон)-ийн хооронд хамтран



ажиллах сайн харилцаа бий болсон ба орон нутгийн сайн дурын ажилтнуудыг болон бусад нөөц бололцоонуудыг хөдөлгөөнд оруулснаар хамт олонд эрх мэдэлжиж, өөрсдөө эзэмшиж эхэлсэн.

## Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрүүл мэндээ хүрч болох боломжит дээд хэмжээнд хүргэх.

## ХОТСЗ-ын үүрэг

ХОТСЗ хөтөлбөрийн үүрэг нь эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээ, сэргээн засах, туслах хэрэгслээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн хэрэгцээг хангахын тулд эрүүл мэндийн салбартай хамтран ажиллахад оршино. Мөн ХОТСЗ хөтөлбөр нь хувь хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүдийг эрүүл мэндийн үйлчлгээг хүртэхэд, мөн эрүүл мэндийн бүхий л асуудлыг шийдвэрлэхэд бусад салбаруудтай хамтран ажиллах шаардлагатай.

## Хүсч буй үр дүн

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн мэдлэг нэмэгдэж, эрүүл мэндээ сайжруулахын тулд идэвхтэй оролцогч байна.
- Эрүүл мэндийн салбар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийн сайжруулахад анхаарч, хөгжлийн бэрхшээлээс нь болон бусад хүчин зүйлээс (жишээ нь хүйс) болж ялгаварлан гадуурхахгүй байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд эрүүл мэндийн тусламж болон сэргээн засах тусламж үйлчилгээг өөрийн амьдарч байгаа газарт болон аль болох ойр газарт боломжийн өртгөөр хүртэнэ.
- Эрүүл мэндийн болон сэргээн засалтын тусламж, үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гэр бүлийн болон хамт олны амьдралд идэвхтэй оролцогч болох боломж олгоно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сайн эрүүл мэндтэй болгохын тулд боловсрол, амьжиргаа болон нийгмийн салбарууд зэрэг хөгжлийн бүх салбаруудын хамтын ажиллагаа сайжирна.

## Гол ойлголтууд

### Эрүүл мэнд гэж юу вэ?

Уламжлалт байдлаар эрүүл мэнд гэдэг нь өвчин, эмгэггүй байх гэсэн үг. Хэдий тийм боловч ДЭМБ-ын тодорхойлсноор энэ нь маш өргөн ойлголт бөгөөд “Эрүүл мэнд гэдэг нь дан ганц өвчин, эмгэггүй байгаад зогсохгүй, бие бялдар, сэтгэл санаа, нийгмийн сайн сайхан байх”-ыг хэлнэ. Эрүүл мэнд нь хувь хүн, нийгэм, эдийн засгийн хувьд бүтээмжтэй амьдрах үнэт баялаг бөгөөд энэ нь чөлөөтэй сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх, гэр бүл болон хамт олны амьдралд идэвхтэй оролцох боломжийг олгодог.



## Жишээ 2 ЭНЭТХЭГ

### Куршида

Куршида сонсгол, харааны бэрхшээлтэй бөгөөд Энэтхэгийн Прадеш Уттар мужийн Барабанки дүүргийн жижиг тосгонд төрсөн. ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан Сатябхама Sense International байгууллагын сургалтанд хамрагдсан бөгөөд нь Куршидатай таарах үед Куршида 10 настай байсан ба хамт олноос тусгаарлагдсан, ихэнх цагийг гэрийнхээ харанхуй буланд хэвтэж өнгөрөөдөг байв. Тэрээр бүх хэрэгцээн дээр ээжээсээ бүрэн хамааралтай байсан ба бусадтай харилцаж чаддаггүй байв. Сатябхама Куршидад харилцааны болон өдөр тутмын амьдралын чадваруудыг зааж сургасан. Куршида босч сууж, хоолоо өөрөө идэж, тоглоом тоглох зэрэг зэрэг үйлдэл үзүүлж эхэлсэн. Тэрээр ээжийнхээ саариг татах зэргээр хүрч харилцаж сурч эхэлсэн. Сатябхама Куршидаг гараас нь хөтөлж, гэрээс гарахад нь тусалсан. Тэр шувуу жиргэхийг сонсож байгаагүй, наранд ч гарч байгаагүй. Энэ бүгдийг мэдрээд нүүрэнд нь оч гялалзаж сэтгэл нь сэргэсэн. ХОТСЗ хөтөлбөр Куршидад хөгжлийн бэрхшээлийн үнэмлэхээ авахад нь тусалсан. Ингэснээр олон төрлийн үйлчилгээ авах боломжоор хангагдаж, хөтөлбөрийн ачаар Куршидагийн ээж сүрьеэгийн эмчилгээнд хамрагдсан. Сатябхама Куршидатай үргэлжлүүлэн ажиллаж байгаа ба одоо түүнд дохионы хэл зааж байна. Энэ нь Куршида болон түүний гэр бүлийн хувьд урт аялал болох хэдий ч тэд ХОТСЗ хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Куршидаг хамт олны амьдралд бүрэн дүүрэн хамрагдах хүртэл нь хамтран ажиллаж байна.

### Эрүүл мэндийг тодорхойлогч хүчин зүйлс

Хүний эрүүл мэндийн байдалд хувийн, эдийн засгийн, нийгмийн болон хүрээлэн буй орчны зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг. Эдгээр хүчин зүйлсийг эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллөөр нь дараах байдлаар ангилдаг.

- **Удамшил:** Удамшлын онцлог, амьдралын мөчлөг, наслалт зэрэг олон хүчин зүйлс тухайн хүний эрүүл мэнд болон тодорхой өвчин үүсэхэд нөлөөлдөг.
- **Хувийн зан үйл ба амьдралын хэв маяг:** хоолны дэглэм, үйл ажиллагаа, тамхи, архины хэрэглээ, болон амьдралд тохиолдох стресст хэрхэн хандах нь эрүүл мэндэд нөлөөлдөг.
- **Нийгэмд эзлэх байр суурь ба орлого:** Баян, ядуу хүмүүсийн хооронд асар их ялгаа байдаг шиг эрүүл мэнд нь ч гэсэн асар их ялгаатай.
- **Хөдөлмөр эрхлэлт болон ажлын нөхцөл:** Хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс, ялангуяа ажлын нөхцөл байдал нь илүү хяналттай байдаг хүмүүсийн эрүүл мэнд сайн байдаг.
- **Боловсрол:** Боловсролын түвшин бага байх нь тухайн хүний эрүүл мэнд муудаж, илүү стресстэй болж, өөртөө итгэлгүй байдал зэргийг үүсгэдэг.
- **Нийгмийн дэмжлэг, туслалцаа:** гэр бүл, найз нөхөд, хамт олон хэдий чинээ дэмжинэ эрүүл мэнд төдий чинээ сайн байдаг.
- **Соёл:** гэр бүл, хамт олны ёс заншил, уламжлалт байдал, итгэл үнэмшил нь эрүүл мэндэд нөлөөлдөг.
- **Хүйс:** Эрэгтэй, эмэгтэй хүмүүс өөр өөр өвчнөөр өөр өөр насандаа өвчилдөг.
- **Бие махбодын орчин:** аюулгүй ундны ус, цэвэр агаар, эрүүл ажлын байр, аюулгүй орон гэр, хамт олон ба зам зэрэг нь эрүүл мэнд сайн байхад хувь нэмрээ оруулдаг.
- **Эрүүл мэндийн үйлчилгээ:** үйлчилгээнүүд нь мөн эрүүл мэндэд нөлөөлнө.

Эдгээр хүчин зүйлүүдээс заримыг нь хянаж болно. Тухайлбал хүн эрүүл эсвэл эрүүл бус зан үйлийг сонгож болно. Харин зарим хүчин зүйлийг нь хянах боломжгүй байдаг. Тухайлбал удамшлын хүчин зүйлийг хянаж чадахгүй.

### **Хөгжлийн бэрхшээл ба эрүүл мэнд**

1978 онд Алма-Атад хуралдсан эрүүл мэндийн анхан шатны тусламжийн бага хурал дээр ДЭМБ дэлхийн эрүүл мэндийн зорилгыг “Бүх нийтээрээ эрүүл байх” гэж тодорхойлсон. 30 жилийн дараа дэлхийн олон улс орон энэ зорилтод хүрч чадаагүй бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг олон бүлэг хүмүүсийн эрүүл мэнд тааруу байсаар байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийн байдлыг сайжруулахад доорх зүйлийг анхаарах нь чухал:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусад хүн амын нэгэн адил амьдралын үе шатуудад өөр өөр хэрэгцээ гарч ирж, ерөнхий эрүүл мэндийн тусламжийн хэрэгцээ (эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх үйлчилгээ, эмнэлгийн тусламж) –нүүд шаардлагатай байдаг.
- Хэдийгээр бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст өөрийнх нь эмгэг согогтой холбоотой эрүүл мэндийн асуудал төдийлөн гарахгүй боловч тэдний олонхид нь янз бүрийн шалтгааны улмаас тогтмол болон түр зуурын, амьдралынхаа туршид болон богино хугацаанд сэргээн засах гэх мэтийн зэрэг эрүүл мэндийн тусгай үйлчилгээ шаардагддаг.

### **Эрүүл мэндийн тусламж**

#### **Эрүүл мэндийн тусламж үзүүлэх**

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг улс орон бүр эрүүл мэндийн тогтолцоогоор дамжуулан олгодог. Эрүүл мэндийг дэмжих, сэргээх, эрүүл байдлыг хадгалах зорилготой бүх байгууллага, институт, нөөц боломж болон хүмүүс нь тэрхүү тогтолцоог бүрдүүлдэг. Хэдийгээр эрүүл мэндийн тогтолцооны үндсэн үүргийг засгийн газар хариуцдаг хэдий ч улсын, хувийн, уламжлалт болон албан бус салбарууд хамтран эрүүл мэндийн дийлэнх үйлчилгээг үзүүлдэг.

2008 оны Дэлхийн эрүүл мэндийн тайлан илтгэлд эрүүл мэндийн анхан шатны тусламжийн үндсэн үүрэг нь хүн бүрт эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэх явдал юм гэж онцолсон. Анхан шатны тусламж нь хувь хүн, гэр бүлд хүртээмжтэй, үнийн хувьд боломжийн байх нь чухал. Хувь хүн, гэр бүл, хамт олны хувьд энэ нь эрүүл мэндийн үндэсний тогтолцоотой холбогдох эхний шат бөгөөд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэдний ажиллаж, амьдарч байгаа газарт нь аль болох ойр үзүүлдэг.

#### **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд тулгарах саад бэрхшээлүүд**

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийн байдал нь тааруу байгаа нь тэдний хөгжлийн бэрхшээлээс шууд хамаарахгүй байж болно. Энэ нь үйлчилгээ, хөтөлбөрт хүртээмжгүйгээс саад бэрхшээл үүсч болно. Буурай хөгжилтэй

орнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн маш бага хувь нь сэргээн засах болон бусад шаардлагатай суурь үйлчилгээг хүртэж чаддаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд эрүүл мэндийн тусламж хүртэхэд дараах саад, бэрхшээлүүд тулгарч болно. Үүнд:

- Эрүүл мэндийн бодлого, хууль тохиромжгүй эсвэл байхгүй байх – Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх бодлого болон хууль нь гарсан боловч хэрэгждэггүй, эсвэл хуулийг мөрддөггүй, ялгаварлан гадуурхдаг, эсвэл үйлчилгээ үзүүлэхэд саад болдог;
- Эдийн засгийн саад бэрхшээл – үнэлгээ, эмчилгээ, эм зэрэг эрүүл мэндийн үйлчилгээнүүд нь бэлэн мөнгөөр худалдан авах үйлчилгээнүүд байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд эрүүл мэнд тусламж авах орлого хязгаарлагдмал байдгаас хүндрэл ордог (Танилцуулга товхимол: Ядууралх ба хөгжлийн бэрхшээ хэсгийг уншина уу);
- Бие махбодын болон газарзүйн байршлын саад бэрхшээл – Тээврийн хэрэгсэл, барилга байгууламж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хүртээмжгүй байдал нь нийтлэг бэрхшээлүүдийн жишээ бөгөөд хөдөө орон нутаг дахь эрүүл мэндийн тусламжийн хязгаарлагдмал байдал (хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ихэнх нь амьдардаг), мөн том хотод үйлчилгээнд хүрэх гэж урт замыг туулах зэрэг нь ч нийтлэг бэрхшээлүүдийн жишээ юм;
- Холбоо харилцаа ба мэдээллийн саад бэрхшээл – Эрүүл мэндийн ажилтнуудтай харилцахад хүндрэл үүсч болно. Тухайлбал, сонсголгүй хүн эмчид өөрийнхөө шинж тэмдгийг тайлбарлаж ойлгуулахад хүндрэлтэй байж болно. Мөн эрүүл мэндийн мэдээллүүд оюуны бэрхшээлтэй хүмүүст зориулсан зурган хэлбэрээр гаргах гэх мэтээр хүртээмжтэй хэлбэрээр хэвлээгүй байдаг;
- Эрүүл мэндийн ажилтнуудын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх мэдлэг, хандлага дутмаг байдаг – эрүүл мэндийн ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийн асуудлыг ойлгох, тэдэнтэй ажиллах ур чадвар, мэдлэг ихэнхдээ дутмаг байдаг. Тэд мэдрэмжгүй, ялгаварлан гадуурхсан, тохиромжгүй хандлагатай байж болно;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эмнэлгийн тусламж үйлчилгээний талаарх мэдлэг, хандлага дутмаг байдаг – хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авахдаа дургүй байж болно.; мөн ихэнх нь өөрсдийнхөө эрх, эрүүл мэндийн асуудал болон эрүүл мэндийн ямар үйлчилгээнүүд байгаа талаар хязгаарлагдмал мэдлэгтэй байдаг.

Зарим хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдаасаа илүү ялгаварлан гадуурхагдсан, хаягдсан, илүү эмзэг байж болно. Тэд хөгжлийн бэрхшээлийн төрөл, нас, хүйс, нийгэмд эзлэх байр суурь гэх мэт олон бэрхшээлүүд нэг дор төвлөрч, үүнээсээ болж зовдог байж болно. Тиймээс тэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүртэхэд илүү хүндрэлтэй, бэрхшээлтэй байж болно. ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, хүүхэд, өндөр настнууд, мөн сонсголгүй ба хараагүй, оюуны бэрхшээлтэй, ХДХВ/ДОХ ба хөгжлийн бэрхшээл, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай, уяман өвчтэй эсвэл арьс цайрах өвчтэй зэрэг хавсарсан бэрхшээлтэй хүмүүст онцгойлон анхаарал тавих ёстой (Нэмэлт товхимолыг уншина уу).

### **Эрүүл мэндийн үйлчилгээнд тэгш хамруулах**

“Боловсролд тэгш хамруулах” гэдэг ойлголт нь дэлхий нийтийн боловсролын тогтолцоонд өргөн хүрээнд хэрэгждэг, танил болсон ойлголт юм. Энэ нь бүх хүнд

ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургууль болон сургалтын төвүүдэд бүрэн дүүрэн оролцож боловсрол эзэмшихийг нь дэмждэг хандлага юм (Боловсрол бүрэлдэхүүн товхимолыг уншина уу). Үүний нэгэн адил “эрүүл мэндийн үйлчилгээнд тэгш хамруулах” гэсэн ойлголт нь эрүүл мэндийн тогтолцоо бодлого, төлөвлөлт, үйлчилгээ үзүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг



харгалзан үзэхийг баталгаажуулж, ХОТСЗ хөтөлбөр дэмжиж байгаа хандлага юм. Энэ нь эрүүл мэндийн анхан шатны тусламжийн “Бүх нийтээрээ эрүүл байх” ойлголтод суурилсан бөгөөд эрүүл мэндийн тусламж нь хувь хүн, гэр бүл, хамт олонд хүртээмжтэй, тухайн хамт олон, улс орон төлж чадахуйц зардалтай байх ёстой.

Эрүүл мэндийн үйлчилгээнд тэгш хамруулах гэдэг нь хувь хүн бүр эмгэг, согог, нас, хүйс, арьсны өнгө, шашин шүтлэг, нийгэм эдийн засгийн байдлаас үл хамааран эрүүл мэндийн тусламжийг хүртэх боломжтой гэсэн үг юм. Иймд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид нь төрөл бүрийн эмгэг согогтой хүмүүсийн хэрэгцээг хангахад чиглэгдсэн харилцааны чадвар, зохих чадварыг эзэмшин, хөгжлийн бэрхшээл болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар эерэг хандлагатай байх хэрэгтэй. Хэн нь ч нэгнийгээ үл хайхран, ялгаварлан гадуурхахгүй байж, бүх орчин өөрчлөгдөх хэрэгтэй. Үүнийг хийх нэг арга бол эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон сэргээн засах үйлчилгээг төлөвлөхдөө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагыг идэвхтэй оролцуулах явдал юм.

## Жишээ 3 Пакистан

### Саад бэрхшээлийг даван туулах урам хайрласан нь

Мухаммад Акрам нь Пакистаны Синд мужийн иргэн. Тэрээр өвчний улмаас өсвөр насандаа сонсголгүй болсон. Дараах түүх нь тэр гэр бүлтэйгээ хамт эмчид үзүүлсэн тохиолдлыг өгүүлнэ. “Сонсголгүй учир хүмүүс юуны тухай ярьж байгааг мэддэггүй байлаа. Би эмчээс юм асуух бүрт эмч гэр бүлийнхэнд маань хариултыг өгч байлаа. Би гэрийнхнээсээ юм асуухад тэд “санаа зоволтгүй, онц зүйл биш” эсвэл “чамд дараа хэлье” гэж байв. Хэн ч надад тайлбар хэлсэнгүй, би зөвхөн эмээ л ууж байлаа. Хэн ч дохионы хэл ашигладаггүй, үзэг цаас аваад бичгээр надтай харилцах хүсэл болон цаг ч байсангүй. Хугацаа өнгөрөх тусам би өөртөө итгэлгүй болж, бусдаас хамааралтай болж эхлэв. ХОТСЗ хөтөлбөрт хамрагдсанаар өөртөө итгэх итгэлээ аажмаар олж, өөрт тулгарч буй саадтай нүүр тулгарч сурав. Эмчид үзүүлэхдээ гэрийхэнтэйгээ явахаас татгалзаж ганцаараа явдаг болов. Энэ нь эмчийг надтай бичгээр ойлголцохоос өөр аргагүй болгов. Зарим эмч нар дараагийн удаа ирэхдээ гэрийнхэнтэйгээ ирэхийг гуйхад би өөрөө насанд хүрсэн хүн гэж хариулдаг байв. Өөртөө итгэх итгэлтэй болж, эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт авахад нь мөн тусалсан.

## **ХОТСЗ ба эрүүл мэндийн салбар**

ХОТСЗ хөтөлбөр нь орон нутгийн эрүүл мэндийн анхан шатны тусламжтай хамтран ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй хүн, эрүүл мэндийн тусламжийн тогтолцоог хооронд нь холбож, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрүүл мэндийн тусламжийг хүргэхэд чиглүүлж чадна. Аргентин, Индонез, Монгол, Вьетнам зэрэг орнуудад ХОТСЗ хөтөлбөр нь эрүүл мэндийн тусламжийн тогтолцоотой шууд холбоотой байдаг – хөтөлбөрийг эрүүл мэндийн яам нь удирдаж, эрүүл мэндийн анхан шатны тусламжийн бүтцээрээ дамжуулан хэрэгжүүлдэг. Олон оронд ХОТСЗ хөтөлбөрийг засгийн газрын бус байгууллагууд, эсвэл нийгмийн халамж гэх мэт өөр яамд удирддаг. Ийм тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрүүл мэндийн тусламж болон сэргээн засах үйлчилгээг аль болох эрт авахыг баталгаажуулахын тулд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээтэй маш нягт холбох шаардлагатай.

## **Энэ бүрэлдэхүүн хэсгийн элементүүд**

ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийн тусламжийн гол зүйлүүдийг таньж, дэмжиж, нөлөөлнө. Эдгээр нь:

### **Эрүүл мэндийн дэмжлэг**

Эрүүл мэндийг дэмжихийн гол зорилго нь эрүүл мэнд, түүнийг тодорхойлогч хүчин зүйлд тавигдах хяналтыг нэмэгдүүлэхэд чиглэнэ. Энэ нь эрүүл мэндэд нөлөөлж байгаа үр нөлөөг арилгахын тулд хувь хүний чадварыг сайжруулж, нийгэм, эдийн засаг болон орчны нөхцөл байдлыг өөрчлөхөд чиглэсэн олон талт стратеги, оролцоог хамарсан өргөн ойлголт юм.

### **Урьдчилан сэргийлэх**

Урьдчилан сэргийлэх нь эрүүл мэндийг дэмжих гэсэн ойлголттой маш их уялдаатай ойлголт. Эрүүл мэндийн нөхцлүүд (өвчин, эмгэг, осол гэмтэл гэх мэт)-ээс сэргийлэх аргууд нь анхдагч (эрсдлээс зайлсхийх), хоёрдогч (эрт илрүүлэх, эрт эмчлэх), гуравдагч (сэргээн засах) сэргийлэх байдаг. Энэ элемент нь ихэнхдээ анхдагч урьдчилан сэргийлэлтэнд анхаарлаа хандуулдаг.

### **Эмнэлгийн тусламж**

Эмнэлгийн тусламж нь эрт илрүүлэх, үнэлэх, тодорхойлох болон хувь хүний эмгэг согогийг анагаах, эсвэл хязгаарлах зэрэг эрүүл мэндийн нөхцөл байдлыг эмчлэх гэсэн утгатай. Эмнэлгийн тусламжийг эрүүл мэндийн тусламжийн тогтолцооны анхдагч, хоёрдогч, гуравдагч түвшинд үзүүлнэ.

### **Сэргээн засах**

Сэргээн засалт гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хүрээлэн буй орчиндоо илүү зохицоход нь туслах цогц арга хэмжээ юм. Энэ нь төрөлхийн эсвэл олдмол бэрхшээлийн аль алинд нь ач холбогдолтой. Сэргээн засах үйлчилгээг эмнэлэг,

гэр, мөн хамт олны хүрээнд анхан шатнаас нарийн мэргэжлийн түвшинд хүртэл үзүүлдэг. Сэргээн засалтыг ихэнхдээ эрүүл мэндийн салбар санаачилдаг боловч олон салбарын хамтын ажиллагаа шаардлагатай байдаг.

### **Туслах хэрэгсэл**

Туслах хэрэгсэл нь тухайн хүнийг тодорхой үүрэг гүйцэтгэхэд тохируулан бүтээж, хийж, эсвэл тохируулсан хэрэгсэл юм. Олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нэг болон түүнээс олон туслах хэрэгслийг хэрэглэдэг. Зарим нийтлэг хэрэглэгддэг туслах хэрэгслүүд нь: хөдөлгөөний хэрэгсэл (таяг, тэргэнцэр гэх мэт), хиймэл мөч (хиймэл хөл), ортоз (гарын чиг гэх мэт), харааны хэрэгсэл (нүдний шил, цагаан таяг), сонсголын хэрэгсэл (сонсголын аппарат). Туслах хэрэгслийг үр дүнтэй ашиглахын тулд хэрэглэгчийг сургах, засах, сэлбэх, орчинд нь тохируулах зэргийг хийх нь чухал.






# Эрүүл мэндийн дэмжлэг

## Танилцуулга

Эрүүл мэндийг дэмжих Оттавагийн тунхаглалд (1986) эрүүл мэндийг дэмжих гэдэг нь хүмүүс өөрсдийнхөө эрүүл мэндийг сайжруулах, хянах процесс юм гэж тодорхойлсон.

Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа нь хувь хүний эрүүл мэндийн зан үйл ба амьдралын хэв маяг, орлого ба нийгэмд эзлэх байр суурь, боловсрол, хөдөлмөр эрхлэлт ба ажлын нөхцөл, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж болон бие махбодын орчин зэрэг өөрчилж болдог эрүүл мэндийг тодорхойлогч хүчин зүйлд анхаарлаа хандуулдаг. Эрүүл мэндийг дэмжихэд үнэтэй эм, нарийн мэргэжлийн иж бүрэн тоног төхөөрөмж хэрэггүй, харин маш энгийн түвшинд эрүүл мэндийг дэмжих кампанит ажилд цаг хугацаа, хүч энергиэ зарцуулах хувь хүний хөрөнгө оруулалт гэх мэт нийгмийн оролцоо байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийн асуудлыг ихэнхдээ үл тоож, үүний улмаас тэд эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдалгүй үлддэг. Энэ элемент нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийг дэмжихийн чухлыг тодорхойлсон элемент юм. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хэрхэн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд хамруулах, шаардлагатай үед үндсэн үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэхийг ХОТСЗ хөтөлбөрт санал болгож байгаа юм. Мөн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа нь эрүүл мэндийг тодорхойлогч хүчин зүйлүүдийг өргөн хүрээгээр өөрчилдөг учир зөвхөн эрүүл мэндийн салбарын биш бусад салбаруудыг оролцуулах нь чухал.



## Жишээ 4 Кени

### Буруу ойлголт, ялгаварлан гадуурхалтыг даван туулсан нь

Африкийн зарим соёлд арьс цайралтыг эх нь хөл хүнд үедээ чөтгөртэй нөхчсөнөөс гарсан гэж итгэдэг. Арьс цайралттай хүүхэдтэй байх нь ёс суртахуунгүй бөгөөд эх, хүүхэд хоёул орон нутагтаа гадуурхагддаг. Арьс цайралттай хүүхэд нуугдмал байдалд байж, суурь эрх нь хөндөгдсөөр байна. Үүнд эрүүл мэндийн эрх ч бас хамарна.

Кенийн Квале Дүүргийн Нүдний Төв /КДНТ/ нь ХОТСЗ хөтөлбөртэй бөгөөд арьс цайралттай хүүхэд гэр, сургууль, орон нутгийн орчинд гадуурхагдан шоовдорлогдох хандлагыг багасгах зорилготой. Хүүхдийн эрүүл мэндийг хүрэх хамгийн түвшинд нь хүргэхийн тулд ХОТСЗ хөтөлбөр нь олон төрлийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа, оролцоог ашигладаг:

- Арьс цайралттай хүмүүсийн талаарх ойлголт, хандлага, эмчилгээнд өөрчлөлт хийхийн тулд хамт олны гишүүд, удирдлагууд, тосгоны эрүүл мэндийн хороо, багш, эмэгтэйчүүдийн бүлгүүдэд ойлголт өгөх;
- Эцэг, эхэд нь боловсрол олгосноор тэд хүүхдийнхээ эрүүл мэндийг хамгаалж, дэмжинэ. Тухайлбал арьс цайралттай хүмүүс нарны хурц гэрэлд гэмтэх өндөр эрсдэлтэй байдаг. КДНТ нь урт ханцуйтай цамц, өмд өмсөх зэргээр бие хамгаалах, наранд түлэгдэхээс сэргийлэх тос хэрэглэх зэрэг чухал боловсрол олгодог;
- Орон нутгийн зочид буудлуудтай хамтран ажиллаж, жуулчдыг нарнаас хамгаалах тос болон хэрэглэхгүй хувцасаа хандивлаж хэрэгтэй нэгэнд нь өгөхийг уриалах;
- Арьс цайралттай хүмүүст ихэвчлэн тохиолддог харааны эмгэгийг илрүүлэхийн тулд нүд шалгах ажлыг зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд нүдний шил, сул хараатай хүнд зориулсан хэрэгслээр хангах.

КДНТ нь эрүүл мэнд, боловсролын салбартай сайн хамтран ажилласны үр дүнд энэхүү ХОТСЗ хөтөлбөр амжилттай хэрэгсэн юм. Арьс цайралттай хүүхдүүд ердийн сургуульд сурдаг болсон.



## Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд эрүүл байх ёстой ба тэднийг өөрийн эрүүл мэндийнхээ түвшинг сайжруулах болон тэр хэвэнд нь байлгахад эрх мэдэлжүүлж, чадавхжуулахад оршино.

## ХОТСЗ-ЫН ҮҮРЭГ

ХОТСЗ хөтөлбөрийн үүрэг нь орон нутаг, бүсийн болон үндэсний түвшинд эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг тодорхойлж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг хамруулж, тэдэнд хүртээмжтэй болгохын тулд гол хүмүүс (эрүүл мэндийн яам, орон нутгийн захиргааны байгууллага)-тэй хамтран ажиллана. Өөр нэг үүрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд эрүүл мэндээ сайн байлгахын чухлыг, мөн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд идэвхтэй оролцохын чухлын талаар мэдлэг олгоход оршино.

## Хүсч буй үр дүн

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд эрүүл мэндийг дэмжих талаар хамт олны бусад гишүүдэд хүрдэг ижил мэдээлэл хүрдэг байх.
- Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны материал, хөтөлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн онцлог хэрэгцээнд тохирсон хэлбэрээр боловсруулах.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд өөрсдийн эрүүл мэндээ сайн байлгах талаар мэдлэг, чадвартай, мөн бусад хүмүүст тусладаг байх.
- Эрүүл мэндийн тусламж үзүүлэгчдийн нийт хүн ам болон эрүүл мэндийн тусгай хэрэгцээ шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх мэдлэг сайжирч, холбогдох эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг явуулах мэдлэгтэй байна.
- Хамт олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаануудад оролцуулж, орчныг бүрдүүлэхэд туслалцаа үзүүлнэ.
- ХОТСЗ хөтөлбөр нь өөрсдийнхөө ажилтнуудын ажлын байран дээр эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулж, тэднийг сайн эрүүл мэндтэй байхыг дэмжинэ.



## Гол ойлголтууд

### Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийг дэмжих

Эрүүл мэндийг дэмжих нь заримдаа урьдчилан сэргийлэх стратеги шиг харагддаг. Хөгжлийн бэрхшээл нь эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг хэрэглээгүйн улмаас үүсч бий болсон гэж харагдаж болох хэдий ч энэ нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой биш байдаг. Жишээ нь: нуруу нугасны гэмтлээс болж доод мөч нь саажсан хүн аль хэдий нь гэмтсэн учир эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны сайн жишээ биш байж болно.

Олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусад хүмүүсийн нэгэн адил эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа хэрэгтэй байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ч гэсэн бусад хүн амын нэгэн адил эрүүл мэндийн эрсдэлд ордог, харин ч эрүүл мэндийнх нь нөхцөл байдлаас (хөгжлийн бэрхшээлээс нь болж ч болно, эсвэл үүнтэй огт холбогдолгүй байж болно) болоод илүү өртөмхий байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн ихэнх нь эрүүл мэндээ сайн байлгах, эсвэл хэвийн хэмжээндээ барих талаар бага мэдлэгтэй байдаг.

### Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд тулгарах саад бэрхшээл

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрүүл мэндээ сайжруулах гэж оролдоход тулгарах саад бэрхшээл олон байдаг учраас бусад хүмүүсийг бодвол тэдний эрүүл мэнд илүү сул байдаг (Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд тулгардаг сааж бэрхшээл хэсгийг уншина уу). Харин эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулснаар эдгээр саадуудыг хялбархан арилгаж болно.

### Гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийг дэмжих

Ихэнх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусдын, ялангуяа гэр бүлийнхний дэмжлэг туслалцаа шаардлагатай байдаг. Гэр бүлийн гишүүд хөгжлийн бэрхшээлтэй хүнээ асарч байхад стресстсэнээс үүдэж бие өвдөж, сэтгэл хямрах, хүүхдүүдээ асрах чадвар нь буурах, ажилдаа зориулах цаг, хүч чадал багасах, нийгэмтэй харилцах харилцаа багасч, гадуурхагдах зэрэг олон асуудлуудтай тулгарч болно. Иймээс гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийг хэвийн хэмжээнд нь байлгах гэдэг бол маш чухал юм (Нийгмийн бүрэлдэхүүн хэсэг товхимол: Хувийн туслалцаа хэсгийг уншина уу).

### Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа

Эрүүл мэндийг дэмжих Оттавагийн тунхаглал нь эрүүл мэндийг дэмжих стратегийг боловсруулж, хэрэгжүүлэхэд тус болох 5 үндсэн зорилтыг тодорхойлсон байдаг.

#### 1. Эрүүл нийгмийн бодлого бий болгох

Бүх салбаруудын бодлого, дүрэм, журмыг эрүүл, аюулгүй бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, нийтийн эрүүл үйлчилгээ, цэвэрлэгээ зэрэг илүү таатай орчин бий болгож нийт хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалахад зориулж боловсруул.

## **2. Эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх**

Ажиллах, амьдрах орчин нь аюулгүй, таатай, сэтгэлд нийцэхүйц байлгах бие махбодын болон нийгмийн орчинд өөрчлөлт хий.

## **3. Хамт олныг бэхжүүлэх**

Эрүүл мэндийн асуудал нь нийгэм эдийн засаг, улс төр, хүрээлэн буй орчинтой маш хүчтэй холбоотой байдаг учир хамт олныг оролцуулах хэрэгтэй. Эрүүл мэндээ илүү сайжруулахад шаардлагатай нэн тэргүүний асуудлууд, шийдвэр гаргах, төлөвлөх, стратегийг хэрэгжүүлэхэд хамт олныг эрх мэдэлжүүлж, чадавхжуул.

## **4. Хувь хүнийг чадварыг хөгжүүлэх**

Хүмүүс өөрсдийнхөө эрүүл мэнд болон орчноо хянах, мөн эрүүл мэндийн нөхцөл байдлаа дээшлүүлэхийн тулд илүү зөв сонголтыг хийхэд нь Хувь хүнийг мэдээллээр хангаж эрүүл мэндийн боловсрол олгож хувь хүний чадварыг хөгжүүл.

## **5. Эрүүл мэндийн үйлчилгээг шинэчлэх**

Эрүүл мэндийн салбар нь эмчлэх анагаах үйлчилгээ үзүүлэхээс илүү эрүүл мэндийг дэмжих хандлага руу шилжих ёстой.

Эрүүл мэндийг дэмжих стратегийг нь дараах байдлаар хэрэгжүүлж болно:

- Хүн амын бүлгээр – хүүхдүүд, өсвөр үеийнхэн, өндөр настнууд
- Эрсдэлт хүчин зүйлээр – тамхичид, хөдөлгөөний идэвх багатай хүмүүс, зохисгүй хооллодог хүмүүс, аюултай бэлгийн харьцаатай хүмүүс
- Эрүүл мэнд болон өвчний байдлаар – чихрийн шижин, ХДХВ/ДОХ, зүрх судасны системийн эмгэг, амны хөндийн эрүүл мэнд
- Оршин байгаа газраар – хамт олны төв, клиник, эмнэлэг, сургууль, ажлын байр

Хувь хүмүүс өөрийн эрүүл мэндэд нөлөөлөх асар их чадвартай байдаг бөгөөд эрүүл мэндийг дэмжихэд хамтран оролцох нь өөрсдийн эрүүл мэндэд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг хянахад чухал юм. Эрүүл мэндийн асуудалд хандахдаа тэдэнд зориулж аливаа зүйлийг хийхээс илүү хамтран ажиллах шаардлагатай байдаг.

## **Санал болгож буй үйл ажиллагаанууд**

Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа нь тухайн орон нутгийн нөхцөл байдал, тэдний нэн тэргүүнд тавьж байгаа хүчин зүйлээс маш хамааралтай байдаг. Тиймээс энд санал болгож байгаа ажлууд нь ерөнхий саналууд юм. ХОТСЗ хөтөлбөр нь эрүүл мэндэд нөлөөлж байгаа хүчин зүйлүүд дээр хяналт тавьж ажиллаж байгаа хүмүүс, бүлгүүдтэй хамтран ажиллаж, нийт хүмүүст зөв ойлголтыг өгөх хэрэгтэй.

### **Эрүүл мэндийг дэмжих аяныг дэмжих**

Эрүүл мэндийг дэмжих аян нь хувь хүн, хамт олон, нийт хүн амын эрүүл мэндэд эерэгээр нөлөөлж болно – тэд мэдээлэл өгч, зан үйлийг өөрчлөхийг дэмжиж болно. ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийг илүү сайжруулахад дараах байдлаар дэмжиж болно:

- Хамт олны, бүсийн эсвэл үндэсний түвшинд явагддаг эрүүл мэндийг дэмжих аяныг олж илрүүлж, түүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг идэвхтэйгээр хамруулж, мөн тэдэнд зориулж үйл ажиллагаа зохиох;



- Хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт өгөхийн тулд эрүүл мэндийг дэмжих аянд идэвхтэй оролцох, мөн хамтран зохион байгуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар эерэг дүр зураг харуулах эрүүл мэндийг дэмжих аяныг дэмжих. Жишээ нь: нийт хүн амд мэдээлэл хүргэх зурагт хуудас, мэдээллийн самбар дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дүр, зургийг тавих;
- Эрүүл мэндийг дэмжих аяны ажлуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулж тохирох форматаар хийх. Жишээ нь: сонсголгүй хүмүүст зориулж бичгээр урсдаг дэлгэц, мөн дохион хэлээр нийтийн үйлчилгээний талаарх зар, сурталчилгааг явуулах;
- Хамт олонд байгаа нөөц бололцоог илрүүлэх (хамт олны манлайлагч, сонин хэвлэл, радио телевиз) ба хөгжлийн бэрхшээлтэй холбоотой эрүүл мэндийн асуудлыг хамрахыг дэмж. Аливаа зүйлийг хийхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, эрхэм зэргийг хүндэтгэх нь чухал;
- Орон нутагт зохион байгуулж байгаа эрүүл мэндийг дэмжих аянд хөгжлийн бэрхшээлтэй холбоотой асуудлуудыг хөндөхөд нь дэмжлэг үзүүлэх.



### **Хувь хүний мэдлэг чадварыг бэхжүүлэх**

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд эрүүл мэндийн боловсрол олгосноор тэдний эрүүл мэндийг сайжруулахад зайлшгүй шаардлагатай мэдлэг ур чадварыг бий болгоно. Тэд өвчний эрсдэлт хүчин зүйл, эрүүл ахуйн сайн орчин, эрүүл хоолны сонголт, хөдөлгөөний ач холбогдол, мөн бусад хамгаалах хүчин зүйлүүдийн талаар зохион байгуулалттай бүлгүүдээр (хувь хүн, жижиг бүлэг) дамжуулан мэдлэг болно.

ХОТСЗ хөтөлбөр нь :

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй гэр бүлд очиж эрүүл амьдралын хэв маягийг хэрхэн хэвшүүлж болох талаар практик зөвлөмж өгөх;
- Эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгааны материалуудыг (товхимол, нугалбар гэх мэт) цуглуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд өгөх;
- Мэдээлэл, сургалт, сурталчилгааны материалыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж хүртээмжтэй хэлбэрээр бэлтгэх. Жишээ нь: оюуны хомсдолтой хүмүүст ойлгоход энгийн, уншаад ойлгохоор хэлээр бичигдсэн, зурагтай байх шаардлагатай;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд эрүүл амьдралын талаар шинэ мэдлэг, чадвар олгох зорилготой орон нутгийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр, үйлчилгээний талаар мэдээлэл хүргэх;
- Хамт олныхоо дунд боловсрол олж авч чадаагүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан боловсрол олгох ажлыг зохион байгуулах;
- Эрүүл мэндийн боловсролыг ойлгомжтой байх үүднээс тоглоомын аргаар, дүрд тоглох, дадлага хийх, хэлэлцүүлэг, түүх ярих, асуудал шийдвэрлэх дасгал зэргийг өргөн хүрээтэй ашиглах;
- Эрүүл мэндийн тусламж үзүүлэгчтэй уулзахдаа өөртөө итгэлтэй байж, эмчээс асуулт асуух, өөрийнхөө эрүүл мэндийн талаар шийдвэр гаргахад нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд туслах;

- Хөгжлийн бэрхшээлтэй хувь хүн рүү чиглэсэн үйл ажиллагааг явуулахдаа эрүүл мэндийн салбартай хамтарч ажиллаж тэднийг эрүүл мэндийн дэмжих сургагч багш болоход нь зориулж сургалт явуулах.

## Өөрөө өөртөө туслах бүлгүүдтэй холбоо

Өөрөө өөртөө туслах бүлэг хэсэг бүлэг хүмүүсийг хоорондоо мэдээлэл, туршлага мөн өөртөө байгаа нийтлэг асуудлуудаа хуваалцах боломжийг олгодог (Эрх мэдэлжүүлэх бүрэлдэхүүн товхимол: Өөрөө өөртөө туслах бүлэг хэсгийг уншина уу). Ижил бэрхшээлтэй нэгнээс зөвлөгөө, тусламж авах нь эрүүл мэндийн ажилтнуудаас зөвлөгөө авснаас илүү үр дүнтэй байдаг. Энэ хэсэгт өөрөө өөртөө туслах бүлгүүд ихээр дурдагдана, учир нь тэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийг сайжруулахад хувь нэмэр оруулж чаддаг. ХОТСЗ хөтөлбөр:

- Эрүүл мэндийн тусгай хэрэгцээг нь хангахын тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үйл ажиллагаа явуулж байгаа өөрөө өөртөө туслах бүлэгтэй холбох. Тухайлбал нуруу нугасны гэмтэлтэй хүмүүс, уяман өвчтэй хүмүүс, ХДХВ/ДОХ-той хүмүүс, тархины саатай хүүхэдтэй эцэг эхчүүд гэх мэт;
- Тухайн тосгонд тохиромжтой бүлэг байхгүй бол бэрхшээлээрээ ижил хүмүүсийг шинээр өөрөө өөртөө туслах бүлэг байгуулахыг дэмжих. Ижил насны, ижил бэрхшээлтэй хүмүүс 1:1 хэлбэрээр бие биедээ илүү туслах иймэрхүү бүлэг байгуулахад хүндрэлтэй байж болно;
- Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд өөрөө өөртөө туслах бүлгийг идэвхтэй оролцуулахын тулд бусадтай хамтран ажиллах. Тухайлбал эрүүл мэндийн аялал зохион байгуулах, Дэлхийн эрүүл мэндийн өдөр, Дэлхийн сэтгэцийн эрүүл мэндийн өдөр, Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдрийг тэмдэглэх.

## Жишээ 5 Колумб

### Өөрөө өөртөө туслах бүлгээр дамжуулан эрүүл мэндээ хянах

Колумбын Пидекуэста-д ХОТСЗ хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр нуруу нугасны гэмтэлтэй хэсэг хүмүүс өөрөө өөртөө туслах бүлэг байгуулсан. Хэвтэж байгаа эмнэлэгтээ өөртөө хэрхэн анхаарал тавих, шарх болон шээсний асуудлаас хэрхэн урьдчилан сэргийлэх зэрэг эрүүл мэндийн мэдээлэл хангалтгүй байдаг.

Туршлагатай гишүүд нь саяхан нуруу нугасны гэмтлийн бэрхшээлтэй болсон шинэ гишүүддээ бусад чадвар болон туслах хэрэгсэл ашиглан хэрхэн даван туулах талаар зааж зөвлөдөг. ХОТСЗ хөтөлбөр нь иргэдийн эргэлзсэн асуултыг тодруулж эмнэлэг болон бүлгүүдтэй харилцан ажилладаг.



## **Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдийг сурга**

Эрүүл мэндийн тусламж үзүүлэгчид нь эрүүл мэндтэй холбоотой шинжлэх ухааны бодит мэдлэгтэй ба тэд бусдын эрүүл мэндэд эерэгээр нөлөөлөх чадвартай байдаг. ХОТСЗ хөтөлбөр нь эрүүл мэндийн ажилтнуудын хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг ойлголттой болгоход, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд хамруулахад хамтран ажиллах шаардлагатай.

ХОТСЗ хөтөлбөр нь:

- Эрүүл мэндийн ажилтнууд (эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэгчид)-ыг хөгжлийн бэрхшээлийн талаар чиглэл өгч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд тулгардаг асуудлыг ойлгуулах;
- Эрүүл мэндийн ажилтнууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ойлгож, эрхийг нь хүндэтгэн, ялгаварлан гадуурхахгүйгээр харьцахын чухлыг ойлгуулж, түүнчлэн сургалтандаа бодит жишээгээр тайлбарлах;
- Эрүүл мэндийн мэдээллийг ойлгомжтой болгохын тулд үйл ажиллагаагаа хэрхэн энгийн аргаар зохицуулж болохыг эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд харуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан эрүүл мэндийн мэдээлэл, хөтөлбөрүүдийг төлөвлөх, боловсруулахдаа төрөл бүрийн мэдээллийн хэрэгсэл, технологийг ашиглахыг дэмжих.

## **Жишээ 6 Монгол**

Монгол улсад ХОТСЗ хөтөлбөр ЭМ-ийн сайдын тушаалаар 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүрэгт хэрэгждэг. Өрх, сумын эмч, багийн бага эмч нар ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд гэж тооцогддог. АИФО Италийн төрийн бус байгууллага 1996 онд ЭМЯ-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, өрх, сумын эмч, багийн бага эмч нарыг ХОТСЗ хандлагын талаар сургалт зохион байгуулсан. Сургалтанд ХОТСЗ хандлагын тухай ойлголт, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гэрээр гэрт дамжин эрт илрүүлэх, эрт арга хэмжээ авах, хоёрдогч, гуравдагч хүндрэлд оруулахаас урьдчилан сэргийлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын чанарыг дээшлүүлэхийн тулд орлого олох үйл ажиллагааг дэмжих, өөрөө өөртөө туслах бүлэг байгуулах зэрэг гол үйл ажиллагаануудаар эмч нарт нийт 10 хоногийн, багийн бага эмч нарт 21 хоногийн сургалт явуулсан.

Мөн эмч, эмнэлгийн ажилтанг бэлтгэдэг их дээд сургуулиудын хичээлийн хөтөлбөрт ХОТСЗ хандлагыг оруулах зорилгоор Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуультай хамтран ХОТСЗ хөтөлбөрийн цөм хөтөлбөр боловсруулж байна.

## **Дэмжлэгт орчин бүрдүүлэх**

ХОТСЗ хөтөлбөр нь өрхийн эрүүл мэндийн төв, эмнэлэг, сургууль, ажлын байр, соёл амралтын газруудтай хамтран ажиллаж, гол түншүүдтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бие махбодийн болон нийгмийн дэмжлэгт орчинг бүрдүүлэх мөн дараах зүйлүүдийг хийж эрүүл мэндээ сайжруулах

боломж олгоно:

- Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн орчинг дэмжсэнээр эрүүл мэндийн тусгай хөтөлбөр, үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгох;
- Бие махбодын болон барилга байгууламжийн хүртээмжтэй байдлыг сайжруулахын тулд хот, нийгэм, эрүүл мэндийн төлөвлөгчид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хооронд түншлэлийг бий болгох;
- Амралт, чөлөөт цагийн үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулах боломжийг бий болгох. Жишээ нь: тэргэнцэртэй хүмүүсийн дунд хөлбөмбөгийн тэмцээн явуулахыг дэмжих (Нийгмийн бүрэлдэхүүн товхимол: Амралт, чөлөөт цаг, спорт хэсгийг уншина уу);
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тусгаарладаг, ганцаардуулдаг, нийгмээс тусгаарладаг зүйл нь нийтийн тээвэр байдаг учраас нийтийн тээврийг аюулгүй, хүртээмжтэй болгохыг баталгаажуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн талаарх эрүүл мэндийн салбарт болон хамт олны дунд байдаг эндүүрэл, буруу ойлголт, сөрөг хандлагыг арилгахын тулд эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл олгох;
- Хамт олны дунд байгаа эрүүл мэндийн асуудлуудад бүжиг, жүжиг, кино, дуу, хүүхэлдэйн жүжиг зэрэг соёлын үйл ажиллагаа зохион байгуулах.

## Жишээ 7 Египет

Александра хотод ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний гэр бүлийнхэн, сайн дурын идэвхтнүүдийг хамт бүлгээр нь амраах зуны зусланг ажиллуулсан. Хамтдаа цагыг зугаатай өнгөрүүлснээр эрүүл мэндийн байдал сайжирч, хамтдаа тоглож, найз нөхөд болдог. ХОТСЗ хөтөлбөр түүнчлэн орон нутгийн паралимпикийн хороо, эцэг эхийн холбоо болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай хамтарч жил бүр төв стадионд спортын өдрийг зохион байгуулдаг болсон байна.



### Эрүүл мэндийг дэмжигч байгууллага болох

Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих нь ажилчдын харилцааг сайжруулж мөн хүний нөөцийг чадваржуулан ажлын гүйцэтгэл, эрүүл мэндийг сайжруулдаг. ХОТСЗ хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байгууллагууд ажилтнуудынхаа эрүүл мэндийг дэмжихэд дараах зүйлүүдэд анхаарлаа хандуулах ёстой.

- Бүх ажилтнуудыг ажлын байрны түвшингээс хамаарахгүйгээр, эрүүл мэндийг сайжруулах арга замыг сайжруулах, эсвэл хэвийн хэмжээнд нь байлгахын тулд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтанд хамруулах;
- Эрүүл, аюулгүй орчноор хангах. Жишээ нь: тамхигүй орчин, эрүүл хоол, аюулгүй ус, эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, тохиромжтой ажлын цаг, аюулгүй тээврийн хэрэгслийн сонголт гэх мэт;
- Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын бодлого, журмыг боловсруулах. Тухайлбал, ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, тамхи, архи, эмний хэрэглээний хор уршиг, ялгаваран гадуурхалт ба буруу ойлголт гэх мэт;
- Ажилтнуудын эрүүл зан үйлийг хэвшүүлж бусдадаа үлгэрлэхийг сайшаах.



# Урьдчилан сэргийлэлт

## Танилцуулга

Эрүүл мэндийн тусламжинд урьдчилан сэргийлэлтийн гол анхаарлаа хандуулдаг зүйл нь эрүүл мэндэд муугаар нөлөөлөх нөхцлийг зогсоох явдал юм (анхдагч урьдчилан сэргийлэлт). Үүнээс гадна урьдчилан сэргийлэлтэд эрүүл мэндийн байдлыг муутгахыг зогсоох эрт илрүүлэлт, эмчилгээ (хоёрдогч урьдчилан сэргийлэлт), одоо байгаа эрүүл мэндийн байдлаас гарах үр дагаварыг бууруулах (гуравдагч урьдчилан сэргийлэлт) ордог. Энэ хэсэгт анхдагч урьдчилан сэргийлэлтийн талаар илүүтэй тусгасан.

Анхдагч урьдчилан сэргийлэлтэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж, төрөхийн өмнөх болон төрсний дараах асрамж, хоол тэжээлийн талаарх боловсрол, халдварт өвчний эсрэг дархлаажуулалтын аян, орон нутгийн шинжтэй өвчнүүдийг хянах арга хэмжээнүүд, аюулгүй байдлын дүрэм, өөр өөр орчинд осол гэмтэл гарахаас урьдчилан сэргийлэх хөтөлбөр, үүнд мэргэжлээс шалтгаалан осол гэмтэл гарах, өвчин эмгэг үүсэхээс урьдчилан сэргийлж ажлын байрыг тохируулах орно, орчны бохирдол эсвэл зэвсэгт мөргөлдөөнөөс үүсэн бий болох хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх орно.

Анхдагч урьдчилан сэргийлэлт болон эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг сайн ашиглабал дэлхийн өвчлөлийн ачаалал 70 хүртэл хувиар бууруулж болно гэсэн тооцоолол байдаг. Гэсэн хэдий ч урьдчилан сэргийлэлтийг (эрүүл мэндийг дэмжих) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийг удирдахад маш бага үүрэг гүйцэтгэдэг гэдэгт хүмүүс итгэлтэй байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийн тусламж нь ихэнхдээ нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж, сэргээн засалтанд анхаарлаа хандуулдаг. Өмнө нь дурдсанчлан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийн бусад нөхцөл байдалд эрсдэл учирдаг, тэдний анхдагч эрүүл мэндийн нөхцөл байдлаас хоёрдогч хүндрэл үүсэх эрхсдэл мөн байсаар байдаг.

Эрүүл мэндийг дэмжихтэй нэгэн адил урьдчилан сэргийлэхэд олон салбарын оролцоо шаардлагатай байдаг. Эрүүл мэндийн салбарт эрүүл мэндийн анхан шатны тусламж маш чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд ХОТСЗ хөтөлбөрүүд эрүүл мэндийн анхан шатны эрүүл мэндийн тусламжтай их холбоотой байдаг учир тэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэж чадна.





## Жишээ 8 ЭНЭТХЭГ

### Эрхэм зэрэгтэйгээр амьдрахуй

Энэтхэгийн Карнатака мужийн Чамаражнагар нь маш ядуу дүүрэг бөгөөд иргэдийн амьдралын чанар муу, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэд бүр ядуу байдаг. Мобилити Индия төрийн бус байгууллага нь Английн Хөгжлийн бэрхшээл, Хөгжлийн түншлэл байгууллагын дэмжлэгтэйгээр ХОТСЗ төсөл хэрэгжүүлсэн бөгөөд хүмүүс эрүүл ахуйн наад захын үндсэн хэрэгцээгээ хангаж чаддаггүйг олж илрүүлсэн. Ихэнх иргэд задгай талыг ашиглахын тулд хол явдаг байсан. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд хүндрэлтэй байв.

Энэтхэгийн засгийн газар бие засах газар барих тэтгэлэгийг олгож, Мобилити Индия нь Чамаражнагарийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй бие засах газар барихад туслав. Энэхүү шинэ төсөлд одоо байгаа хамт олонд түшиглэсэн сүлжээ болон өөрөө өөртөө туслах бүлгийг ашиглан Мобилити Индия нь эрүүл ахуйн тухай болон сайн эрүүл ахуй нь эрүүл мэндийн асуудлаас сэргийлдэг сэдвээр олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх зорилготойгоор гудамжны жүжигчилсэн тоглолт, хана будах зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулав. Хүмүүсийг сонирхож эхэлмэгц Мобилити Индия эрүүл ахуйн үндсэн хэрэгцээ хангах байгууламж барихдаа хамтарч ажиллахыг зөвшөөрөв.

Нэг бие засах газрын нийт зардал 150 ам.доллар байхаар тооцоолсон. Энэтхэгийн засгийн газар өрх бүрт буцалтгүй тусламж санал болгосон бөгөөд харин үлдэгдэл санхүүжилтийг төлөхөд ихэнх хүмүүс, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс түүнийг нь төлөхөд хүндрэл учирсан. Швейцарийн MIBLOU байгууллага болон орон нутгийн хувь нэмрийн тусламжтайгаар Мобилити Индия сайн чанарын, хүртээмжтэй 50 бие засах газрыг байгуулах боломжтой байв. Бие засах газар зайлшгүй шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй ядуу өрхийг сонгохыг аерөө өөртөө туслах бүлгийн гишүүдээс хүссэн. Тэд мөн олгосон санхүүжилт зөв зарж, гэр бүлийн гишүүдтэй хамтран ажиллаж байгууламж барих ажлыг зохицуулсан.

Олон хөгжлийн бэрхшээлтэй иргэд бие засахын тулд хол газар руу алхаж, мөлхөх шаардлагагүй болсон. Тэд бие дааж, хамгийн чухал нь эрхэм зэргээ буцаан авсан юм. Эрүүл ахуйн муу нөхцөл байдлаас үүдэлтэй бий болдог эрсдлүүд мөн нэлээд буурсан. Мобилити Индия байгууллагын энэхүү төсөл амжилттай хэрэгжсэнээс хойш Энэтхэгийн засгийн гауар буцалтгүй тусламжаа нэмэгдүүлж, холбогдох санхүүжилтийг нэн яаралтай олгож байхыг орон нутгийн засаг захиргаандаа үүрэг болгосон. Хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хүмүүс аль аль нь энэхүү төслөөс ижил ашиг хүртсэн бөгөөд энэ нь аажмаар дүүргийн хэмжээний төсөл болсон юм. Чамаражнагарын хүмүүс байшин дотроо бие засах газартай, эсвэл гэртээ ойрхон бие засах газартай болж удахгүй дүүрэг болно.



## Зорилго

Эмгэг, согоогоосоо үүдээд болон үүнтэй огт хамаарахгүйгээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сайн сайхан байхад тэдний эрүүл мэндийн байдалд нөлөөлж буй нөлөөллийг бууруулах, мөн гэр бүлийн гишүүд болон бусад хамт олны гишүүдийн хөгжлийн бэрхшээлээс үүдсэн эмгэг согог болон эрүүл мэндийн байдалд нөлөөлж буй нөлөөллийг бууруулахад оршино.

## ХОТСЗ-ын үүрэг

ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хүмүүсийн аль алинд урьдчилан сэргийлэх ажилд хамт олон болон холбогдох салбарынхан анхаарлаа хандуулахыг нь баталгаажуулахад оршино. ХОТСЗ хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг эрүүл мэндээ дэмжих үйлчилгээ хүртэх, мөн эрүүл мэндийн ерөнхий байдал муудах эсвэл хоёрдогч хүндрэлд орохоос урьдчилан сэргийлж, тэдний эрүүл мэндийг дэмжихэд туслана.

## Хүсч буй үр дүн

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд нь эрүүл мэндийн нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн эрүүл мэндийн мэдээлэл, үйлчилгээг хүртдэг болсон байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд эрүүл зан үйл, амьдралын хэв маягаа өөрчилж, сайжруулж үүсч болзошгүй эрүүл мэндийн асуудлын эрсдлийг бууруулна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн анхдагч урьдчилан сэргийлэлтийн үйл ажиллагаанд оролцуулна. Тухайлбал, эрүүл мэндийн өөр нөхцөл байдал үүсгэх эсвэл эмгэг согог үүсгэх эрсдлийг бууруулах зорилготой дархлаажуулалтын хөтөлбөр.
- Хамт олны бүх гишүүдийг анхдагч урьдчилан сэргийлэлтийн үйл ажиллагаанд оролцуулна. Тухайлбал, эрүүл мэндийн өөр нөхцөл байдал үүсгэх эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүргэх эмгэг согог үүсгэх эрсдлийг бууруулах зорилготой дархлаажуулалтын хөтөлбөр.
- Эрүүл мэндийн нөхцөл байдлын талаарх боловсрол эзэмшүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд туслах дэмжих зорилгоор ХОТСЗ хөтөлбөр эрүүл мэндийн болон бусад салбаруудтай хамтран ажиллана.

## Гол ойлголтууд

### Эрүүл мэндийн эрсдлүүд

Эрсдэлт хүчин зүйлүүд нь хүний эрүүл мэндэд нөлөөлж, осол гэмтэл, өвчин эмгэг үүсгэж байдаг. Хүн амьдралынхаа туршид эрүүл мэндийн олон эрсдэлд орж байдаг. Тэргүүлэх эрсдэлд хүчин зүйлүүдэд жин алдах, аюулгүй бэлгийн харьцаанд орох, цусны даралт ихсэх, тамхи, архины хэрэглээ, найваргүй ус, эрүүл ахуй, ариун цэврийн байдал, төмрийн дутагдал, хатуу түлшний утаа, угаар гэх зэрэг орж болно.

Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь хувь хүн болон хамт олны эрүүл мэндэд учирч болох эрсдлийг бууруулдаг. Гэр бүлийн түүх гэх мэт зарим эрсдэлт хүчин зүйлүүд нь тухайн хүний хяналтанд ордоггүй, харин хүний эрүүл мэндийн байдлыг сайжруулах, эсвэл хэвийн байдалд нь барихад амьдралын хэв маяг, бие махбодын болон нийгмийн орчинг өөрчилж болно. Эрүүл мэндийн салбар эдгээр эрсдэлт хүчин зүйлүүдэд онцгойлон анхаарлаа хандуулж чадна.

### Урьдчилан сэргийлэлтийн 3 түвшин

Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь дараах гурван түвшний аль нэг дээр байж болно.

- Анхдагч урьдчилан сэргийлэлт – “урьдчилан сэргийлэх нь эмчлэхээс илүү юм” гэсэн үг нь ихэнх хүмүүс танил байгаа бөгөөд энэ нь анхдагч урьдчилан сэргийлэлтийн гол чиглэл нь юм. Анхдагч урьдчилан сэргийлэх гэдэг нь зайлсхийх, үүсч буй эрүүл мэндийн нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах гэсэн үг. Эдгээр арга хэмжээ нь голцуу хүнд чиглэсэн (эрүүл мэндийн зан үйлийг өөрчлөх, дархлаажуулалт, хоол тэжээл гэх мэт), мөн орчин (найдвартай ус, эрүүл ахуй, сайхан амьдрал, ажлын нөхцлөөр хангах) руу чиглэсэн байдаг. Анхдагч урьдчилан сэргийлэлт нь хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хүмүүсийн аль алинд ижил хамаатай бөгөөд энэ элементийн гол чиглэл нь юм.
- Хоёрдогч урьдчилан сэргийлэлт - үр дагаварыг бууруулах, эмчлэхэд чиглэгдсэн эрүүл мэндийн нөхцөл байдлыг эрт илрүүлэх, эрт эмчлэх юм. Эрт илрүүлэхийн жишээ гэвэл хөхний хорт хавдрыг илрүүлэх, нүдний катарактыг шалгах маммограм шинжилгээ хийх, эрт эмчлэхийн жишээ гэвэл нүдний халдварт өвчинг сохролоос сэргийлж антибиотикаар эмчлэх, уяман өвчнийг цааш газар авахаас сэргийлж олон эмийн эмчилгээ хийх, яс хугаралыг зөв анагааж, үенд ямар нэгэн гажиг үүсгэхээс урьдчилан сэргийлэх зэрэг орж болно. Хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хүмүүсийн хоёрдогч урьдчилан сэргийлэх стратегийн талаар Эмнэлгийн тусламжийн хэсэгт ярилцах болно.
- Гуравдагч урьдчилан сэргийлэлт нь эмгэг согог, эсвэл аль хэдий үүссэн эрүүл мэндийн нөхцөл байдлын үр дагаварыг хязгаарлах эсвэл хөрвүүлэхэд оршино. Үүнд үйл ажиллагааны хязгаарлалтаас сэргийлж, бие даахад нь дэмжлэг үзүүлж, тэднийг нийгмийн амьдралд оролцуулах зорилготой сэргээн засалтын үйлчилгээнүүд орно. Гуравдагч урьдчилан сэргийлэлтийн стратегийг Сэргээн засалт, Туслах хэрэгсэл хэсгүүд дээр ярилцах болно.

Урьдчилан сэргийлэлтийн 3 түвшин



## Жишээ 9 ЭНЭТХЭГ

### Анита дахин боссон нь

Анита бол Энэтхэгийн Махараштра мужийн Райгад дүүргийн уулархаг бүсэд орших Кандале тосгонд амьдардаг 50 настай эмэгтэй юм. Нэгэн өдөр Анита баруун хөлөндөө жижиг гэмтэл авчээ. Түүний хөлөнд өвчин маш хурдан тархаж хэдэн өдрийн дараа хар болж хувирав. Түүнийг хүү нь 15 км-ийн цаана байрлах Алибауг эмнэлэгт хүргэсэн ба тэндээс 100 км хол Мумбайн нарийн мэргэжлийн эмнэлэгт очихыг зөвлөжээ. Мумбайн эмнэлгийн ажилтан Анитаг чихрийн шижинтэйг шуурхай оношлон түүний баруун хөлийн өвдөгний доогуур тайрчээ. Хагалгааны дараагаар Анитагийн гэр бүл түүнийг хотод удаан байлгах боломжгүй тул яаралтай тосгондоо буцаан авчрав. Анита явж чадахгүй болсон тул хүү нь нуруундаа үүрэн явдаг байжээ.

Тосгоны эрүүл мэндийн ажилтан гар хөлөө алдсан хүмүүст үнэгүй эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг ХОТСЗ хөтөлбөрийн талаар Анита болон түүний гэр бүлд танилцуулжээ. Тосгонтой хамгийн ойр эрүүл мэндийн төвд байрлах ХОТСЗ хөтөлбөрийг сонирхон Анита очиж танилцав. Тэнд түүний хөл зөв эдгэрч байгаа эсэх болон зүүн хөлийг урьдчилан үзэж цусны эргэлт өөрчлөгдсөнтэй холбоотой ямар нэгэн асуудал байгаа эсэхийг үзжээ. Анита чихрийн шижингийн талаар сурч мэдэн эм, байнгын дасгал болон хоолны дэглэмээр хэрхэн нөхцөл байдлыг хянах талаар ойлголттой болж авав. Мөн түүнчлэн цаашид зүүн хөлөө алдахгүйн тулд хөлөө арчлах зохистой арга, урьдчилан сэргийлэх боломжийн талаар сурч авчээ. Анитад суга таяг өгч мөн хэрхэн ашиглах талаар зааж сургасан байна.

Түүний дараа эрүүл мэндийн мэргэжилтэнгүүдийн баг эрүүл мэндийн төвд зочилж, Анитад хиймэл хөл тааруулсан ба цаашид зүүн хөл нь гэмтэхээс урьдчилан сэргийлж сайхан гутал бас өгчээ. Түүнд хиймэл хөлтэй алхаж сурах хичээл орох ба ХОТСЗ хөтөлбөрийн ажилчид түүний гэрийн ойролцоо алхах дадлага хийлгэх зорилгоор зам засч бэлдэж өгчээ. Аажим аажмаар Анитагийн өөртөө итгэх итгэл өсч, хиймэл хөлтэйгээр бие даан алхаж явж суран эргэн ажил хийх боломжтой болжээ. Тэрээр байнгын эмнэлгийн үзлэг болон эм, эмчилгээ авсаар байна. Анита дурьдахдаа түүний амьдралын чанар сайжирсан ба ХОТСЗ хөтөлбөр болон бусдын тусламжтайгаар чихрийн шижингээс үүсэн гарсан цаашдын эрүүл мэндийн хүнд хэцүү нөхцөл байдлыг даван туулахад амжилт гаргаж чадсан гэжээ.

### **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд урьдчилан сэргийлэлт ямар утгатай вэ?**

Хүн бүрийн адилаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст урьдчилан сэргийлэх тусламж шаардлагатай байдаг эрсдлийн хүчин зүйлд өртөж болно. Жишээ нь дархлаажуулалт. Гэхдээ тэд эрүүл мэндийн хувьд эрсдэлд орох нь илүү амархан учир нарийн мэргэжлийн тусламж дэмжлэг шаардлагатай байдаг. Тухайлбал, ядуу нөхцөлд байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс аюулгүй ус, эрүүл ахуйн газрууд хүртээмж муутай байдаг. Энэ нь тэднийг эрүүл ахуйн хувьд цэвэр байх боломжгүй болгож тэднийг амьдралаа сайжруулах боломжийг сааруулж, эрүүл мэндийг нь эрсдэлд оруулж байдаг. Ийм тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулж тусгай газар эсвэл тохируулга хийх шаардлага гарч болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс мөн хоёрдогч хүндрэлд (эрүүл мэндийн анхдагч нөхцөл байдлаас үүдээд гарч болох эрүүл мэндийн асуудлууд) орох эрсдэлтэй байдаг. Тухайлбал, арьс цоорох, шээсний замын халдвар, үений хязгаарлалт, өвдөх, таргалах, яс сийрэгших, хямралд орох гэх мэт. Эдгээр хоёрдогч хүндрэлийн үед аль болох эрт арга хэмжээ авах шаардлагатай бөгөөд ихэнх тохиолдолд эдгээрээс сэргийлэх боломжтой байдаг. Тухайлбал, доод мөчний саажилттай хүмүүсийн арьсыг сайн арчилж арьс цооролтоос сэргийлж болно, мөн давсагийг сайн арчилснаар шээсний замын халдвар авахаас сэргийлж болно.

## **Жишээ 10** Вьетнам

### **Гэр бүлийн орчинг хүртээмжтэй болгох**

Handicap International байгууллага нь Вьетнамын Хо Ши Мин хотын сэргээн засах эмнэлэгт Нуруу Нугасны гэмтлийн тасгийг байгуулахад дэмжлэг үзүүлжээ. Энэ тасагт ажиллаж буй ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд нь эмнэлгээс гарсан өвчтнүүдийг хоёрдогч хүндрэлд орохоос урьдчилан сэргийлж, мөн түүний гэр тэргэнцэртэй явахад саадгүй эсэхийг хянах үүрэгтэй байдаг. ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд бүх өвчтнүүдийг хянахыг хичээдэг боловч хүний нөөцийн дутагдал, мөн хамрах хүрээ ихтэй байдгаас болж зөвхөн 25 хувийг нь л харж анхаарах боломжтой байдаг байна. Эмнэлгийн болон ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд өвчтнүүдийг ангилах шинэ системийг хэрэгжүүлэхээр шийдсэн – өндөр эрсдэлтэй хүмүүсийг гэрээр нь очих, харин эрсдэл багатай хүмүүстэй утсаар холбогдож, боловсрол олгох товхимолоор хангах болжээ. Үүний үр дүнд сэргээн засах эмнэлгийн өвчтнүүдийн дахин эмнэлэгт ирэх дараалал багасчээ. Мөн энэхүү санаачлагын үр дүнд илүү зардал багатай болж, ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнуудын ачаалал буурсан байна.

### **Хөгжлийн бэрхшээлгүй хүмүүсийн хувьд урьдчилан сэргийлэлт ямар утгатай вэ?**

Урьдчилан сэргийлэлт нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд чухал байсны нэгэн адил хөгжлийн бэрхшээлгүй хүмүүст ч чухал хэрэгтэй байдаг. Эмгэг, согог, хөгжлийн бэрхшээлээс үүдэн гарсан эрүүл мэндийн ихэнх нөхцөл байдлыг сэргийлэх боломжтой байдаг. Тухайлбал, насанд хүрсэн хүний бүх хэлбэрийн сохролын 80%-ийг сэргийлж болдог, эсвэл эмчилж болдог. Бүх хүүхдүүдийн сохролын хагасаас илүү хувийг эмчилгээ хийж, катаракт, глаукома гэх мэт төрөлхийн гажгийг засч сэргийлж болно. Дэлхийн Эрүүл мэндийн 58 дугаар ассамблейгаас гарсан Хөгжлийн бэрхшээл, түүнийг урьдчилан сэргийлэх, удирдах, сэргээн засах (WHA58.23) тогтоолд дурдсанаар Гишүүн орнууд хөгжлийн бэрхшээлийн талаарх асуудлаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлж, хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд бүх салбарыг оролцуулж, зохицуулалт хийхийг шаардсан байдаг.

Эрүүл мэндийн нөхцөл байдал, хөгжлийн бэрхшээлээс үүдэн гарсан эмгэг, согоогоос урьдчилан сэргийлэхэд анхаарлаа хандуулсан хөтөлбөр,



санаачлагуудыг дэмжихэд мэдрэмж шаардлагатай байдаг. Учир нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг урьдчилан сэргийлэх оролдого хийхэд тэдний ихэнх нь айдаг, эсвэл гомддог. Хөгжлийн бэрхшээлтэй холбоотой эрүүл мэндийн нөхцөл байдлыг бууруулахыг зорьсон урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийг сайжруулах, эсвэл хэвэнд нь байлгах арга хэмжээнүүдийн хооронд ямар нэгэн зөрчилгүй байх ёстой.


## Санал болгож буй үйл ажиллагаанууд

Урьдчилан сэргийлэлт нь эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа болон эмнэлгийн тусламжтай их холбоотой байдаг учир энэхүү гурван элементэнд дурдагдсан санал болгож буй үйл ажиллагаанууд хооронд давхардал байгааг санах нь чухал. Энд хамгийн гол анхаарлаа хандуулах хэсэг нь анхдагч урьдчилан сэргийлэлтийн ажиллагаа байх болно. Нийгмийн бүрэлдэхүүн хэсэг товхимол болон Нэмэлт товхимолд ХОТСЗ ба ХДХВ/ДОХ-н талаар дурдсан учир хүчирхийлэл, ХДХВ энэ хэсэгт хамрагдаагүй болно.

### Одоогийн урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдэд хамруул

Тухайн орон нутагт байгаа урьдчилан сэргийлэх үйл ажиллагаануудын талаар мэдээлэл цуглуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэдгээр хөтөлбөрүүдэд хамруулахад ХОТСЗ хөтөлбөр ажиллаж болно. ХОТСЗ хөтөлбөр нь дараах зүйлүүдийг хийж болно:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд тухайн орон нутагт байгаа урьдчилан сэргийлэх үйл ажиллагаануудын талаар мэдлэг олгохыг баталгаажуулах;
- Эрүүл мэндийн ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар мэдлэгтэй болох;
- Урьдчилан сэргийлэлтийн талаарх мэдээллүүдийг тохирох форматуудаар гаргаж, хүмүүсийн амьдардаг газарт аль болох ойр байршуулах;
- Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж буй газар бие махбодын хувьд хүртээмжтэй эсэхийг тодорхойл. Хэрэв хүртээмжгүй байвал түүнийг хүртээмжтэй болгох санаа, шийдвэрийг гаргах;
- Хүртээмжийн асуудлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй байвал урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг өөр сонголтот газарт, тухайлбал гэрт нь хийж болох талаар судлах.



## Жишээ 11 Кени

### Тэргэнцэртэй хүмүүсийн хэрэгцээг хангах

Кенийн Найроби дахь Корогочо хэсгийн төрийн бус байгууллагаас явуулдаг эрүүл мэндийн төвд тэргэнцэртэй хүн орж болохооргүй олон шаттай байжээ. Иймээс вакцинжуулалтанд хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүс (тархины саатай хүүхдүүд) хамрагдах боломжгүй байсан учраас эрүүл мэндийн ажилтнууд тухайн гэр бүлийг хотод байрлах сэргээн засах төв рүү явуулдаг байв. ХОТСЗ



хөтөлбөр уг асуудлыг шийдвэрлэхээр эрүүл мэндийн ажилтнуудтай уулзалт зохион байгуулж үүнийг шийдэх энгийн арга олсон ба уг эрүүл мэндийн төв хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн вакцинжуулалтыг нэг давхарт хийхээр зөвшилцжээ.

### **Эрүүл амьдралын хэв маяг, зан үйлийг дэмжих**

Тамхи татахгүй байх, архийг бага хэмжээгээр уух, эрүүл хоол идэх, дасгал хөдөлгөөн тогтмол хийх, бэлгийн хавьтлын үед бэлгэвч хэрэглэх гэх мэт эрүүл зан үйл нь эрүүл мэндийг асуудалд өртөх эрсдлийг бууруулдаг. Урьдчилан сэргийлэлтийн хөтөлбөр нь эрүүл зан үйлийг дэмжихийн тулд эрүүл мэндийг дэмжих стратегийг ашигладаг. Тухайлбал, урьдчилан сэргийлэх талаарх ойлголт нэмэгдүүлэх аян, хувь хүний боловсрол гэх мэт. Эрүүл зан үйлийг дэмжихид Эрүүл мэндийг дэмжих хэсгийн санал болгож буй үйл ажиллагаануудыг харна уу.

### **Дархлаажуулалтыг дэмжих**

Аль ч газарт тодорхой өвчнүүд болон өндөр эрсдэл бүхий бүлэгт зориулсан дархлаажуулалтын хөтөлбөр байдаг. Тухайлбал нярай болон бага насны хүүхдүүдэд хийдэг халдварт саа, дифтери, татран, улаан бурхны вакцин, мөн жирэмсэн эхэд хийдэг татрангийн вакцин гэх мэт. ХОТСЗ хөтөлбөр нь дараах зүйлүүдийг хийж болно:

- Бүх хүмүүсийг хамрах дархлаажуулалтыг дэмжиж ойлголт нэмэгдүүлэх аянд идэвхтэй оролцох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эмгэг согоогоос үл хамааран дархлаажуулах чухал шаардлагатай талаар эрүүл мэндийн анхан шатны тусламжийн ажилтнуудыг сургалтанд хамруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг вакцинжуулалтын хөтөлбөрт амьдарч байгаа газартаа хамрагдахыг баталгаажуулахын тулд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээтэй хамтарч ажиллах;
- Анхдагч урьдчилан сэргийлэлтийн үйл ажиллагаанд оролцуулна. Тухайлбал, эрүүл мэндийн өөр нөхцөл байдал үүсгэх эсвэл эмгэг согог үүсгэх эрсдлийг бууруулах зорилготой дархлаажуулалтын хөтөлбөр.
- ХОТСЗ хөтөлбөрт хамрагдаж байгаа хүмүүс (хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний ах, эгч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг жирэмсэн эх) санал болгосон дархлаажуулалтанд хамрагдсан эсэхийг баталгаажуулах;
- Санал болгосон дархлаажуулалтанд хамрагдаагүй хүмүүст дархлаажуулалтанд хамрагдахад аюулгүй талаар мэдээлэл олгож, шаардлагатай бол тэрхүү үйлчилгээнд хамрагдахад нь туслах;
- Вакцинжуулалтанд хамрагдаагүй хүмүүст (сургуульд сурдаггүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд) зориулж зохион байгуулах талаар эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээтэй хамтран ажиллах;

## Жишээ 12 Малайз

### Залуу хүний амьдралыг аварсан нь

Малайзийн үндэсний ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээ эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээг авахыг баталгаажуулахын тулд эрүүл мэндийн анхан шатны тусламжийн үйлчилгээтэй маш нягт хамтран ажилладаг. Энэ нь залуу эхчүүдэд хийдэг улаан эсэргэнийн вакцинжуулалт болон хүүхдийн дархлаажуулалтын хөтөлбөрийн эрүүл мэндийн анхан шатны ажилтан хариуцдаг.

### Зохистой хоолло

Хоол тэжээлийн дутагдал нь ихэвчлэн хангалттай хоол идэхгүй, идэх зуршил муугаас ихэнхдээ тохиолддог ба эрүүл мэндийн асуудлуудад хүргэх нийтлэг шалтгаан болдог. Тохиромжтой хоол хүнс хэрэглэхийг баталгаажуулах нь хөгжлийн салбаруудын хариуцах асуудал бөгөөд тэдгээртэй ХОТСЗ хөтөлбөр хамтарч ажиллах шаардлагатай. Эрүүл мэндийн салбартай холбогдуулан ХОТСЗ хөтөлбөр дараах ажлуудыг хийж болно:

- ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд хоол тэжээлийн дутагдалтай хүмүүсийг (хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй) илрүүлэх чадвартай байж, цаашдын зохих үнэлгээ, арга хэмжээ авахад нь эрүүл мэндийн ажилтнуудад илгээх чадварыг эзэмшсэн байхыг баталгаажуулах;
- Орон нутагт олдоцтой, хямд үнэтэй, төмрөөр баялаг, амин дэмээр баялаг хоол хүнс (бууцай, бөмбөрийн цохиурын навч, буудай, папаяа жимс гэх мэт) хэрэглэхийг дэмжих. Тэжээллэг хоолны жор нь хүмүүсийг тэжээллэг хоол идүүлэх бас нэг арга байдаг;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хангалттай, зохимжтой хоол идэхийг баталгаажуулах. Ихэнхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, ялангуяа хооллох бэрхшээлтэй хүүхдүүдэд тэжээллэг хоол өгдөггүй;
- Зажлах, залгих бэрхшээлтэй тархины саатай хүүхдүүд гэх мэт хооллох бэрхшээлтэй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг илрүүлж, боломжтой газар нь хэл засалчид илгээх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хоол идэх, уухад туслах аргуудыг гэр бүлийн гишүүдэд нь зааж өгөх. Тухайлбал, аюулгүй мөн амархан хооллоход зөв суулгах;
- Тухайн орон нутагт байгаа хоол тэжээлийн хөтөлбөрүүдийг олж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулахыг баталгаажуулах. Ийм хөтөлбөрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулж, өсөлт хөгжлийг нь хянах, шим тэжээлтэй хүнс эсвэл нэмэлт тэжээл өгөх;
- Хөхөөр хооллохыг хөхиүлэн дэмжиж, жирэмсэн эхчүүдийг төмөр, фолийн хүчилтэй нэмэлт тэжээл төрөхийн өмнө хэрэглэхийг хөхиүлэн дэмжих (Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламжинд хамруулах талаар үргэлжлүүлэн уншина уу).



## Жишээ 13 ЭНЭТХЭГ

### Хоол хүнсээр дамжуулан чийрэгжүүлэх нь

Энэтхэгийн Бангалорын Санживина Итгэл төв нь эмэгтэйчүүд болон хүүхдүүдтэй арав гаруй жил хамтран ажилласан. Тэдний гол үйл ажиллагаануудын нэг нь хүүхдүүдийн, ялангуяа таваас доош насны хүүхдүүдийн хоол тэжээлийн дутлын асуудлыг шийдвэрлэх юм. Ядуу буурай гэр бүлд харъяалагдах ихэнх хүүхдүүдийн хоол тэжээлийн дутагдал нь хөхний сүүнээс хагас хатуу хоолонд, дараа нь хатуу хоолонд шилжих үед байдаг ба энэ нь тохиромжтой хоол хүнс хэрэглээгүйгээс үүдэлтэй байдаг учир Санживина Итгэл төв нь сард нэг удаа хоолны дутагдалд орсон бүх хүүхдүүдэд илчлэг, уургаар баян шим тэжээлтэй нэмэлт бүтээгдэхүүнээр үйлчилдэг. Сайн дурын ажилтнуудыг нэмэлт бүтээгдэхүүн бэлдэхэд сургаж, шаардлагатай хүүхдүүдийг олж илрүүлж, тэдэнд олгодог. Ээжүүдэд хооллолтын талаар сургалт зохион байгуулж, орон нутгийн олдоц ихтэй буудай, хүнсний ногоо ашиглаж зардал багатай шим тэжээллэг хоол хүнс хэрхэн бэлдэхийг зааж өгдөг байна. Мөн Санживини нь хоол тэжээлийн нэмэлтээр хангах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сэргээн засах үйлчилгээгээр хангах бусад байгууллагуудтай хамтран ажилладаг. Тусгай хэрэгцээ шаардлагатай (хооллох талын асуудалтай) хүүхдүүд нэмэгдэл тэжээл байнга хэрэглэдэг ба үүнээс маш ихээр шим тэжээл авдаг.

Африин 9 настай тархины саатай охин юм. Тэрээр эцэг, эх, хоёр эгчийн хамт Бангалорын Иллиаснагарын ядуусын хороололд амьдардаг. Түүний эцэг, эх өдрийн 70 рупигийн цалинтайгаар орон нутгийн үйлдвэрт ажилладаг. Тэдний гэр бүл Африинийг 6 настай байхад Бангалорт нүүж иржээ. Африиний ээж хүндрэлтэй төрснөөс болж Африин тархины саатай болжээ. Түүнийг зөвхөн шингэн хоолоор хооллож байсан ба үүний үр дүнд хоолны дутагдал болон хэвтэрт орж, өсөлт буурч байнгын суулгаж, мөн татдаг байна. Африиний нөхцөл байдлаас болж ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд ямар нэгэн эмчилгээ хийж чадахгүй байсан тул түүнд зөвхөн нэмэлт тэжээл өгөв. Нэг жилийн дараа Африин эрүүл мэндийн хувьд эрс сайжирч чийрэгжсэн байна. Одоогоор Африин эмчилгээ болон сэргээх зорилгоор дасгалжуулалтын төвд явдаг ба түүний сайжирсанд гэр бүл нь сэтгэл хангалуун, баяртай байгаа ба түүнд ээж нь өөр төрлийн хоол өгөх боломжтой болж байна.

### Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламжинд хамруул

Төрөхийн өмнөх тусламж, төрөх үеийн чадварлаг тусламж, төрсний дараах тусламжууд нь эх, хүүхдийг хөгжлийн бэрхшээлд хүргэж болзошгүй эмгэг, согог, эрүүл мэндийн нөхцөл байдал үүсэх эрсдлийг бууруулдаг. ХОТСЗ хөтөлбөр нь дараах зүйлүүдийг хийх ёстой:

- Орон нутагт байгаа эхийн эрүүл мэндийн үйлчилгээг олж илрүүлэх. Тухайлбал, төрөхийн өмнөх тусламж;
- Бүх эмэгтэйчүүдэд эхийн эрүүл мэндийн үйлчилгээний талаар мэдээлэл олгож, түүнд хамрагдахыг баталгаажуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг эхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдахад нэмэлт тусламж дэмжлэг үзүүлэх. Тухайлбал, эрүүл мэндийн тусламжийн тогтолцоонд ялгаварлан гадуурхалт байгаа тохиолдолд нөлөөллийн ажил хийх;

- Эмэгтэйчүүд, тэдний гэр бүлийг удамшлын зөвлөгөө авахад нь (одоогийн болон дараах жирэмслэлттэй холбоотой асуултууд асуух гэх мэт) зуучлах. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй хос дараа дахин хүүхэдтэй болбол тэр нь удамшиж дахин ийм бэрхшээлтэй хүүхэдтэй болох эсэх талаар асуухыг хүсч болно;
- Хөгжлийн бэрхшээлтэй жирэмсэн эмэгтэйчүүдэд үйлчлэх талаар эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөгөө өгөх. Тухайлбал, тэдэнтэй харилцах харилцааны аргуудыг санал болгох, эмнэлэг/төрөх өрөөг хүртээмжтэй болгох гэх мэт;
- Тухайн орон нутагт байгаа гэрээр эх баригч нарт зориулсан сургалтын хөтөлбөр байгаа эсэхийг тодруулах, тэдгээр сургалтын хөтөлбөр хөгжлийн бэрхшээлийн талаар болон эмгэг согогийг эрт таних талаар орсон эсэхийг баталгаажуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ төрмөгц орон нутгийн байгууллагад бүртгүүлэхийг баталгаажуулах.

## Жишээ 14 Монгол

### Жирэмслэлтийн үеийн хямралыг давах

Монголын баруун хойд хэсгийн зарим тосгонд олон эмэгтэйчүүд түнхний мултралтай байдаг байна. Эдгээр эмэгтэйчүүд жирэмсэн үедээ жин нэмсэнээр тэдний түнхэнд нэмэлт ачаалал үүсч өвдөлтийг улам нэмэгдүүлдэг. Монголын үндэсний ХОТСЗ хөтөлбөр эдгээр эмэгтэйчүүдтэй хамтран ажиллаж, жирэмслэлт хоорондын хугацааны талаар болон жирэмсний сүүлийн шатанд сайн амарч байхыг зөвлөдөг.

### Цэвэр ус, эрүүл ахуйг хөхиүлэн дэмж

Ус, эрүүл ахуй нь эрүүл амьдрах нөхцөлийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлийг бууруулахад хувь нэмрээ оруулдаг. ХОТСЗ хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг хангахад дараах зүйлүүдийг хийж, баталгаажуулахад тусалж чадна:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдтэй ус түгээх болон эрүүл ахуйн газрыг ашиглахад тулгарч байгаа бэрхшээлийн тухай ярилцах. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хол амьдардаг, орчин газар нь явахад дэндүү хэцүү эсвэл худгаас ус авах арга нь хэтэрхий хэцүү байдаг тул тэд ус авч чаддаггүй;
- Эдгээр тулгарч байгаа бэрхшээлээ орон нутгийн удирдлагууд болон ус, эрүүл ахуйн байгууллагуудад мэдээлж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдтэй хамтарч тулгарч байгаа бэрхшээлийг хэрхэн даван туулах талаарх арга замуудыг санал болгох;
- Одоо байгаа газруудад тохируулга хийх, эсвэл шинэ байгууламж барихад нь орон нутгийн удирдлагуудтай хамтарч ажиллах. Тухайлбал, намхан суултууртай жорлон дээр сууж чаддаггүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслаж жорлонгийн суудлыг суух түвшинд байрлуулж, бариултай болгох;
- Шаардлагатай газарт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусалж дэмжихийг хамт олны гишүүдэд ойлгуулах. Тухайлбал, усанд явахад нь хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй хамт явах.



## **Осол, гэмтлээс урьдчилан сэргийлэхэд тусал**

Маш олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэртээ, ажил дээрээ, хамт олон дотроо осол гэмтэлд өртдөг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрсэн хүмүүс гэмтэх өндөр эрсдэлтэй байдаг. ХОТСЗ хөтөлбөр нь осол гэмтлээс урьдчилан сэргийлэхэд дараах үүрэгтэй:

- Хамт олон болон гэртээ гэмтэж байгаа гол шалтгаануудыг (түлэгдэх, живэх, авто замын осол гэх мэт) олж, өндөр эрсдэл байгаа бүлгийг (тухайлбал хүүхэд) тодорхойлох;
- Осол гэмтлийн нийтлэг шалтгаан, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар ойлголт нэмэгдүүлэх. Үүнд эрүүл мэндийг дэмжих аяныг хамруулж болно (Эрүүл мэндийг дэмжих элементийг харна уу);
- Хамт олон болон гэрт гарч болох осол гэмтлийг багасгахын тулд орон нутгийн эрх бүхий байгууллагууд, хамт олны бүлгүүдтэй хамтран ажиллах. Тухайлбал том баяр наадмын үеэр осол гэмтлээс урьдчилан сэргийлэх;
- Орон гэртээ осол гэмтлээс хэрхэн сэргийлэх талаар гэр бүлийн гишүүдэд санал тавих. Тухайлбал, хүүхдийг усны хажууд эсвэл ил галын дэргэд байлгахгүй сайн харах, хортой бодисыг цоожлох, эсвэл хүүхдээс хол байлгах, тагт, дээвэр, шатнаас хүүхдийг хол байлгах, хурц үзүүртэй юмаар тоглуулахгүй байх гэх мэт;
- Ажлын байран дээр осол гэмтлээс хэрхэн сэргийлэх талаар ажилтнуудад боловсрол олгох. Тухайлбал, барилга дээр ажиллаж байгаа хүмүүс аюулгүй байдлыг хангасан хэрэгсэл хэрэглэх (гутал, дуулга, бээлий, чихэвч гэх мэт);
- Сургуулийн хүүхдүүдэд зам хөндлөн хэрхэн аюулгүй гарах, машин дотор суудлын бүсээ зүүх, дугуй эсвэл мотоцикль унахдаа дуулга өмсөх гэх мэт боловсролыг олгох.

## **Хоёрдогч хүндрэлээс урьдчилан сэргийлэхэд тусал**

Хөгжлийн бэрхшээлтэй бүх насныхан хоёрдогч хүндрэлд өртөх эрсдэлтэй байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энэхүү хүндрэлд орох эрсдлийг бууруулах анхдагч урьдчилан сэргийлэлтийн стратегиудыг ХОТСЗ хөтөлбөр дэмжинэ:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй нийтлэг тохиолддог хоёрдогч хүндрэлийн талаар мэдлэгтэй болох. Тухайлбал, нуруу нугасны гэмтэлтэй эсвэл нугасны ивэрхийтэй хүмүүс (гэр бүл)-т шээсний замын халдвар үүсэх өндөр эрсдэлтэй талаараа тэд мэддэг байх ёстой;
- Хоёрдогч хүндрэл үүсэхээс урьдчилан сэргийлэх стратегийг илрүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд туслах. Үүнд дасгал хөдөлгөөн хийх, сайн тэжээллэг хоол хүнс хэрэглэх гэх мэт эрүүл амьдралын зан үйлтэй болох, эрүүл мэндээ байнга шалгуулж байх, эрүүл ахуйг сайн сахих, өөрөө өөртөө туслах бүлэгт элсэн орох гэх мэт үйл ажиллагаанууд байж болно;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэглэж байгаа туслах хэрэгслүүд хоёрдогч хүндрэлийг үүсгэхгүй байхыг баталгаажуулах. Өөрөөр хэлбэр хиймэл үе (протез) сайн тохирсон, хэсэг газарт улайлт өгч, арьс цоорохгүй байх ёстой.



# Эмнэлгийн тусламж

## Танилцуулга

Эмнэлгийн тусламжийг эмгэг согогоос үүссэн эсвэр эрүүл мэндийн нөхцөл байдлыг илрүүлэх, үнэлэх, эмчлэх гэж тодорхойлж болно. Эмнэлгийн тусламж нь анагааж (уяман, хумхааг эмчлэх), үр нөлөөг бууруулж (уналт таталтыг эмчлэх), сэргийлж болох эмгэг согогоос сэргийлж (чихрийн шижинг сохрол явагдахаас сэргийлж эмлэх) чадна. Чанартай эмнэлгийн тусламж авах нь хүний, ялангуяа эрүүл мэндийн түвшин нь муу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэнд болон функц (үйлдэл)-ийг хэвийн хэмжээнд байлгахад маш чухал юм.

Өмнөх үг дээр бид Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын Конвенцийн 25 дугаар зүйлийг дурдсан билээ. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрүүл мэндийн үйлчилгээг үнэ төлбөргүй, эсвэл боломжийн үнэтэй эрүүл мэндийн тусламж, хөтөлбөрийг бусдын нэгэн адил чанар, стандартаар хангах, тэднийг эрт илрүүлэх, тохирох арга хэмжээг авч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шаардлагатай эрүүл мэндийн үйлчилгээгээр хангах, мөн үйлчилгээг тэдний амьдарч байгаа газар аль болох ойр үзүүлэх үүргийг хүлээнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох стандарт дүрэмд эмнэлгийн тусламжийн талаар Улс орнуудын хүлээх хариуцлагыг дурдсан бөгөөд эмнэлгийн тусламж нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг амьдралын бүхий л хэсэгт идэвхтэй оролцох урьдчилсан нөхцөл болно гэдгийг онцлон тэмдэглэсэн байдаг.

Конвенц болон Стандарт дүрмийн удирдамжаар ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эмнэлгийн тусламжинд цаг тухайд нь, тохирох үйлчилгээнд хамруулахад баталгаажуулж ажиллана.





### Аднанд гарсан том өөрчлөлт

Ирен болон Мохамед Танзанийн нэгдсэн улсад амьдардаг. Аднаныг төрөхөд тэд маш их баярласан учир нь тэдний өмнөх хүүхэд аль хэдийн зургаан нас хүрсэн болохоор энэ хүүхдийн маш удаан хүлээсэн байсан юм. Аднаныг ойролцоогоор 2 настай байхад түүний толгойн хэмжээ арай жижиг байгааг тэд анзаарсан байна. Ирен, Мохамед 2 орон нутгийн эмнэлгээс Аднанд зориулж эрүүл мэндийн тусламж авсан. Рентген шинжилгээний дараа эмч нар Ирен болон Мохамедад хандаж хүүхдэд санаа зовох зүйл байхгүй гэдгийг хэлжээ. Гэсэн хэдий ч Аднан өсөж байгаа хэрнээ хялбар үйл ажиллагааг гүйцэтгэж, энгийн зааврыг биелүүлж чадахгүй мөн өдрөөс өдөрт зан нь улам хэцүү болж байв. Түүнчлэн тогтмол татаж унах болов. Ирений хэлж байгаагаар “Тэр хэзээ ч ярьж эсвэл дуу авиа гаргаж байгаагүй тул би түүнийг юмсыг ойлгож байна гэж боддоггүй байсан бас би түүнтэй хэзээ ч ярилцаж байгаагүй. Учир нь юунд байгаа юм бол? Гэвч түүний зан байдал улам муудсаар байна.”

Тэр дөрвөн настайдаа л алхаж эхэлсэн бөгөөд нэг өдөр түүнийг гудамжинд тоглож байхад хажуугаар нь өнгөрч явсан хүн түүнийг оюуны бэрхшээлтэйг анзаарч Ирен болон Мохамедэд Танзанийн Хамт Олонд Түшиглэн Сэргээн засах цогц үйлчилгээ хэмээх төрийн бус байгууллага нь ХОТСЗ хөтөлбөрийг хэрэгжүүлдэг талаар хэлсэн байна. Аднаны эцэг эх ХОТСЗ үйлчилгээ байгууллагатай холбогдон зөвлөгөө болон дэмжлэг авахыг хүсчээ. ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан Мама Китенж тэдний гэрээр очиж боловсрол болон эмчилгээг үзүүлж эхэлсэн байна. Мөн тэдний гэр бүлд хүүгийн уналт таталтын үед авах эрүүл мэндийн тусламжын авахад тусалжээ. Ингэснээр Аднан эпипсиг хяналтандаа байлгах эмийн эмчилгээг авч эхэлсэн байна.

Ирен хэлэхдээ “Бид хөтөлбөрт хамрагдахаас өмнө Аднан өөрөө бие даан юу ч хийж чадахгүй байсан. Тэр өөрөө идэж, хувцаслаж мөн гараа угааж ч чаддаггүй байсан. Тэр аз жаргалгүй байсан. Тэр өдөржингөө гадуур алхаж байнга төөрдөг байсан. Би түүнд юу яаж туслахаа мэдэх ээ больсон. Түүнд энэ заавар, зөвлөгөөнүүд үнэхээр тусалсан. Одоо би түүнтэй үргэлж ярьдаг, тэр ойлгодог болсон. Хүү маань одоо өөрөө ус ууж, хоолоо идэж бас нүүрээ угааж чаддаг болсон. Би түүнд ус авдаг цэгээс буцаж гэртээ харьдаг замыг маш олон удаа зааж өгсний эцэст тэр одоо төрсөн үед гэрээ олдог болсон. Эпилепсийн эмээ тогтмол ууж байгаа учих унаж татахаа больсон. Бид маш том өөрчлөлтийг гаргаж чадсан.



## Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрийн хэрэгцээн дээр тулгуурлаж ерөнхий болон нарийн мэргэшлийн эмнэлгийн тусламж авахад оршино.

## ХОТСЗ-ын үүрэг

ХОТСЗ хөтөлбөрийн үүрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрүүл мэндийн нөхцөл байдал болон эмгэг согоого илрүүлэх, сэргийлэх, засах зэрэг эмнэлгийн үйлчилгээнүүдийг авахыг баталгаажуулахын тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдтэй хамтран ажиллахад оршино.

## Хүсч буй үр дүн

- ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг ерөнхий болон нарийн мэргэшлийн эмнэлгийн тусламжийг тэдний хэрэгцээгээр нь илгээх чадвартай болон эмнэлгийн тусламжийн талаар мэдлэгтэй болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд эрүүл мэндийн нөхцөл байдал болон эмгэг согоогийг эрт илрүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаанд (үзлэг, оношлогоо) хамрагддаг болно.
- Эмнэлгийн тусламж үзүүлдэг газар нь бүгдийг хамардаг, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эмгэг согоого засах, эсвэл багасгах мэс заслын тусламж үйлчилгээ авдаг байна. Энэ нь тэдний эрүүл мэнд эсвэл функц (үйлдэл)-ийг сайжруулахад хувь нэмрээ оруулна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд өөрсдийнхөө эрүүл мэндийн талаар болон эмнэлгийн тусламжийн талаар асуулт асуух, эмчилгээний сонголтуудын талаар ярилцах, мэдээлэлтэйгээр шийдвэр гаргах гэх зэрэг чадваруудыг эзэмшсэн байна.
- Эмнэлгийн тусламжийн ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эмнэлгийн хэрэгцээ, тэдний эрх, эрхэм зэргийг хүндэтгэж, чанартай үйлчилгээг хүргэх талаарх ойлголт нэмэгдэнэ.

## Гол ойлголтууд

### Эмнэлгийн тусламжийн төрөл

Хөгжиж байгаа орнуудын ихэнхийнх нь эрүүл мэндийн тогтолцоо нь эрүүл мэндийн тусламжийн гурван түвшинтэй байдаг: анхан, хоёрдогч болон гуравдагч. Эдгээр нь ихэвчлэн нэгээс нөгөөд илгээх тогтолцоогоор хоорондоо холбоотой байдаг. Тухайлбал, эрүүл мэндийн анхан шатны тусламжийн ажилтан шаардлагатай тохиолдолд хүнээ хоёрдогч шатлалд илгээдэг. Түвшин бүрт давхардал (эрүүл мэндийн анхан шатны тусламжийг ихэнхдээ хоёрдогч шатны эрүүл мэндийн тусламж үзүүлдэг газарт үзүүлдэг) байдаг учраас ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан түвшин тус бүрийн ялгааг ерөнхийд нь мэддэг байх шаардлагатай. Тэгж байж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг чиглүүлж өгнө.

**Анхан шатны тусламж** нь хамт олны түвшинд эрүүл мэндийн үндсэн тусламж үзүүлдэг шатлал юм. Үйлчилгээг ихэнхдээ эрүүл мэндийн төвөөр эсвэл клиникээр дамжуулж үзүүлдэг бөгөөд энэ нь эрүүл мэндийн тогтолцоонд холбоо тогтоодог анхны цэг нь байдаг. Анхан шатны түвшинд үзүүлж буй эмнэлгийн тусламж нь хурц өвчний (халдвар) үед, мөн архаг өвчний (уяман, уналт таталт, сүрьеэ, чихрийн шижин гэх мэт) үед богино хугацаатай, энгийн эмчилгээ хийдэг. ХОТСЗ хөтөлбөр нь хамт олны түвшинд ажилладаг учраас эрүүл мэндийн анхан шатны тусламжийн үйлчилгээтэй хамтарч ажиллах хэрэгтэй.

**Хоёрдогч шатны тусламж** нь ихэнхдээ дүүргийн түвшинд, илүү том эмнэлэг, клиникт үзүүлдэг нарийн мэргэшлийн эмнэлгийн үйлчилгээ байдаг. Эрүүл мэндийн анхан шатны тусламж нь илгээх механизмаараа дамжуулан хоёрдогч шатлалтай холбох чухал үүрэгтэй байдаг.

**Гуравдагч шатны тусламж** нь илүү өндөр түвшинд мэргэшсэн эмнэлгийн тусламж юм. Энд нарийн мэргэшлийн технологи ашиглан, нарийн мэргэшлийн мэргэжилтнүүд, сувилагч, эмнэлгийн дунд түвшний ажилтнууд тусламж үйлчилгээг үзүүлдэг. Үйлчилгээг үндэсний эсвэл бүсийн түвшинд байдаг том эмнэлгүүдээр дамжуулан үзүүлдэг. Гуравдагч шатлалд үзүүлдэг эмнэлгийн тусламж нь тархины мэс засал, хавдрын эмчилгээ, согог засах ортопед мэс засал гэх мэт хамрагдана.

### **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эмнэлгийн тусламж**

Эмнэлгийн ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлдэг төв дээр эмчлэхээсээ илүүтэй ерөнхий эмнэлгийн тусламжийн сэргээн засах үйлчилгээнд ихэнхдээ илгээдэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад хүмүүсийн нэгэн адил эрүүл мэндийн анхан шатны тусламж, эмнэлгийн тусламж авах шаардлагатай байдаг талаарх тэдний мэдлэг дутмаг байгаагийн илрэл юм. Тухайлбал, амьсгалын замын халдвар, ханиад томуу, цусны даралт ихсэх, дунд чихний үрэвсэл, чихрийн шижин, сүрьеэ, хумхаа гэх мэт өвчний үед эмнэлгийн тусламж шаардлагатай.

Эрүүл мэндийн тусламжийн ажилтнууд эмгэг согогт хүргэдэг нөхцөл байдлуудыг эрт илрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэдний эрүүл мэндийн бүх нөхцөл байдлыг илрүүлж, эрт эмчлэх нь (хоёрдогч урьдчилан сэргийлэлт) чухал. Эрүүл мэндийн зарим нөхцөл байдлуудыг эмчлэлгүй, хяналтгүй орхивол шинэ эмгэг согог үүсч, эсвэл одоо байгаа эмгэг согогийг илүү дордуулж болно. Эрт арга хэмжээ авах нь гэмтэл багатай, зардал бага, илүү үр дүнтэй байдаг.

Ихэнх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эмнэлгийн тусламжийн тусгай хэрэгцээ хязгаарлагдмал хугацаанд эсвэл тэдний амьдралын туршид хэрэгтэй болж болно. Тухайлбал, уналт таталттай хүмүүс эсвэл сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүст удаан хугацааны туршид эм уух шаардлага гарна. Зарим хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэдний согогийг засах мэс засал шаардлагатай болж болно.

## Жишээ 16 Унадаг өвчин

Унадаг өвчин (таталт) нь мэдрэлийн системийн архаг хямрал ба энэ нь ихэвчлэн хөгжлийн бэрхшээлд хүргэдэг, ялагуяа хөгжлийн бүсэд энэ нь тохиолддог. Унадаг өвчтэй иргэд болон тэдний гэр бүл буруу ойлголт, ялгаварлан гадуурхагдахаас болж шаналдаг байна. Татаж унах өвчин болон түүнд тохирох эмчилгээтэй холбоотой олон ташаа ойлголт, цуу ярих байдаг. Хөгжингүй болон буурай хөгжилтэй орнуудад хийсэн сүүлийн үеийн судалгаагаар шинээр оношлогдсон татах өвчтэй хүүхэд болон насанд хүрэгчдийн 70 хүртэлх хувийг татах өвчний эсрэг эмийн тусламжтайгаар бүрэн анагаах (тэдний татаж унахыг бүрэн хянах) боломжтойг харуулжээ. 2 – 5 жилийн амжилттай эмчилгээний дараагаар, ойролцоогоор хүүхдүүдийн 70%, насанд хүрэгчдийн 60% нь өвчинг дахиулахгүйгээр эм уун таталтыг зогсоох боломжтой. Гэсэн хэдий ч буурай хөгжилтэй орны татах өвчтэй иргэдийн  $\frac{3}{4}$  нь өөрт шаардлагатай эмчилгээг авч чаддаггүй байна.

### Мэс засал

Мэс засал нь эмнэлгийн тусламжийн нэг хэсэг ба ихэвчлэн хоёрдогч эсвэл гуравдагч шатны эмнэлгийн тусламжийн системд явагддаг. Зарим төрлийн мэс засал нь эмгэг согогийг засч, сэргийлж, мөн эмгэг согогтой хавсарч гарч ирдэг гажиг, хүндрэлийг хязгаарладаг. Мэс заслын жишээнд харааны бэрхшээлд оруулдаг катарактыг авах, хугарал, нурууны гажиг зэргийг засах ортопед мэс засал, уруул тагнайн цоорхой, түлэгдэлт, эсвэл уяманд нөхөн сэргээх мэс засал орно.

Мэс засал хийхээс өмнө анхаарах хэд хэдэн зүйл байдаг. Гэр бүлийн хүмүүс нь мэс заслын талаар ойлголт бага, хязгаарлагдмал мэдлэгтэй байж магадгүй тул мэс заслын ашиг тус болоод үр дагаврын талаар зохистой мэдээллийг өгөх хэрэгтэй. Мэс заслын үйлчилгээ нь ихэвчлэн өндөр үнэтэй байдаг ба нийгмийн халамж эсвэл эрүүл мэндийн даатгалгүйгээр ядуу иргэдийн хувьд хүртэх боломж хэцүү байдаг. Мэс заслыг амжилттай болгоход мэс заслын дараах эмнэлгийн тусламж, эмчилгээ, туслах хэрэгсэл гэх мэт иж бүрэн үйлчилгээ шаардлагатай байдаг. Эмнэлгийн болон сэргээн засалтын мэргэжилтнүүд хоорондын ойрхон холбоо шаардлагатай байдаг. Мэс засал эмгэг согог болон хөгжлийн бэрхшээлтэй холбогдолтой бүх асуудлуудыг шийдэж чадахгүй гэдгийг үргэлж санаж байх нь чухал.

## Жишээ 17 Кени

### Боломж бололцооны тухай сурах нь

Кенийн Киеножо дүүрэгт 1987 онд Патрик майга тавхайтай төржээ. Түүний дүү охин Сара мөн майга тавхайтай төрөв. Патрикийн хэлснээр тэрээр 17 нас хүртлээ буюу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг Камвенжи хот руу явах зарлалыг радиогоор сонсох хүртлээ хөгжлийн бэрхшээлтэй байв. “Энэ бүх жилүүдэд үе тэнгийнхэн дундаа би үргэлж тусгаарлагдмал байсан. Радиогоор зарлал сонссоны дараа би маш их эргэлзэж байв. Миний хөлөнд ямар нэгэн зүйл хийж болох эсэхэд би итгэлгүй байсан. Гэвч эцэст нь би Камвенжи Оутрич Төв рүү явсан. Тэнд өөр бусад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байгааг олж мэдсэн. Өөр олон хүмүүс надтай ижил зүйлийг мэдэрч байсныг би хэзээ ч мэддэггүй байсан юм. Хоёр хагалгааны дараа миний хөл засарч мөрөөдөл байсан энгийн гутлыг одоо өмсөх болсондоо хязгааргүй баяртай байлаа. Алхаж явах нь өмнөхөөс илүү хялбар болсон. 14 настай миний бага дүү мөн адил хагалгаанд орсон юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд эмнэлгийн болон сэргээн засах үйлчилгээг авах нь боломжтой гэдгийг олон нийт мэдэж байх нь хамгийн чухал зүйл. Манай хэсгийн хүмүүс эдгээр үйлчилгээний талаар мэдлэг мэдээлэлгүй байсан. Сара бид хоёр энэ төрлийн үйлчилгээний талаар гэр бүл, найз нөхөд болон олон нийтэд хүргэхийн тулд байдаг чадлаараа хичээж байгаа. Бид бусад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамт нийгмийн нэг хэсэг байж сургууль, сүм болоод бусад бүлгийн энгийн үйл ажиллагаанд оролцохыг хүсч байна. Миний дүү бид хоёр уг үйл ажиллагааг явуулснаас хойш, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд өөрсдийн алдсан итгэл найдвараа эргэж олж авах боломж бий гэдэгт олон хүмүүс одоо итгэж байгаа.”

### Өөрийгөө хянах ба удирдах

Өөрийгөө удирдан хянах (өөрийгөө арчлах) гэдэг нь эмнэлгийн оролцоогүйгээр өөрийн эрүүл мэндийг хянах гэсэн үг биш юм. Өөрийгөө удирдах гэдэг нь хүмүүс өөрийнхөө эрүүл мэндийг хянана гэсэн үг – тэд өөрийнхөө эрүүл мэндийг сайжруулах, эсвэл хэвийн хэмжээнд нь байлгахын тулд асаргааны төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож, мөн эмнэлгийн тусламжийн талаар мэдээлэл авсны үндсэн дээр сонголтоо хийж, шийдвэр гаргах хариуцлагаа хүлээдэг. Эрүүл мэндийн сайн үр дүнд хүрэхийн тулд эрүүл мэндийн ажилтан, хувь хүнтэй сайн харилцаатай байх ёстой. Өөрийгөө арчилж байгаа хүн:

- Эрүүл мэндийн ажилтантай тогтмол, үр дүнтэй харилцах;
- Шийдвэр гаргах ба асаргааны төлөвлөгөөнд оролцох;
- Эрүүл мэндийн мэдээллийг авах хүсэлт гаргах, хүлээн авах ба түүнийг ойлгох;
- Эрүүл мэндийн ажилтны гаргасан эмчилгээний дэглэмийг дагах;
- Эрүүл мэндийн ажилтантай зөвшилцсөний дагуу өөрийгөө арчлахад тохирсон үйл ажиллагааг явуулах.

Өөрийгөө удирдах арга нь доод мөчний саатай эсвэл чихрийн шижин зэрэг архаг өвчтэй, амьдралынхаа туршид хөгжлийн бэрхшээлтэй байх хүмүүсийн хувьд нэн чухал юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүл өөрийгөө удирдаж чадаж байвал эрүүл мэндийн ажилтан оролцох шаардлагагүй. Гэхдээ тухайн хүн өөрийн эрүүл мэндийг удирдах тал дээр мэдлэг чадвар дутмаг байж болно.



Өөрөө өөртөө туслах бүлэг нь өөрсдийн мэдлэг чадварыг бусадтайгаа хуваалцах замаар өөрийгөө удирдах аргад суралцах гайхалтай боломжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгодог байна. Эмнэлгийн тусламжийн системтэй хэрхэн үр дүнтэй ажиллах болон одоогийн эрүүл мэндийн нөхцлөө хэрхэн удирдах зэрэг үнэ цэнэтэй мэдээллийг эмнэлгийн тусламж үйлчилгээний боломжит эх үүсвэрээс олж мэддэг.

## Жишээ 18 Эль Салвадор

### Тооны хүч

Раул Фолерогийн анд нөхдийн холбоо (АИФО) Италийн нийгэмлэг нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Хөгжлийн Бэрхшээл ба Сэргээн Засах баг болон Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Олон Улсын Байгууллагатай хамтран хэд хэдэн улс оронд судалгаа явуулсан ба энэ нь эмнэлгийн ижил тусламж шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамтран баг болсон үед тэдний өөрсдийн эмнэлгийн үйлчилгээг сайжруулах тал дээр илүү идэвхтэй үүрэг оролцоотой байх болон өөрсдийгөө удирдах чадвартай болж чадах эсэхийг тодорхойлох зорилготой байв. Туршилтын төслийн зорилго нь: ижил эмнэлгийн тусламж хэрэгцээ шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг олж мэдэх; эмнэлгийн үйлчилгээний гол хэрэгцээг тодорхойлох; эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаатайгаар тодорхойлсон шаардлагыг тусгахын тулд өөрсдийгөө халамжлах чадвар болон мэдлэгээр хангах; хөгжлийн бэрхшээлтэй иргэд/эсвэл гэр бүлийн гишүүдээр өөрсдийгөө халамжлах ба эмнэлгийн тусламж сайжирсан үед үнэлгээ хийх; хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чадвар ба мэдлэг танигдсан болоод эмнэлгийн үйлчилгээний системд ямар нэгэн үүрэг гүйцэтгэсэн бол түүнийг тодорхойлох.

Эль Салвадор дахь туршилтын төсөл нь нуруу нугасны гэмтэл дээр төвлөрөн ажилласан. АИФО нь Дон Боско Их сургууль ба Салвадорын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн институттай хамтран Эль Салвадор болон Тонакатепекийн тосгоны нуруу нугасны гэмтэлтэй иргэд болон тэдний гэр бүлээс бүрдэх 30 хүмүүстэй ажиллав. Өөрөө өөртөө туслах дөрвөн бүлэг байгуулсан ба олон удаагийн уулзалт зохион байгуулсан. Бүлгийн гишүүдийн эрүүл мэндийн гол хэрэгцээгээр нь сонгон авсан. Үүнд: шээс, давсаг ба бөөрний асуудал, арьс цоорох, үе мөчний хөшингө болон бэлгийн амьдрал, эцэг эх байхтай холбоотой асуудлууд. Эдгээр асуудлыг шийдэхийн тулд төсөл дээр ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтнүүд нь өөрийгөө хянаж удирдах чадвар олгох сургалтыг зохион байгуулсан. Аажмаар өөрөө өөртөө туслах бүлгийн гишүүд болон эмнэлгийн мэргэжилтнүүд нь сэтгэлгээгээ өөрчлөхийн тулд уг сургалтанд хамрагдах болсон. Зөв дэмжлэг, сургалтын ачаар нуруу нугасны гэмтэлтэй хүмүүс эрүүл мэндээ хянаж, амьдралын чанараа дээшлүүлэх чадвартай болсон. Тэдний үзэж байгаагаар эмнэлгийн ажилтнууд нь эмнэлгийн уламжлалт үүрэг хариуцлагаа эргэн харж нэгдмэл хариуцлагын зарчим болох өөрийгөө удирдах/өөрийгөө халамжлах аргыг чиглүүлж урамшуулах хэрэгтэй. Хэсэг хугацааны дараа өөрөө өөртөө туслах бүлгийн гишүүд болон эрүүл мэндийн мэргэжилтнүүд тэдний бодлыг өөрчлөх эхлэлийг төсөлд оруулав. Тохирох дэмжлэг болон сургалтын ачаар нуруу нугасны гэмтэлтэй иргэд өөрсдийн эрүүл мэндийг удирдан хянаж, амьдралын илүү сайн түвшинд хүрэх боломжтойг тэд ойлгов. Мөн түүнчлэн эрүүл мэндийн мэргэжилтнүүд



уламжлалт эмнэлгийн үүргийг биелүүлэхээс гадна өөрсдийгөө удирдах хянах боломжоор хангах – хамтын хариуцлагын ойлголтыг нэвтрүүлэх шаардлагатайг олж мэдсэн. Өөрөө өөртөө туслах бүлгийн гишүүд ALMES (Asociacion de Personas con Lesion Medular de El Salvador) нэртэй нийгэмлэгээ байгуулахаар болжээ.

## Санал болгож буй үйл ажиллагаанууд

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эмнэлгийн тусламжийг илүү хүртээмжтэй болгоход ХОТСЗ хөтөлбөр нь дараах үйл ажиллагаа явуулах боломжтой.

### Эмнэлгийн үйлчилгээний талаар мэдээлэл цуглуулах

Эрүүл мэндийн системийн анхдагч, хоёрдогч, гуравдагч түвшний эмнэлгийн үйлчилгээний талаар мэдлэгтэй байх нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд ба тэдний гэр бүлийнхэнд эмнэлгийн тусламж авахад чухал байдаг. ХОТСЗ хөтөлбөр нь доорх ажлыг гүйцэтгэх боломжтой:

- Орон нутаг, дүүрэг ба үндэсний хэмжээнд ажиллаж буй улсын, хувийн ба төрийн бус байгууллагаас үзүүлж буй эмнэлгийн үйлчилгээ, мөн уламжлалт анагаах ухааны үйлчилгээ үзүүлэгчдийг олж мэдэх;
- Үйлчилгээ үзүүлэгч нартай холбоо тогтоож эмнэлгийн тусламжийн төрөл, хүртээмж, үнэ төлбөр, хуваарь болон илгээх зарчмын талаар мэдээлэл цуглуулах;
- Үйлчилгээний лавлагааг нэгтгэж, ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд, хувь хүн, хамт олонд хүртээмжтэй болгохыг баталгаажуулах – үйлчилгээний лавлагаа нь орон нутгийн хэлээр, хүртээмжтэй форматаар, мөн эрүүл мэндийн тусламж үзүүлж байгаа газарт олдоцтой байхыг баталгаажуулах.

### Эрт илрүүлэлтийг дэмжих

ХОТСЗ хөтөлбөр нь доорх ажлыг гүйцэтгэх боломжтой:

- Эрүүл мэндийн анхан шатны ажилтнуудтай хамтран хөгжлийн бэрхшээлээс үүссэн эмгэг согог, эрүүл мэндийн нөхцөл байдлуудыг эрт илрүүлэх механизм бий болгох;
- Халдварт болон халдварт бус өвчнийг (сүрьеэ, уяман, шимигч хорхойноос үүдэлтэй филариасис өвчин, сохрол, чихрийн шижин, хавдар гэх мэт) эрт илрүүлэх зорилгоор скрининг үзлэг хийх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлд скрининг үзлэг болох хугацаа, байршлыг зааж өгч, мөн тэднийг очиж үйлчилгээ авахад нь хүртээмжтэй байгаа эсэхийг баталгаажуулах;
- Удамшлын гаралтай өвчин эмгэгтэй (тухайлбал булчингийн сулрал) гэр бүлийн гишүүдийг оношилж, үзэж, зөвлөгөө өгөх;



- Тодорхой хөгжлийн бэрхшээлийн улмаас үүсч гардаг арьс цоорох гэх мэтийн хоёрдогч хүндрэлийн талаар мэдлэгтэй байж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллахдаа түүнийг нь шалгаж үзэх;
- Мэс засал хийлгээд сайжрах боломжтой эмгэг согогтой хүмүүсийг олж илрүүлэх.
- Мэс заслын аргаар гэмтлийг анагааж эмчлэх боломжтой иргэдийг олж илрүүлэх

## Жишээ 19 ЭНЭТХЭГ

### Тусламж үзүүлэхийн тулд хүчийг нэгтгэх

Энэтхэгийн Мандя дүүрэгт хоёр төрийн бус байгууллагын удирдан явуулдаг ХОТСЗ хөтөлбөр нь уяман өвчний үндэсний хөтөлбөртэй хамтарсан. Тэдэнд уяман өвчний эхний шинж тэмдгийн талаар сургалт зохион байгуулж, гэмтсэн хүмүүсийг хамгийн ойр эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлдэг төвд очихыг дэмждэг. Уяман өвчинтэй гэж оношлогдсон хүмүүс 6 – 12 сар эмчилгээний дэглэм барих ёстой ба энэ үйлчилгээг эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний байгууллага үнэ төлбөргүй үзүүлдэг. Хэрэв өвчтөн эмчилгээ авч чадаагүй бол эрүүл мэндийн анхан шатны тусламжийн үйлчилгээ ХОТСЗ хөтөлбөр тухайн хүнийг хянахыг хүсдэг.

### Эмчилгээг эрт хүртэх боломжоор хангах

Эмнэлгийн тусламжийн үйлчилгээг бүх шатанд хүртээмжтэй болгохын тулд ХОТСЗ хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүл, эрүүл мэндийн анхан шатны тусламжийн ажилтнуудтай хамтран ажиллах хэрэгтэй. Дараах үйл ажиллагаануудыг санал болгож байна:

- Эрүүл мэндийн ажилтнуудтай хамтарч скрининг үзлэг хийлгэсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шаардлагатай бол дараагийн эмнэлгийн тусламжийг үзүүлэх;
- Эрүүл мэндийн ажилтнуудтай хамтарч эрүүл мэндийн хоёрдогч эсвэр гуравдагч шатлалын эрүүл мэндийн тусламж авах шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг илгээж байгаа эсэхийг баталгаажуулах;
- Дохионы хэл мэддэг ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан сонсголгүй хүний дагаж эрүүл мэндийн байгууллага дээр очиж, тэднийг хэрэгцээгээ илэрхийлж, өгсөн мэдээллийг бүрэн ойлгож, тохирох эмчилгээгээ авч байгаа эсэхийг нь баталгаажуулах;
- Эмнэлгийн тусламж үзүүлэхэд тулгарч байгаа саад бэрхшээлийн талаар ойлголт нэмэгдүүлж, тэрхүү бэрхшээлийг арилгаж устгахад бусадтай хамтарч ажиллах – зарим бэрхшээлүүдийг арилгахад шинэлэг механизм шаардлагатай байж болно. Тухайлбал, эмнэлгийн тусламж үйлчилгээ авахтай холбоотой зардал;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үйлчилгээ үзүүлэхэд тулгарч байгаа дутуу байгаа зүйлсийн бусадтай (хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гэр бүлийн гишүүд, эмнэлгийн ажилтнууд, бодлого баригч нар гэх мэт) хамтарч арга замыг хайх.



## Жишээ 20 Белиз

### Амжилтыг бий болгох

Буурай хөгжилтэй орнуудад хөгжлийн бэрхшээлд ихэвчлэн хүргэдэг төрөлтийн гажиг нь майга тавхай буюу төрөлхийн хөлний гажиг юм. Белизийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Боловсрол ба Сэргээн Засах Олон Нийтийн Агентлаг (ХОТСЗ - Белиз) нь дээрх гажиг нь Белизийн хүүхдүүдийн хувьд чухал анхаарал татах асуудал болж буйг олж мэджээ. Уг байгууллага нь Хүүхдийн Олон Улсын эмнэлэг болон Эрүүл Мэндийн Яамтай хамтран майга тавхайтай хүүхдүүдийг эрт илрүүлэх, эмчлэх хөтөлбөр боловсруулжээ.

Орон нутгийн эмч нар, эм зүйч ба сэргээн засах хэсгийн ажилчдыг Понсети аргыг хэрэглэхэд сургасан ба энэ нь хөлний гажгийг бага насанд нь чиг мод тавих зэрэг зөөлөн арга хэрэглэн засах мэс заслын бус арга юм. ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнуудын тусламжтайгаар хүүхдүүдийг бага насанд нь илрүүлэн тэдэнд хөлний гажгийг засах эмнэлгийн үйлчилгээг санал болгодог болжээ. Энэ нь орон нутгийн төрийн бус байгууллагын санаачлага байсан ба уг амжилт нь хөлний гажгийг засах үндэсний хөтөлбөрийг боловсруулахад хүргэжээ.

### Мэс заслын тусламж үзүүлэх

Хөгжлийн бэрхшээлтэй зарим иргэдэд мэс заслын тусламж шаардлагатай байдаг. Мэс засал тухайн согогийг засч, цаашид үүсэх хүндрэлээс сэргийлдэг бөгөөд мэс заслын дараах асаргаа, сэргээн засалт хамтарч түүний үйлдлийг сайжруулахад хувь нэмрээ оруулдаг. ХОТСЗ хөтөлбөр дараах үйл ажиллагааг хийж болно:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэс заслын ямар сонголт байгааг олж илрүүлж, түүнд шаардагдах санхүүгийн сонголтуудыг судлах;
- Мэс заслаас өмнө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд үүсч болох эрсдлийн талаар сайн ойлголт авсан эсэх, мэс заслын ашиг тус болон мэс засал/эмчилгээний төлөвлөгөө, түүний зардал, хугацаа зэргийг мэдэж байгаа эсэхийг нь баталгаажуулах;
- Мэс засалын дараа хүмүүс мэс заслын, сувилахуйн, сэргээн засалтын багийнхний (хөдөлгөөн засалч, ахуй засалч, протез/ортопед үйлдвэрлэгч гэх мэт) тохирох хяналтанд байгаа эсэхийг баталгаажуулах – ХОТСЗ хөтөлбөр нь эмнэлгийн тусламжаас сэргээн засалт руу аажмаар шилжүүлэхэд тусална.

### Архаг өвчний байдлыг өөрөө удирдах аргыг хөхиүлэн дэмж

ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийнхэнд эмнэлгийн тусламж авах эрхээ мэдэхэд нь, архаг нөхцөл байдлыг удирдахад шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэхэд тусална. ХОТСЗ хөтөлбөрийг дараах үйл ажиллагаа явуулахыг санал болгож байна:

- Өөрийнхөө эрүүл мэндэд хариуцлага хүлээх, тохирох эрүүл мэндийн тусламж үйлчилгээ эрэлхийлэх, эрүүл амьдралын хэв маягийг сонгох зэргийг нь дэмжиж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй шууд хамтран ажиллах, мөн эмнэлгийн зөвлөгөөг дагаж, түүнийг ойлгож байгаа эсэхийг баталгаажуулах;

- Эрүүл мэндийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл бүхий материал, ном хэвлэлийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд зориулж хүртээмжтэй форматаар (энгийн хэллэгтэй, ойлгомжтой зургаар илэрхийлсэн, орон нутгийн хэлээр) боловсруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өөрөө өөртөө туслах бүлэгтэй холбож, мэдлэг, ур чадвараа бусадтай хуваалцаж, өөрийгөө удирдах арга барил сургахад туслах – тэд эмнэлгийн тусламж авахад ямар нөөц бололцоо байгаа, эрүүл мэндийн тусламжийн тогтолцоотой хэрхэн үр дүнтэй зөвшилцөх, эрүүл мэндийн нөхцөл байдлаа хэрхэн удирдах зэрэг үнэтэй мэдээллийг авч суралцдаг.

## Жишээ 21 Никарагуа

### Өөрчлөлтийг бий болгох хамтын ажиллагаа

Никарагуад цусны даралт өндөртэй эсвэл чихрийн шижинтэй зэрэг архаг өвчтэй хүмүүсийн клубууд байдаг. Эдгээр клуб эсвэл дэмжих бүлэг нь эмнэлгийн тусламжийн системийн хичээл зүтгэл тус болох зорилгоор хүмүүсийн өвчин цаашид сэдрэх, муудахаас сэргийлж өөрсдийн эрүүл мэндийг удирдахад хариуцлагыг нь ухамсарлуулахад нэмэр болдог байна. Уулзалтанд хүмүүс өөрсдийн асуудлын талаар



ярилцаж, эрүүл мэндээ хэрхэн хянахад суралцан эрүүл амьдралын хэв маягийг бий болгох арга замуудыг нээдэг байна. Клубын удирдлагын хороо нь эм, эмчилгээ болон эрүүл мэндийн системээр хангагддаггүй лабораторийн туршилт зэрэг үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлдэг. ХОТСЗ хөтөлбөр нь уг дэмжих бүлэгтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулахад тусалдаг.

### Эмнэлгийн тусламжийн үйлчилгээ үзүүлэгчтэй харилцаа холбоо тогтоох

Эмнэлгийн мэргэжилтнүүд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эмнэлгийн тусламж үйлчилгээг хэрхэн сайн хүргэх талаар болон хөгжлийн бэрхшээлийн талаар хязгаарлагдмал мэдлэгтэй байдаг. Эдгээр үйлчилгээ үзүүлэгч нар болон үйлчилгээтэй нь холбоо тогтоосноор ХОТСЗ хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст иж бүрэн эмнэлгийн тусламж үзүүлэх, илгээх ажлыг чиглүүлэх сүлжээг үүсгэж чадна. ХОТСЗ хөтөлбөр дараах үйл ажиллагаануудыг явуулж болно:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийнхний эрүүл мэндийн хэрэгцээний талаар эмнэлгийн мэргэжилтнүүдийн ойлголт нэмэгдүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хувь хүн, бүлэг, гэр бүлийн гишүүд болон эмнэлгийн мэргэжилтнүүдийн хооронд харилцан ярилцлага зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй холбоотой гол асуудлуудын талаар туршлага солилцох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг эмчилгээ/асаргааны төлөвлөгөө зохиох үедээ оролцуулахыг эмнэлгийн мэргэжилтнүүдэд ойлгуулах;
- ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнуудад эрт илрүүлэлт, тохирох үйлчилгээнд нь илгээх, цаашдын хяналтыг хамт олон дотор нь хийхэд туслах зэрэг сэдвээр сургалт зохион байгуулах;

- Эдгээр хөтөлбөрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамрагдаж байгаа эсэхийг баталгаажуулж хамт олны эрүүл мэндийн хөтөлбөрүүдтэй хамтарч ажиллах.

## Жишээ 22 Индонези

### Индонезид ойлголт нэмэгдүүлэх үйл ажиллагаа

Индонезийн Өмнөд Сулавези дахь ХОТСЗ хөтөлбөр нь тосгоны эрүүл мэндийн ажилчид, бага сургуулийн багш нар болон олон нийтийн сайн дурын ажилчдаас бүрдэх олон салбарын багтай ба эдгээр хүмүүсийн ихэнх нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд эсвэл тэдний гэр бүлийн гишүүд байдаг. ХОТСЗ баг нь эрүүл мэндийн системийн бүх л түвшний хүмүүстэй хамт байнгын сургалт явуулдаг хэсэгтэй. Эдгээр сургалтуудын хэсэг нь хамтран ажиллах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эмнэлгийн үйлчилгээний шаардлагыг дэмжих болон ХОТСЗ үүрэг ба эмнэлгийн тусламжийн үйлчилгээг сайжруулах гайхалтай боломжоор хангаж өгдөг.

# Сэргээн засах

## Танилцуулга

Өмнөх үгэнд дурдсанаар сэргээн засалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүл мэндийн боломжит хамгийн дээд түвшинд хүргэхэд чухал юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухайн НҮБ-ын Конвенцийн 26 дугаар зүйлд “Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хараат бус байдлыг дээд зэргээр хангах, тэднийг бие махбод, оюун санаа, нийгмийн болон мэргэжлийн бүрэн чадавхтай болгох, амьдралын бүхий л үйл явцад бүрэн хамрагдах, оролцох боломжийг олгох, эзэмшүүлэх үүднээс ижил түвшний хүмүүс бусаддаа дэмжлэг үзүүлэх болон бусад холбогдох үр дүнтэй, зохистой арга хэмжээ авна...” заасан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох стандарт дүрэмд зааснаар сэргээн засах арга хэмжээ гэж үйлдлийг дахин сэргээх, алдсан эрхтнийг эсвэл үйлдлийн хязгаарлалтыг орлуулахыг хэлнэ. Сэргээн засалт хүний амьдралын аль ч үед тохиолдож болно, гэхдээ энэ нь тодорхой хугацаанд, нэг эсвэл хэд хэдэн төрлийн арга хэмжээ авахаар байдаг. Сэргээн засалтыг хамт олны сэргээн засалчийн гүйцэтгэх үндсэн арга хэмжээнээс хөдөлгөөн засалч мэтийн илүү мэргэжлийн түвшинд арга хэмжээ авах хүртэл ялгаатай байдаг.

Сэргээн засалтыг амжилттай болгохын тулд эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа, нийгмийн халамж гэх мэт хөгжлийн бүх салбаруудын оролцоо шаардлагатай. Энэ элемент нь эрүүл мэндийн салбар дотор санал болгож байгаа үйлдлүүдийг сайжруулахад эдгээр арга хэмжээнүүдэд анхаарлаа хандуулна. Гэхдээ эрүүл мэндийн сэргээн засах үйлчилгээ, туслах хэрэгслийн хангамжийг заавал эрүүл мэндийн яам удирдах албагүй гэдгийг цохон тэмдэглэх нь чухал (Сэргээн засалтын үйлчилгээ хэсгийг уншина уу)





## Жишээ 23 Кени

### Улсын болон хувийн түншлэлийг бий болгох нь

Кенийн хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмлэг (APDK) нь сүүлийн 50 жилд Кенид ойролцоогоор 500 гаруй мянган хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст иж бүрэн сэргээн засалтын үйлчилгээг үзүүлж байна. Олон байгууллагатай хамтран ажилласны үр дүнд APDK нь есөн салбар, 280 гаруй хүрч үйлчилдэг төв, олон арван хамт олонд түшиглэсэн сэргээн засалтын хөтөлбөр бүхий үндэсний сэргээн засалтын сүлжээ байгуулагдаж, эмчилгээ, туслах хэрэгсэл болон мэс засал зэрэг үйлчилгээ үзүүлдэг.

APDK-ийн амжилттай түншлэн ажилласан байгууллагын нэг нь Эмнэлгийн үйлчилгээний яам (хуучнаар Эрүүл мэндийн яам) юм. Сүүлийн 30 жилд APDK нь дээрх яамтай хамтран олон хүмүүст чанартай сэргээн засалтын үйлчилгээг хүргэсэн. APDK-ийн 9 салбарын 6 нь улсын эмнэлэгт байрласан ба Эмнэлгийн үйлчилгээний яам 50 гаруй эрүүл мэндийн ажилтнууд (ихэнх нь терапевст, техникчид)-ыг энэхүү салбаруудад ажиллуулсан. APDK хөтөлбөрийг санхүүжүүлж, яам эрүүл мэндийн ажилтнуудын цалинг өгч байв.

1992 онд APDK анхныхаа ХОТСЗ хөтөлбөрийн Момбасса салбар дээр эхлүүлсэн. 2000 оноос хойш хөтөлбөр өргөжиж, хамгийн эмзэг байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүрэхийн тулд Найроби-гийн хамгийн том ядуусын хороололд хэрэгжүүлж эхэлсэн. ХОТСЗ хөтөлбөр нь гэрээр сэргээн засалтыг үзүүлдэг ба APDK-ийн хүрч үйлчлэх төв болон салбарууд руу илгээдэг. CBM болон Kindernothilfe байгууллагуудын санхүүгийн дэмжлэгтэйгээр APDK нь хөтөлбөрүүд дээр ажиллах ХОТСЗ хөтөлбөрийн 32 ажилтнуудыг ажиллуулсан. Засгийн газраас хэд хэдэн эмчилгээний байршлуудыг санхүүжүүлсэн.

APDK нь улсын болон хувийн хэвшлийн байгууллагын түншлэлийн амжилттай хэрэгжсэн жишээ бөгөөд төвд суурилсан сэргээн засалтыг хамт олонд суурилсан сэргээн засалт хоёр хэрхэн хамтарч ажиллаж, хот болон хөдөөд амьдарч байгаа хүмүүст сэргээн засалтын үйлчилгээ үзүүлэхийг харуулсан юм. 2008 он гэхэд APDK нь ойролцоогоор 52000 Кеничүүдэд сэргээн засалтын үйлчилгээ үзүүлсэн байна.

## Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сайн сайхан байх, хамруулах, оролцоход нь хувь нэмрээ оруулах сэргээн засалтын үйлчилгээг авдаг болоход оршино.

## ХОТСЗ-ын үүрэг

ХОТСЗ хөтөлбөрийн үүрэг нь хамт олны түвшинд сэргээн засалтын үйлчилгээг хөхиүлэн дэмжих, туслах, хэрэгжүүлж, илүү нарийн мэргэжлийн сэргээн засалтын үйлчилгээнд илгээх ажлыг зохицуулахад оршино.

## Хүсч буй үр дүн

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хувийн үнэлгээ хийлгэж, тэдний авах сэргээн засалтын төлөвлөгөөг боловсруулахад оролцдог болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд сэргээн засалтын зорилго, үүргийг ойлгож, эрүүл мэндийн салбарт байгаа үйлчилгээнүүдийн талаар тодорхой мэдээлэл авдаг болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сэргээн засалтын үйлчилгээнд илгээж, тэрхүү үйлчилгээгээ авсан эсэх, мөн тэдний хэрэгцээ хангагдсан эсэхийг баталгаажуулж хянана.
- Хамт олны түвшинд сэргээн засалтын үндсэн үйлчилгээнүүд байна.
- Хамт олны түвшинд явуулж байгаа сэргээн засалтын үйл ажиллагааг дэмжих материалуудыг ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд хэрэглэх боломжтой байна.
- ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд сэргээн засалтын үйл ажиллагааг явуулахын тулд тохирох сургалтанд хамрагдсан байна.

## Гол ойлголтууд

### Сэргээн засах

Сэргээн засалт нь ямар ч хэлбэрийн эрүүл мэндийн нөхцөл байдлаас үүдэн хөгжлийн бэрхшээлтэй болсон хүнд хэрэгтэй байдаг. Тиймээс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын Конвенц дээр “Сэргээн засал”, “Амьдралын чадварт бэлтгэх” гэсэн ойлголтуудыг оруулсан. Амьдралын чадварт бэлтгэх гэдэг нь хүүхэд насандаа эсвэл төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй, хэрхэн бие дааж амьдрахаа мэдээгүй байгаа хүмүүст туслах зорилготой. Сэргээн засалт бол аливаа нэгэн өвчин, осол гэмтлээс үүдээд үйлдэлд гарз хохирол гарсан, дахин түүнийгээ дээд хэмжээнд нь ашиглаж өдөр тутмынхаа амьдралыг хэрхэн гүйцэтгэхээ дахин сурах хэрэгцээнд туслах зорилготой. Амьдралын чадварт бэлтгэх гэдэг бол шинэ нэр томьёо, хөгжиж буй оронд нийтлэг хэрэглэгддэггүй. Тиймээс энэхүү Удирдамжаар амьдралын чадварт бэлтгэх болон сэргээн засалтыг аль альныг нь “сэргээн засалт” нэр томьёон дор хэрэглэсэн.

## **Сэргээн засах арга хэмжээнүүд**

Эрүүл мэндийн салбарт сэргээн засалт өргөн хүрээгээр хэрэглэгддэг тул дараах жишээнүүдийг үзнэ үү.

- Тархины саатай төрсөн охины хувьд сэргээн засалт нь түүний хөдөлгөөн, мэдрэхүй, хэлний хөгжлийг дэмжих тоглоом, булчинг хөшингө болгох, гажгийг хязгаарлах дасгал хөдөлгөөн, функцийн үйл ажиллагааг зөв байрлалд оруулахад туслах тусгай тэргэнцэр олгох зэрэг орно.
- Сонсголгүй, хараагүй хүүгийн хувьд сэргээн засалт нь түүнийг хөгжүүлэх өдөөх үйл ажиллагаа явуулах, орон гэр болон орчин тойрныг нь мэдрүүлэх чиг баримжаа олгох сургалт зохион байгуулах, харилцааны өөр аргуудыг (хүрэх, дохих) заахад эцэг эхтэй нь хамтран ажиллах орно.
- Оюуны хомсдолтой өсвөр насны охины хувьд сэргээн засалт нь түүнд хувийн ариун цэврийг сахихыг (тухайлбал биений юм ирэх үед цэвэрхэн байх) зааж өгөх, гэр бүлтэй нь зан үйлийн асуудалтай хэрхэн харьцах талаар стратеги боловсруулах, хамт олон түүнийг хүлээн авч, үйл ажиллагаандаа оролцуулах боломжийг олгох зэрэг болно.
- Гүн хямралд орсон залуу эрийн хувьд сэргээн засалт нь ганцаарчилж зөвлөгөө өгөх, стресс, уур бухимдалаа тайлах тайвшрах дасгал заах, нийгэм дэх оролцоог нэмэгдүүлэх, бусад танилцахад туслах зэрэг орно.
- Цус харваллтай дунд насны эмэгтэйн хувьд сэргээн засалт нь доод мөчийг сайжруулах дасгал, алхах сургалт, бие дааж ганцаараа хувцсаа өмсөх, усанд орох, хоол ундаа идэх зэргийг заах, балансын алдагдлыг багасгахын тулд таягтай явж сурах, хэл ярианы дасгал хийх зэрэг орно.
- Чихрийн шижинтэй, саяхан хоёр хөлөө өвдөгнөөс доогуур тайруулсан настай эрэгтэйн хувьд сэргээн засалт нь дасгал хөдөлгөөн хийх, хиймэл хөл хэрэглэх, эсвэл тэргэнцэр ашиглах, хөдөлж явах, мөн нэгээс нөгөөд шилжиж сурах, өдөр тутмын ажилд чадваржих сургалт зохион байгуулах зэрэг орно.

## **Сэргээн засах үйлчилгээ**

### **Сэргээн засах үйлчилгээ**

Сэргээн засах үйлчилгээг засгийн газар, хувийн болон төрийн бус байгууллагууд үзүүлдэг. Ихэнх оронд энэхүү үйлчилгээг эрүүл мэндийн яам удирддаг; боловч зарим оронд сэргээн засах үйлчилгээг бусад яамд хариуцдаг байна. Жишээлбэл, Вьетнамд Хөдөлмөр, Дайнаас гарсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, нийгмийн асуудал эрхэлсэн яам, Энэтхэг, Гана болон Этиопд нийгмийн халамжийн яамдууд хариуцдаг байна. Зарим оронд засгийн газрын яамд болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаагаар удирдан явуулдаг байна. Жишээлбэл Ираний Исламжийн бүгд найрамдах улс, Кени болон Хятад зэрэг орнуудад хамтран удирддаг.

Үйлчилгээг эмнэлэгийн мэргэжилтэн (сувилагч, их эмч), эмчилгээний мэргэжилтэн (ахуй засалч, хөдөлгөөн засалч, хэл яриа засалч), технологийн мэргэжилтэн (ортоз, протез үйлдвэрлэгч) болон сэргээн засалтын ажилтнууд (сэргээн засалтын туслах ажилтан, хамт олны сэргээн засалтын ажилтан) үзүүлдэг. Сэргээн засах үйлчилгээг сэргээн засалтын байдал (осол гэмтлээс үүдэлтэй хурц үе) болон үзүүлэх арга хэмжээнээс нь шалтгаалаад эмнэлэг, клиник, тусгай төв нэгж байгууллага, хамт олны газар ба гэр орон зэрэг олон төрлийн орчинд явуулж болдог.

Хөгжиж байгаа орнуудад, ялангуяа хөдөө орон нутагт сэргээн засах үйлчилгээний хүртээмж болон боломж бололцоо хязгаарлагдмал байдаг. Тухайлбал сэргээн засалтын төв ганцхан том хотод байдаг байж болно. Тийм учраас ХОТСЗ хөтөлбөр гэх мэтийн хамт олонд түшиглэсэн стратеги нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийг сэргээн засалтын үйлчилгээтэй холбоход чухал үүрэгтэй байдаг.

### **Хамт олонд түшиглэсэн үйлчилгээ**

Түүхээс харахад ХОТСЗ нь буруу хөгжилтэй оронд орон нутгийн нөөц бололцоог ашиглан хөгжлийн бэрхшээлтэй хүнд сэргээн засалтын үйлчилгээг хүргэх утгатай эхэлсэн. Энэхүү хандлага нь хөгжлийн илүү өргөн хүрээнд хувьсан өөрчлөгдөж байгаа ойлголт хэдий ч хамт олны түвшинд сэргээн засалтын үйлчилгээ үзүүлэх нь бодит бөгөөд ХОТСЗ хөтөлбөрийн чухал үйл ажиллагаа хэвээр байгаа.

Тусгай төв дээрх сэргээн засалт нь олон хүмүүст, ялангуяа хөдөө орон нутагт амьдарч байгаа хүмүүст төдийлөн ач холбогдолтой биш байж болно. Хамт олны түвшинд тэдгээр сэргээн засалтаас олныг нь санаачлан хийх боломжтой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олонд сургах ДЭМБ-ын багц гарын авлага нь хамт олны түвшинд орон нутгийн нөөц бололцоог ашиглан хийж болох сэргээн засалтын үйл ажиллагаануудыг зааварласан байдаг.

Хамт олонд түшиглэсэн сэргээн засалтын үйлчилгээг илүү нарийн мэргэшсэн сэргээн засалтын төв дээр үргэлжлүүлэн хийх шаардлагатай байж болно. Харин буцаж ирмэгц тэндээс сурсан шинэ чадвар, мэдлэгээ ашиглаж үргэлжлүүлэх шаардлагатай. ХОТСЗ хөтөлбөр тухайн хүний гэрээр очиж, шаардлагатай тохиолдолд сэргээн засалтын үйлчилгээг үргэлжлүүлж, тусалж дэмжиж чадна.

Хамт олны түвшинд байгуулагдсан сэргээн засалтын үйлчилгээг нарийн мэргэжлийн сэргээн засалтын үйлчилгээ үзүүлдэг зуучлах төвтэй нягт холбох шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээ цаг хугацаа өнгөрөх тусам өөрчлөгдөж, удаан хугацаанд тогтмол дэмжлэг шаардлагатай ч болж болно. Сэргээн засалтын үр дүн нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, сэргээн засалтын мэргэжилтнүүд, хамт олонд түшиглэсэн ажилтнуудын хоорондын түншлэлээс маш их шалтгаалдаг.



## Жишээ 24 Хятад

### Бие даасан байдалд хүрэх Лигийн аялал

Бэлэвсэн эмэгтэй Ли нь өөрийн настай ээж болон гурван хүүхдийн хамт Хятадын Чин Хай нутагт амьдардаг. 2003 оны 10 сард гарсан ослоос өмнө бүх гэр бүл нь түүнээс хамааралтай байжээ. Ли гэртээ засвар хийж байх үедээ өндрөөс унан нуруугаа хугалсан ба үүний үр дүнд түүний хоёр хөл мэдээ алдаж сулралтай болсон байна. Эмнэлгээс гарсны дараагаар тэр бүх өдөржин шөнөжин орондоо хэвтэв. Хоёр хөлний хавдар нь улам томорсоор тэр орондоо хэвтэх, усанд орох, хувцсаа солих үедээ хүүхдүүдээсээ бүрэн хамааралтай болжээ. Ли өөртөө итгэх илтгэлээ алдаж хэд хэдэн удаа амиа хорлохыг завдаж байжээ.

Орон нутгийн ХОТСЗ хөтөлбөрийн тосгоны сэргээн засахын ажилтан Лигийн гэрт зочилж гэрээр сэргээн засах ажиллагааг үзүүлэв. Ли өөрийн бусад чадваруудыг ашиглан өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх шинэ аргуудад суралцаж байв. Түүнд хөгжлийн бэрхшээлийнх нь талаар мэдээлэл олгож, арьс цооролт болон шээсний замын үрэвслээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар заажээ. Түүний гэр бүл, найз нөхөд нь хэрхэн зогсох, ойр зуур алхах зэрэгт сургаж тусалж байв. Мужийн Сэргээн Засах Төвөөс түүнд суга таяг, тэргэнцэр өгчээ. Цаг хугацааны эцэст шантралгүй дасгал сургуулилт хийсний хүчинд Ли суга таягтай бие даан явж, тэргэнцэртэй хол замд явж чаддаг болжээ.

Алхам алхмаар Ли өөртөө итгэх итгэлтэй болов. Мөн хурдан хугацаанд өдөр тутмын ажлыг гүйцэтгэдэг болж өөрийн хамгийн хийх дуртай зүйл болох гэр бүлийнхэндээ хоол бэлтгэж өгдөг болжээ. Тэрээр жижиг хоолны газар нээн ажиллуулж Мужийн Сэргээн Засах Төвөөс олгодог сарын тэтгэмжтэй нийлүүлэн бага зэрэг орлого олох болсон ба гэр бүлдээ анхаарал тавьж ирээдүйдээ итгэлтэй болжээ.

### Сэргээн засах төлөвлөгөө

Сэргээн засах төлөвлөгөө нь хүн төвтэй, зорилгод чиглэсэн, бодит байх шаардлагатай. Төлөвлөгөөг боловсруулахдаа тухайн хүний илүүд үздэг зүйл, нас, хүйс, нийгэм эдийн засгийн байдал, гэр орны орчин тойрныг анхаарч үзэх хэрэгтэй. Сэргээн засалт гэдэг болон урт удаан аялал, хол харж, богино хугацаагаар зорилгоо тодорхойлох шаардлагатай байдаг. Сэргээн засалтын төлөвлөгөөг бодит хийхгүй бол үнэтэй нөөц бололцоогоо дэмий үрэх тал бий.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй нь зөвлөлдөөгүйн улмаас ихэнх сэргээн засалтын төлөвлөгөө нурдаг. Төлөвлөгөөнд тэдний сэтгэгдэл, сонголтыг анхааран үзэж, тэдний амьдралын бодит байдлыг, ялангуяа ядуурлын асуудлыг харгалзан үзэх нь чухал. Тухайлбал, хөдөө орон нутагт амьдарч байгаа ядуу хүн хөдөлгөөн засал хийлгэхээр байн байн хот руу орж ирэхээр төлөвлөвөл энэ нь бүтэхгүй нурна гэсэн үг. Сэргээн засалтын мэргэжилтэн хөдөө орон нутагт болон тухайн хүний гэрт аль болох ойр сэргээн засалтын хөтөлбөрийг боловсруулж, санаачлагатай байх ёстой.

## Санал болгож буй үйл ажиллагаанууд

### Хэрэгцээ шаардлагыг олж илрүүлэх

Сэргээн засалтын төлөвлөгөөг хийж, үйл ажиллагааг эхлэхээс өмнө ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан хувь хүний болон тэдний гэр бүлийн гишүүдийн хэрэгцээ, тэргүүлэх асуудлыг үнэлэх нь чухал. Үнэлэх нь чухал чадвар, тиймээс ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнуудад сургалт явуулж, чадвар эзэмшүүлэх хэрэгтэй. Хүний хэрэгцээг олж илрүүлэхэд дараах асуултуудыг анхаарвал тус болно.

- Тэд юу хийж чадах, юуг чадахгүй вэ?
- Тэд юу хийж чадахыг хүсдэг вэ?
- Тэдэнд ямар асуудал тулгардаг вэ? Энэ асуудал нь хэзээ, хэрхэн эхэлсэн бэ?
- Тэдний аль хэсэг нь өртсөн бэ? Бие, мэдрэхүй, сэтгэл санаа, холбоо харилцаа, зан үйл?
- Тэдэнд ямар хоёрдогч хүндрэл бий болж байгаа вэ?
- Тэдний гэр орон, хамт олон нь ямаршуухан бэ?
- Тэд хөгжлийн бэрхшээлээ яаж өөртөө тохируулсан байна вэ?

Тодорхой мэдээллийг өвчтний эмнэлгийн түүхээс харж, хувь хүнийг өөрийг нь ажиглаж, хөдөлгөөнийг шалгах, мөн тэдэнтэй, гэр бүлийн гишүүдтэй нь ярилцаж, эрүүл мэндийн мэргэжилтнүүд/үйлчилгээнд хамруулах зэргээр авч болно. Анхны үзлэгийн бичилт, өгсөн зөвлөгөөг бичиж хадгалах нь чухал. Учир нь тухайн хүний өсөлт дэвшлийг тодорхой цаг хугацааны дараа хянадаг. ХОТСЗ хөтөлбөрүүдийн ихэнхэд нь үнэлэх, ахиц дэвшлийг үнэлэх маягтуудтай байдаг.

### Илгээх үйлчилгээг зохион байгуулах болон дараагийн хяналтыг хий

- Үнэлгээ хийсний дараа тухайн хүнд нарийн мэргэжлийн сэргээн засалтын үйлчилгээ (хөдөлгөөн засал, ахуй засал, дуут эмчилгээ, хэл засал гэх мэт) шаардлагатай гэсэн хэрэгцээг ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан илрүүлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хэрэгтэй үйлчилгээнд нь илгээх ажлыг зохион байгуулж болно. Доорх үйл ажиллагааг санал болгож байна.
- Эрүүл мэндийн тогтолцооны бүх түвшинд сэргээн засалтын илгээх үйлчилгээг олж илрүүл.
- Илгээх үйлчилгээний (байршил, ач холбогдол, үнэ өртөг гэх мэт) талаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст, тэдний гэр бүлийн гишүүдэд мэдээл.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг илгээх үйлчилгээний тадаарх өөрсдийнхөө бодол болон асуултуудаа асуухыг нь дэмж. Шаардлагатай бол нэмэлт мэдээлэл олоход тусал. Ижил төрлийн үйлчилгээ авч байсан ижил төрлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбох.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд аль нэг газар руу илгээхээс өмнө нь тэдэнд урьдчилан мэдээлэл өгч, зөвшөөрлийг нь авсан эсэхийг баталгаажуул.
- Илгээсний дараа хувь хүнтэй болон тухайн үйлчилгээний газартай байнгын холбоо тогтоо.
- Үйлчилгээг хүртэхэд ямар дэмжлэг (санхүүгийн, тээврийн эсвэл нөлөөллийн гэх мэт) авах шаардлагатай байгаа болон түүнийг хэрхэн олгох талаар олж илрүүл. Тухайлбал, нөлөөллийн ажил шаардлагатай бол ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй хамт очиж цаг авч уулзах гэх мэт.



- Үйлчилгээ авч эхэлсний дараа тухайн дэмжлэг цаашид шаардлагатай эсэхийг тодорхойлж дараагийн хяналтыг хийх. Тухайлбал сэргээн засалтыг гэрт нь үргэлжлүүлэн хийх хэрэгтэй байж болно.
- Нарийн мэргэжлийн сэргээн засалтын үйлчилгээ нь ихэнхдээ томоохон хотын төвд байрладаг, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс алс хол, хөдөө нутгаас ирж үйлчлүүлэх боломжгүй байдаг. Хот руу ирэх унаа, хоол хүнс, орон байртай холбоотой гарах зардал болон өдрийн цалингаа авахгүй болно гэдгийг санаж байх хэрэгтэй. Ихэнх үйлчилгээний төлбөр зардал хармаанаас давсан мөнгө шаардлагатай байдаг. ХОТСЗ хөтөлбөр санхүүгийн энэхүү хязгаарлалтын талаар мэддэг байх ёстой бөгөөд засгийн газар болон төрийн бус байгууллагуудаас гарах эх үүсвэр болон банкны зээл, хамт олны дэмжлэг тусалцаа зэрэг өргөн хүрээний сонголтуудыг судлах хэрэгтэй.

## Жишээ 25 Иран

### Үйлчилгээнээс хол газар үгүй

Ираны Исламийн бүгд найрамдах улсын ХОТСЗ хөтөлбөр нь тосгоны эрүүл мэндийн ажилтан болон ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрт илрүүлж, тэднийг эрүүл мэндийн анхан шатны тусламжийн үйлчилгээнд илгээх үүргийг дэмждэг. Ингэснээр явуулын сэргээн засалтын баг гэрт нь очиж, гэрээр сэргээн засах үйлчилгээг үзүүлдэг. Хэрэв нарийн мэргэжлийн арга хэмжээ шаардлагатай бол гуравдагч шатлалын төв рүү илгээдэг. Ихэнхдээ мужийн төвөөс нийслэл хот руу илгээдэг. Нарийн мэргэжлийн сэргээн засалтын төвөөс хүмүүсийг эрүүл мэндийн анхан шатны тусламжийн үйлчилгээ рүү буцааж илгээдэг. Шаардлагатай бол ХОТСЗ хөтөлбөр тухайн хүний сэргээн засалтыг үргэлжүүлэн хийж хамтран ажилладаг. Явуулын баг ахиц дэвшлийг үнэлж, шаардлагатай бол цаашдын тусламжийг үзүүлдэг.

### Сэргээн засалт хий

ХОТСЗ хөтөлбөр гэрийн болон хамт олонд түшиглэсэн эмчилгээ үйлчилгээг хийж, төрөл бүрийн эмгэг согогтой хүмүүст тусалцаа үзүүлж, тэдний үйлдлийг гэрт болон хамт олны түвшинд дээд хэмжээнд нь эсвэл хэвийн хэмжээнд нь байлгах арга хэмжээг авч чадна.

### Хүүхдийн хөгжилд эрт арга хэмжээ ав

Хүүхэд бүр өөрийнхөө амьдралын чухал дадал, чадваруудыг олж авах суралцах процессыг дамждаг. Хүүхдийн хөгжлийн гол хэсгүүд нь биеийн хөгжил, хэл ярианы хөгжил, танин мэдэхүйн хөгжил, нийгмийн болон сэтгэл хөдлөлийн хөгжил зэрэг байдаг.

Хүүхэд өөрийнхөө насанд хүрэх ёстой зүйлдээ хүрэхгүй байвал хөгжлийн хоцрогдол үүсч болно. Эрт арга хэмжээ авснаар хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг аль болох эрт илрүүлж, хоцрогдлоос сэргийлэх эсвэл сайжруулах сэргээн засалтын арга хэмжээг авдаг.

Тархины саа, сохрол, эсвэл дүлийрэл гэх мэтийн хөгжлийн бэрхшээл илэрвэл энэ нь хөгжлийн хоцрогдолд хүргэж, хүүхдийн өдөр тутмын үйл ажиллагаанд (хүүхдүүдтэй тоглох, сургуульд явах гэх мэт) оролцох чадварыг хязгаарладаг. ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан ихэнхдээ хөгжлийн энгийн, таатай сурах боломжуудыг дэмжсэн, гэрт суурилсан, эрт үеийн арга хэмжээнүүдийг явуулж чадна. Эцэг эхчүүд үзэл бодлоо, туршлагаа хуваалцахаар уулзах ажлыг ХОТСЗ хөтөлбөр дэмжсэнээр хүүхдүүд бусад хүүхдүүдтэй хамт тоглож, шинэ чадвар эзэмшиж, хөгжлийн бүх талбарууд сайжирдаг.

## Жишээ 26 Египет

### Гэр бүлд хөгжилтэй

Египетийн Александра дахь ХОТСЗ хөтөлбөр нь хотын өөр өөр хэсгүүдэд долоо хоног бүр уулзалт зохион байгуулдаг хэд хэдэн клубтэй. ХОТСЗ хөтөлбөр ба сайн дурын ажилчдын зохион байгуулсан арга хэмжээнд эцэг эхчүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэйгээ хамт ирж оролцдог байна. Хүүхдүүдэд сонирхолтой хөгжилтэй үйл ажиллагаанууд олон байдаг ба жишээлбэл дуу, бүжгийн тэмцээн болон эцэг эхчүүд өөрсдийн туршлагаа бусадтай хуваалцах боломжийг олгодог.

### Функцийн хувьд бие даасан байдлыг дэмж

Функцийн хувьд бие даах гэдэг нь хувь хүн өдөр тутмын амьдралын чадвараа (явах, харилцах, усанд орох, бие засах, хувцсаа өмсөх, идэх, уух, хоол хийх, гэрийн ажил хийх) бие даан гүйцэтгэх түвшинг сайжруулах зорилготой. Авах арга хэмжээ нь хувь хүний нас, хүйс, орчин зэргээс хамаарах бөгөөд амьдралын нэг шатлалаас нөгөөд шилжиж байгаа учраас цаг хугацааны туршид тэр нь өөрчлөгддөг. ХОТСЗ хөтөлбөр дараах зүйлүүдийг хийж болно:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд аливаа зүйлийг хийх төрөл бүрийн аргуудаар сургалт зохион байгуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бие дааж үйл ажиллагаанд оролцуулахад хэрхэн туслах талаар гэр бүлийнхэнд нь сургалт зохион байгуулах;
- Туслах хэрэгслийг (хялбар болгох алхал/хөдөлгөөний хэрэгсэл гэх мэт) ашиглах талаар сургалт зохион байгуулах;
- Зарим нэг эмгэг согогийн үед хэрэглэх тусгай аргуудын талаар сургалт зохиох, зааварчилгаа өгөх. Тухайлбал, булчингийн сулрал, тэнцвэрээ хадгалж байх, булчин чангарах зэргийг сунгах, чангаруулах зэрэг хөтөлбөр хэрэгжүүлж болно.



## Өөртөө туслах бүлгийн холбоо

ХОТСЗ хөтөлбөр нь ижил сэргээн засах үйл ажиллагаатай эсвэл адил бэрхшээлтэй хүмүүсийн цуглардаг өөртөө туслах бүлгийг дэмжин тусалдаг ба энэ нь тэдэнд өөрсдийн мэдээлэл, санаа бодол болон туршлагаа хуваалцах боломжийг олгодог. ХОТСЗ хөтөлбөр нь эдгээр бүлэг хүмүүс ба сэргээн засах мэргэжилтнүүдийн хоорондын харилцан ойлголцол, хамтын ажиллагааг бататгахын тулд дэмжлэг тусалцаа үзүүлдэг байна.

## Жишээ 27 | Гуяана

### Амьдралыг өөрөөр харахад суралцах

Ширли Гуяанагийн нэгэн тосгонд амьдардаг. Тэр харааны бэрхшээлтэй байсан тул ээж нь түүнийг ганцааранг нь гаргахаас айдаг байжээ. ХОТСЗ хөтөлбөрийн сайн дурын ажилчид тэднийд зочлон эхтэй нь уулзаж ярилцан, Ширлиг бие даан гадуур явахад нь сургах боломжтой гэж хэлжээ. Ширлигийн ээжид үүнийг итгүүлэх тун бэрх байв. Ингээд тэд ХОТСЗ хөтөлбөрийн дүүргийн зохицуулагч Паулинийг Ширлигийн гэрт очихыг ятгажээ. Паулин өөрөө харааны бэрхшээлтэй байсан тул сайн дурын ажилчид түүнийг сайн үлгэр жишээ болж урамшуулж чадах хүн гэж итгэж байв. Ингээд Ширлигийн ээж зөвшөөрөн сэргээн засах төлөвлөгөөг боловсруулсан байна. Ширли маш хурдтай ахиц гаргасан ба цагаан таягны тусламжтайгаар бие даан ганцаараа гадуур явах чадвартай болжээ. Тэрээр ХОТСЗ хөтөлбөрийн орон нутгийн хорооны идэвхтэй гишүүн, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагын гишүүн болсон байна.

## Орчин тойрныг өөрчилж зас

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг функцийн хувьд бие даах байдлыг сайжруулахад орчныг өөрчилж засах шаардлагатай байж болно. ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан хувь хүний түвшинд (гэрт нь) тэргэнцэрт зориулж налуу зам, шатны бариул, бие засах өрөөг засах, хаалгыг өргөн болгох, хамт олны түвшинд сургуулийн эргэн тойрон, нийтийн барилга байгууламж, ажлын байр гэх мэтэд өөрчлөлт засвар хийхэд чиглүүлж болно (Туслах хэрэгсэл элементийг уншина уу).


## Өөрөө өөртөө туслах бүлэгтэй холбо

Ижил төрлийн эмгэг согогтой эсвэл ижил төрилийн сэргээн засах үйлчилгээний хэрэгцээтэй хүмүүс хамтарч, санаа бодлоо, туршлагаа хуваалцах зорилгоор өөрөө өөртөө туслах бүлэг бий болж ажиллахыг ХОТСЗ хөтөлбөр дэмждэг. ХОТСЗ хөтөлбөр эдгээр бүлгүүдийг сэргээн засалтын мэргэжилтнүүдтэй уулзаж, хамтран ажиллахыг дэмждэг.

## Жишээ 28 Вьетнам

### Эмээ өөрийн замыг олсон нь

Вьетнамын Тай Бин тосгоны нэгэн настай эмээ чихрийн шижинтэй ба хараа муутай байжээ. Тэрээр шөнийн цагаар ариун цэврийн өрөөнд яаралтай орох хэрэг байнга гардаг ба бие засах газар нь хашааны захад байрладаг тул гэр бүлийн хүмүүсээс тусламж авах хэрэг гардаг байжээ. ХОТСЗ хөтөлбөрийн сайн дурын ажилчин тэдний гэр бүлд гэрээс ариун цэврийн өрөө хүртэл утас татахыг зөвлөж ингэснээр эмээ бусдыг сэрээлгүйгээр утсыг барьж явсаар замаа олох боломжтой болжээ. Орчныг энгийн аргаар сайжруулснаар эмээгийн хараат бус байдлыг бий болгож чаджээ.



## Жишээ 29 ЭНЭТХЭГ

### Эмнэлгийн дэмжлэг туслалцааг таньж мэдэх

Энэтхэгийн Мумбайн ядуу хороололд хэрэгждэг ХОТСЗ хөтөлбөр нь ихэвчлэн сэргээн засах институтын ажилчдыг сургагч болон багшаар урьж ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнуудыг бэлтгэдэг байв. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд чих, хамар, хоолой, мөн нүдээ үзүүлэхээр эмнэлэгт очихоосоо айж эмээдэг байсныг ХОТСЗ хөтөлбөр олж мэджээ. Ингээд хөгжлийн бэрхшээлтэй иргэд ба тэдний гэр бүлээс бүрдсэн жижиг баг бүрдүүлэн эмнэлэгт очиж хэрхэн үйл ажиллагаа явуулдаг талаар тайлбарлаж өгөв. Эмнэлгийн мэргэжилтнүүд ХОТСЗ хөтөлбөрөөс зохион байгуулсан соёлын арга хэмжээнүүдэд уригдаж, хамт олонд танигдана. Олон тусгай эмнэлгүүд ХОТСЗ хөтөлбөрөөс санал болгосон хүмүүст хөнгөлттэй үнээр эмчилгээ хийхийг зөвшөөрчээ.

### Сургалтын материалыг боловсруулж, түгээ

Хөгжлийн бэрхшээлийн ном, гарын авлагууд нь сэргээн засалтын чухал ашигтай арга хэрэгсэл болж болно. Эдгээрийг ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд сэргээн засалтын талаар, ялангуяа сэргээн засалтын мэргэжилтнүүд дутмаг газарт эдгээр ном, гарын авлагууд хэрэгтэй. Сэргээн засалтанд олон салбар, үйлчилгээнүүд хамрагддаг учир эдгээр ном, гарын авлагууд нь нийт хамт олонд үнэтэй мэдээлэл болж болно. ХОТСЗ хөтөлбөр дараах үйл ажиллагаануудыг санал болгож байна:

- Одоо байгаа ном, гарын авлага, материалуудыг цуглуулах. Яамд, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд, үндэсний болон олын улсын төрийн бус байгууллагуудад холбогдох материалууд байж болох боловч тэдний ихэнх нь интернетээр олддог. Тухайлбал, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олны дунд сургах, Тосгоны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд гэх мэт.
- Материалуудыг орон нутгийн нөхцөл байдалд, мөн соёлд нь тохируулан хэрэглэх.

- Материалуудыг үндэсний болон орон нутгийн хэл рүү орчуулах.
- Ном, гарын авлага байхгүй бол орон нутгийн хэрэгцээнд зориулж энгийн үг хэллэгтэй шинэ гарын авлага материал боловсруулах.
- ХОТСЗ хөтөлбөрийн бүх ажилтнуудад ном, гарын авлага тарааж, түүнийгээ хөгжлийн бэрхшээлтэй хүн дээр сэргээн засалт хийх гэж очихдоо ашиглах.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гэр бүлийн гишүүд болон хамт олны бусад гишүүд үзэх боломжтой газар байгуулах. Тэрхүү газрыг орон нутгийн хөгжлийн газар, хамт олны эрүүл мэндийн төв, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төв гэх мэт газарт байгуулж болно.

## Жишээ 30 | Монгол

### Ном гарын авлагуудыг Монгол хэр рүү орчуулах

ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд зориулан гол гол гарын авлагуудыг монгол хэл рүү орчуулан хэвлэсэн. Тухайлбал, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олон дотор нь сургах, Нуруу нугасны гэмтэлтэй хүмүүстэй ажиллах гарын авлага, Тархины саатай хүүхдэд зориулсан гарын авлага, Цус харвалттай хүнтэй ажиллах гарын авлага, Эмгэг согогтой хүүхэдтэй ажиллах гарын авлага, гэрийн нөхцөлд хийх дасгал хөдөлгөөн, Тав хүртэлх хүүхдийн өсөлт хөгжил, Хамт олонд түшиглэсэн сэтгэцийн эрүүл мэнд зэрэг ДЭМБ-ын гарын авлагууд, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст болон олон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай Конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай Конвенцийн хялбаршуулсан гарын авлага, Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын хамтарсан баримт бичиг, Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харилцах цагаан толгой, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос Монгол улсад өгсөн дүгнэлт, зөвлөмж зэрэг ном, гарын авлага, тараах материалыг олны хүртээл болгож байна. Хөтөлбөрийн сургалтанд хамрагдсан эмч, эмнэлгийн ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гэр бүлийн гишүүд, ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд дээр дурдсан гарын авлагуудыг хүлээн авч, өөрсдийн ажил дээрээ хэрэглэж байна.

### Сургалт зохион байгуул

ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнуудад сэргээн засалтын үйлчилгээг хүргэхэд чиглүүлэх, хамт олны түвшинд тохирох үйлчилгээгээр хангах талаар сургалт хэрэгтэй. Олон байгууллагууд тохирох сургалтын хөтөлбөр боловсруулсан байдаг. ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд сэргээн засалтын ажилтнуудын (хөдөлгөөн засалч, ахуй засалч, хэл засалч, чих хамар хоолойн эмч, алхуулагч, протез, ортопед үйлдвэрлэгч, эмнэлгийн ажилтан, эмнэлгийн дунд мэргэжилтэн) үүргийг маш сайн мэдэж байх шаардлагатай, ингэж байж төрөл бүрийн эмгэг согогтой хүмүүст хэрхэн туслахаа мэднэ. Мөн ХОТСЗ хөтөлбөр сэргээн засалтын мэргэжилтнүүдэд ХОТСЗ хандлагын талаар, түүний гүйцэтгэх үүргийн талаар ойлголт өгч, энэ нь үйлчилгээг хэрхэн зэргээр үйлчлүүлэгчид хүргэх талаар ойлголт өгч болно (Менежмент хэсгийг уншина уу).

•



# Туслах хэрэгсэл

## Танилцуулга

Туслах хэрэгсэл нь тодорхой нэг үүргийг гүйцэтгэхэд тухайн хүнд туслахаар зохион бүтээгдсэн, эсвэл тохируулсан гадуур хэрэглэдэг хэрэгсэл юм. Олон хөгжлийн бэрхшээлтэй хүн өдөр тутмынхаа амьдралд оролцох, хамт олны амьдралд идэвхтэй, үр бүтээлтэй оролцох эсэх нь туслах хэрэгслээс хамаардаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийн 4, 20, 26 дугаар зүйлд Оролцогч улсыг тохирох хэрэгсэл, хөдөлгөөн дэмжих хэрэгслийг хөхиүлэн дэмжиж, тэдгээрийн талаар хүртээмжтэй мэдээллээр хангахыг хүссэн байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох стандарт дүрэмд туслах хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэхийг дэмжих, мөн тэдгээрийн талаар мэдлэг ойлголтыг түгээхийг Оролцогч улсыг уриалсан байдаг.

Хөгжил буурай болон дунд орлоготой оронд туслах хэрэгсэл, технологи хэрэгтэй хүмүүсийн зөвхөн 5-15% нь авч чаддаг. Эдгээр орнуудад үйлдвэрлэл маш бага, ихэнхдээ маш хязгаарлагдмаа тоогоор үйлдвэрлэдэг, бэлтгэгдсэн боловсон хүчин цөөн, зарахыг хориглосон байдаг.

Туслах хэрэгслийн хүртээмж нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд маш чухал, мөн хөгжлийн стратегийн чухал хэсэг нь болдог. Туслах хэрэгсэлгүйгээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс боловсрол эзэмшиж, хөдөлмөр эрхэлж чадахгүй. Ингэснээр ядуурлын цикль үргэлжилсэн хэвээр байх болно. Туслах хэрэгслийн хэрэглээ мөн өсч өндөр настнууд түүнийг эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх стратеги болгон хэрэглээ нь өсч байна.





## Жишээ 31 Непал

### Дахиад ажиллах боломжтой болов

Биратнагарын ХОТСЗ (CBRB) нь 1990 оноос хойш Непалын зүүн хэсэгт ажиллаж байгаа төрийн бус байгууллага юм. Одоогоор Биратнагар дэд захиргаа болон Моранг дүүргийн 41 тосгонд 3000 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрсэн хүмүүст сэргээн засалтын үйлчилгээ үзүүлж байна.

Олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс туслах хэрэгслээ засуулахаад нийслэл хот руу эсвэл хөрш орон болох Энэтхэг рүү явдаг байсан учраас 1997 онд CBRB нь туслах хэрэгслүүд засах жижиг оврын ортопедийн цех нээв. Цаг хугацаа өнгөрөх тусам CBRB нь бүрэн тоноглогдсон ортопедийн цехтэй болгохын төлөө ажилласан. Handical International (Nepal) байгууллагатай хамтарч туслах хэрэгслийг үйлдвэрлэдэг, нийлүүлдэг, засдаг иж бүрэн үйлчилгээг бий болгов. Непал болон Энэтхэгийн хүмүүсийг (хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй эрэгтэй, эмэгтэй хүмүүс) техникчээр бэлтгэж, CBRB-ийн багтаа оруулав. Одоо CBRB нь Непалын зүүн хэсгийн 16 дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг чанартай ортоз (хөлийн чиг, нурууны бэхэлгээ, төрөл бүрийн чигнүүд), протез (хиймэл хөл, гар) болон хөдөлгөөн дэмжих хэрэгслүүд (таяг, гурван дугуйт, тэргэнцэр)-ээр хангаж байна. ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд, терапевстууд, цехийн техникчид бүгд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулахад гар нийлэн ажиллаж байна.

Ортопедийн цехээс ашиг хүртсэн хүмүүсийн нэг нь Чандесвар юм. Тэрээр гэмтэл авч, зүүн хөлөө тайруулахаасаа өмнө тэргээр хүн зөөдөг байв. Гэмтлийн дараа тэрээ хуучин ажлаа хийх боломжгүй болж орлогоо ч алдав. Эмчилгээнийхээ зардалд мөнгө төлөх хэрэгтэй байсан учир хадгалж байсан мөнгөө ч дуусав. Чандесварыг түүний тосгонд ажиллаж байсан CBRB-ийн баг илрүүлж, түүнд өвдөгнөөс доогуурх хиймэл хөл тааруулж өгч, түүнийг хиймэл хөл дээрээ сайн алхаж, дугуйгаа дахин жийж сурахад тусалж сэргээн засалтын тусламж үзүүлсэн. Одоо Чандесвар Биратнагарын завгүй гудамжаар дугуйгаа жийж, амьдралаа дажгүй залгуулж яваа билээ.

Чандесвар шиг хүмүүсийг хараад CBRB-ийн ерөнхийлөгч “Бид ХОТСЗ хөтөлбөрийг олон жил хэрэгжүүлсэн боловч чанартай туслах хэрэгслээр хангаж эхэлснээс хойш бид илүү үр дүнтэй, хариуцлагатай явж, хамт олны хүндэтгэлийг авч байна” гэж хэлсэн.



## Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд сайн чанарын, тохирох туслах хэрэгсэлтэй болж, гэр бүл болон хамт олны амьдралд оролцох.

## ХОТСЗ-ын үүрэг

ХОТСЗ хөтөлбөр нь туслах хэрэгслийн хэрэгцээг тодорхойлж, туслах хэрэгсэл хүртэх аргыг нь зааж өгөн, шаардлагатай тохиолдолд угсрах, засах, солих ажлыг нь хийж өгөхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний гэр бүлтэй хамтран ажиллах үүрэгтэй.

## Хүсч буй үр дүн

- ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд нь туслах хэрэгслийн төрөл, үүрэг болон бэрхшээл тус бүрт тохирох байдал, тухайн орон нутагт үйлдвэрлэх боломж, олдоц болон тусгай хэрэгсэл авахад илгээх механизм зэргийн талаар мэдлэгтэй болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүл нь туслах хэрэгслийн талаар мэдлэгтэй байх ба мэдээлэл авсны үндсэн шийдвэр гаргаж хэрэглэдэг болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд туслах хэрэгслийг зөв хэрэглэж, арчлах талаар сургалт зохион байгуулна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлин гишүүд болон орон нутгийн хүмүүс үндсэн туслах хэрэгслүүдийг үйлдвэрлэж, энгийн засваруудыг хийж, хэвийн хэмжээнд нь байлгах чадвартай болно.
- Мэдээлэл хомс байх, санхүүгийн хүндрэл бэрхшээл, төвлөрсөн үйлчилгээний газар зэрэг бэрхшээлээс болж туслах хэрэгслийн хүрэлцээг багасгаж байгаа бэрхшээлүүдийг арилгана.
- Шаардлагатай тохиолдолд туслах хэрэгсэл ашиглахад орчны хүчин зүйлүүдийг харгалзан үзнэ.

## Гол ойлголтууд

### Туслах хэрэгслийн түгээмэл хэлбэрүүд

Туслах хэрэгсэл нь энгийн буюу өндөр технологийн биш (таяг, зориулалтын аяга гэх мэт) хэрэгслээс эхлэн нарийн буюу өндөр технологиор бүтээсэн хэрэгсэл (компьютерийн тусгай програм болон техник хангамж, мотортой тэргэнцэр гэх мэт) хүртэл олон төрөл байдаг учраас тэдгээрийг дотор нь ангилах боломжтой.

## **Хөдөлгөөн дэмжих хэрэгсэл**

Хөдөлгөөний туслах хэрэгсэл нь алхах, хөдлөхөд туслана:

- Тэргэнцэр
- Гурван дугуйт
- Суга таяг
- Таяг/Цагаан таяг
- Алхуулагч

Хөдөлгөөн дэмжих хэрэгсэл нь хэрэглэгчийн хэрэгцээнд тохируулдаг онцлогтой байж болно. Тухайлбал, тархины саатай хүнд түүнийг зөв суухад зориулж цээж/толгойн түшлэгтэй тэргэнцэр шаардлагатай байж болно. Нөхцөл бололцоо муутай газарт гар тэргэнцэрээр хангах ДЭМБ-ын гарын авлага нь тэргэнцэрийг зохиох, бүтээх, үйлдвэрлэх, түгээх ажлыг хийдэг хүмүүст ашигтай материал байдаг.

## **Байрлуулах хэрэгсэл**

Хөдөлгөөний бэрхшээлтэй хүнд хэвтэх, босох, суух үйлдэл хийхэд хүндрэлтэй байдаг бөгөөд буруу байрлалаас болж гажиг үүсэх эрсдэлтэй байдаг. Дараах хэрэгслүүд зарим хүндрэлийг давахад туслана:

- Налуу тавцан
- Сандаал. Жишээ нь: булангийн сандал, тусгай суудал
- Зогсоох хэрэгсэл

## **Протез, ортоз, ортопед гутал**

Эдгээр нь ихэнхдээ хүний биеийн хэсгүүдийг засах, дэмжих, орлуулахын тулд захиалгаар хийдэг хэрэгсэл юм. Тусгай төвд, бэлтгэгдсэн мэргэжилтнүүд зохиож, үйлдвэрлэж, тааруулдаг хэрэгслүүд:

- Протез: хиймэл хөл, гар
- Ортоз: хөл, гар, нурууны чиг баригч
- Ортопед (гажигтай хөлөнд таарсан) гутал

## **Өдөр тутмын хэрэгсэл**

Энэ нь өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг (идэх, усанд орох, хувцаслах, бие засах, орон гэрийг засах) гүйцэтгэх боломжтой болгох хэрэгсэл юм. Олон жишээ байна:

- Зориулалтын гал тогооны хэрэгсэл, аяга
- Душны сандал
- 00-ийн суултуур ба түшлэг
- Шүүгээ
- Хувцасны өлгүүр

## Харааны хэрэгсэл

Хараа муу, эсвэл хараагүй байх нь хүний амьдралын чухал үйл ажиллагааг хийх чадварт маш ихээр нөлөөлдөг. Энгийнээс нарийн хэрэгслүүд нь нийгмийн оролцоо болон бие даасан байдлыг нэмэгдүүлдэг:

- Том үсгээр хэвлэсэн ном
- Томруулагч шил
- Нүдний шил
- Цагаан таяг
- Унших, бичихэд хэрэглэдэг Брайл систем
- Дуу бичлэгийн хэрэгсэл, жишээ нь: радио, ярьдаг ном, гар утас
- Компьюетрийн дэлгэц унших програм (тухайлбал дэлгэц уншигч JAWS програм)

## Сонсголын хэрэгсэл

Сонсголоо алдах нь бусадтай харилцах чадварт төдийгүй ялгаварлан гадуурхалт, тусгаарлагдахад хүргэдэг хэл яриа, хэл болон сурах, ажиллах боломжийг хязгаарлах зэрэг хөгжлийн олон үйл ажиллагаанд нөлөөлдөг. Сонсголын хэрэгслүүд нь:

- Сонсголын аппарат
- ТВ сонсох чихэвч
- Утасны өсгөгч
- ТТҮ/ТТД Харилцаа холбооны хэрэгсэл
- Харааны системээр дохио өгөх. жишээ нь: хонх дуугарахад гэрэл асах гэх мэт

## Жишээ 32 Папуа Шинэ Гвиней

### Шилдэг сурагч

Анна Папуа Шинэ Гвинейгийн Ийст Сэпикт амьдардаг эх хүн юм. Түүний охин Корис төрөлхийн сонгсолгүй байв. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Каллан Үйлчилгээ (үндэсний төрийн бус байгууллага)-ын ХОТЗ хөтөлбөрийн ажилтан Аннад хүүхдээ сургуульд явуулах шаардлагатайг хэлэв. Анна сонгсолгүй хүүхдүүдийг сувилах сургуулийн талаар мэдлэгтэй болсон байв. Сургуульд хамрагдахаас нь өмнө Каллан Үйлчилгээ байгууллага сонсголын аппаратаар хангах ажлыг зохион байгуулав. Корисийн чихний хэвийг авч, сонсголын аппаратыг бэлэн болмогц Порт Морисбигийн чих хамар хоолойн эмч дээр очиж тааруулуулсан. Корис сургуульд орж, дохионы хэл сурч эхэлсэн. Туслах хэрэгслийн тусламжтайгаар, мөн багш нарынхаа дэмжлэгтэйгээр Корис шилдэг сурагчдын нэг болсон.

## Харилцааны хэрэгсэл

Ойлгох болон ярихад хүндрэлтэй хүнд харилцааны хэрэгсэл тус болдог. Ярихад туслах эсвэл хэл яриаг орлуулах хэрэгсэл нь:

- Зураг, тэмдэгт, цагаан толгойн үсэгтэй харилцах самбар
- Хүсэлтийн картууд
- Дуу хоолойг гаргах төхөөрөмж
- Тусгай тоног төхөөрөмж болон програмаар тоноглогдсон компьютер

## Танин мэдэхүйн хэрэгсэл

Танин мэдэх нь мэдээллийн үйл явц ба ойлгох чадвар юм. Үүнд санах, төлөвлөх, асуудал шийдэх зэрэг тархины сэтгэцийн үйлдлүүд багтана. Тархины гэмтэл, оюуны бэрхшээл, солиорол, дэмийрэл болон сэтгэцийн өвчнүүд нь хувь хүний танин мэдэхүйн чадварт нөлөөлдөг. Дараах хэрэгслүүд нь цаг төлөвлөх, чухал үйл явдлыг санах, үйл ажиллганд бэлтгэхэд тус болно:

- Жагсаалт гаргах
- Өдрийн тэмдэглэл
- Хуанли
- Хуваарь
- Гар утас, пэйжэр, хувийн зохион байгуулагч зэрэг цахим хэрэгслүүд

## Туслах хэрэгсэл сонгох

### Тохирох технологи

Олон төрлийн технологи нь буурай хөгжилтэй орны хөдөө тосгодод тохиромжгүй байдаг хэдий ч “тохирох технологи” нь хувь хүн, хамт олонд нөлөөлөх хүрээлэн буй орчин, соёл, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлийг анхаарахад зориулагдсан. Тохирох технологи нь хүний хэрэгцээг хангадаг. Энэ нь орон нутгийн материалаар, орон нутгийн чадвар, багаж хэрэгслээр хийсэн, энгийн, үр дүнтэй, боломжийн үнэтэй, бүгд хүлээн зөвшөөрсөн байдаг. Туслах хэрэгслүүдийг дээрх шалгуур үзүүлэлтэнд нийцүүлж зохиож, үйлдвэрлэж, сонгодог технологи юм.



## Жишээ 33 Энэтхэг

Ижил гутал өмссөн нь

Энэтхэгийн Андра Прадишийн Ассисси Лепроз болон ХОТСЗ хөтөлбөр нь уяман өвчний улмаас тавхай нь мэдрэмжээ алдсан, хөл нь үрэвсэх эрсдэлтэй иргэдэд зориулж хар микро эсийн резинээр сандаал хийсэн. Олон иргэдийг сандаалаар хангасан ч тэд хэрэглэхгүй байгаа нь илэрхий байсан. Эдгээр хүмүүстэй ярилцсаны дүнд сандаал өмсөх нь нийгмийн зүгээс буруу ойлголтыг бий болгож байгааг мэдэж авав – ийм хар сандаалыг зөвхөн уяман өвчтэй иргэд л өмссөн байдаг нь хүмүүс тэднийг амархан таних боломжтой болгожээ. Ингээд хөтөлбөр орон нутгийн зах зээлээс худалдан авах боломжтой шаахайг ашиглахаар шийдэн түүнийг уяман өвчтэй хүмүүст зориулан өөрчилсөн. Ингэснээр бусдын өмсдөгөөс үл ялиг л ялгаатай болсон.

### Үнэлгээ

Туслах хэрэгсэлийг хувь хүний хэрэгцээг хангахуйц, тусгайлан хийсэн байх ба зөв сонгох хэрэгтэй. Буруу сонголт нь урам хугарах, тавгүй байх, хоёрдогч хүндрэл гаргах зэрэг асуудал үүсгэх болно. Тухайлбал, зарим оронд хандивын хуучин тэргэнцэрийг их хэмжээгээр тараах явдал нийтлэг тохиолддог. Энэ нь хэдийгээр хүндээ ашиг тусаа өгч байгаа хэдий ч хэрэглэгчдэд хор хөнөөл учруулж болзошгүй байдаг. Нуруу нугасны гэмтэлтэй хүнд зөөлөвчгүй тэргэнцэр өгвөл амьдралд нь аюул учруулж болзошгүй даралт үүсгэж болно (Урьдчилан сэргийлэлт элементийг уншина уу).

Туслах хэрэгслийг хувь хүний гэрт, сургууль дээр, мөн хамт олны орчинд хэрэгцээг нь хангахуйц байлгахад иж бүрэн үнэлгээ хийх нь маш чухал юм. Иж бүрэн үнэлгээнд эмнэлгийн түүх, одоогийн функцийг харах, хувь хүний өөрийн зорилго, туслах хэрэгслүүдийн үнэлгээ болон биеийг шалгах зэрэг орно. Үнэлгээнд аль болохоор олон салбарын хүмүүсийг, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гэр бүлийн гишүүд, засалч нар, техникчид, багш нар, ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд, оролцуулах хэрэгтэй.

### Туслах хэрэгслийн хэрэглээ

#### Саадгүй орчин

Ихэнх хүмүүс туслах хэрэгслээ өөр өөр газар ашигладаг учраас бие дааж явахад орчин саадгүй байх нь чухал юм. Жишээ нь: тэргэнцэртэй залуу бүсгүй гэр рүүгээ орох болон гарах, гэр дотроо чөлөөтэй явах, заавал орох газрууд (бие засах өрөө гэх мэт) руу орох боломжтой байх, ажил руугаа явах боломжтой байх ёстой.

Бие махбодын орчинг бүрдүүлэхдээ шаттай газар налуу зам барих, хаалгыг өргөсгөх, тавилгаа өөрчилж зайчлах зэргээр тохируулгыг хийж болно. Мөн түүнчлэн тухайн хэрэгслийг ашиглах тухайн хүний чадварт нөлөөлдөг хандлагын болон дэмжлэгийн тогтолцоо зэрэг орчны бусад зүйлүүдэд анхаарлаа хандуулах нь чухал. Тухайлбал, ярьж чаддаггүй харилцааны самбар ашигладаг залуу хүү самбараа гэрт, сургууль дээрээ ашигладаг. Тиймээс гэр бүлийн гишүүд, сургуулийн багш, найз нөхөд нь түүнийг самбараа ашиглахад нь эерэгээр дэмжиж байх нь маш чухал.



Орчны өөрчлөлт хийх үедээ, ялангуяа хамт олны түвшинд хийхдээ “түгээмэл загвар”-ыг анхааралдаа авах нь зүйтэй. Түгээмэл загвар гэдэг нь бүтээгдэхүүн, орчин, хөтөлбөр, үйлчилгээг загварчлахдаа хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй бүх хүмүүс ижил тэгш хэрэглэх боломжтой болгоно гэсэн үг юм.

## Жишээ 34 Вьетнам

### Орон нутагт гүүр барих

Вьетнамын Тай Бин дүүргийн нэгэн тосгонд ХОТСЗ хөтөлбөрийн сайн дурынхан орон нутгийн гүүрийг сайжруулах ажилд нутгийн иргэдийг уриалснаар тэргэнцэртэй иргэд болон бусад хүмүүс гүүрээр гарахад тухтай болгож чадсан.

## Санал болгож буй үйл ажиллагаанууд

### ХОТСЗ хөтөлбөрийн ажилтанг сурга

ХОТСЗ хөтөлбөрийн ажилтанд туслах хэрэгслийн талаар бодит мэдээлэл, илгээх болон боловсрол олгох талаар сургалт шаардлагатай. Уг сургалт нь тусгайлсан байх ба эсвэл сэргээн засалтын сургалтын хөтөлбөрийн нэг хэсэгт оруулж болно. ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд дараах зүйлүүдийн талаар мэдлэгтэй байх ёстой:

- Туслах хэрэгслийн нийтлэг хэлбэрүүд;
- Туслах хэрэгслийн үүрэг болон зорилго;
- Орон нутагт аль хэрэгслийг бэлтгэж болох (тухайлбал, таяг);
- Протез, сонсголын аппарат гэх мэт тусгай хэрэгслүүд хаана байдаг;
- Тусгай хэрэгслийг авах илгээх механизм;
- Хэрэгслийн үнийг төлж чадахгүй хүмүүст санхүүгийн сонголт байгаа эсэх.

Практик сургалт нь чухал, ялангуяа хөдөө орон нутагт ажиллаж байгаа ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд туслах хэрэгсэл шаардлагатай хүнтэй шууд ажиллах итгэл дүүрэн, чадвартай, мөн тэдэнд үндсэн туслах хэрэгслийг үйлдвэрлэж чаддаг байхын тулд сургалтанд хамрагдах нь чухал. Тухайлбал, ХОТСЗ хөтөлбөрийг ажилтан дараах зүйлүүдийг хийж болно:

- Суухдаа тэнцвэр муутай хүүхдийг суулгахын тулд цээжний бэхэлгээтэй модон сандал хэрхэн хийхийг гэр бүлд нь зааж өгөх;
- Гэртээ явах дасгал хийхийн тулд паралель бар хэрхэн хийхийг гэр бүлд нь зааж өгөх;
- Цус харваад сэргэж байгаа хүнд алхахад нь зориулж таяг хэрхэн хийхийг гэр бүлд нь зааж өгөх;
- Ярьж чаддаггүй эсвэл хамаагүй хөдөлгөөнтэй тархины саатай хүүхдэд зурагтай харилцааны самбарыг нүдээрээ ашиглан хэрхэн ашиглахыг зааж өгөх;
- Хараагүй хүнд цагаан таягийг хэрэглэх талаар зааварчилгаа өгөх.

## Жишээ 35 Индонези

### Мэдээллийг хэрэгтэй газар нь өгөх

Индонезийн Өмнөд Сулавезигийн ХОТСЗ хөтөлбөр нь орон нутагт туслах хэрэгслийг нийлүүлдэг, засварладаг гол үйлчилгээ үзүүлэгчдийн нэрсийг жагсаасан Туслах Хэрэгслийн Нөөцийн хуудсыг гаргасан. Тосгоны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бодит мэдээллээр хангахын тулд энэхүү нөөцийн хуудсыг ХОТСЗ хөтөлбөрийн бүх ажилтнуудад тараасан.

### Хувь хүн ба гэр бүлийг чадавхжуул

ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан нь дараах зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдтэй нягт хамтран ажиллах ёстой:

- Туслах хэрэгслийн төрөл бүрийг мэддэг, тэдний бие дааж, оролцоход эдгээр нь хэрхэн тусалдагийг мэддэг байх;
- Туслах хэрэгслийг зохиох, сонгох тал дээр шийдвэр гаргахад оролцох – хүмүүсийг мэдээллийнхээ үндсэн дээр шийдвэр гаргахад туслах зорилгоор туслах хэрэгслүүдийг хэрэглэж үзэх боломжийг олгох;
- Туслах хэрэгслийн зөв, аюулгүй хэрэглэж, засварлаж, удаан хугацаанд хэрэглэх арчилгааг хийж чаддаг байх;
- Гарч байгаа хүндрэлүүдийн талаар илгээх үйлчилгээнд буцааж мэдэгдэж, засвар тохиргоог хийлгэх, мөн өөр сонголтуудыг анхаарч үзэх.

Энэхүү эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсэг нь өөрөө өөртөө туслах бүлэг хүмүүсийг үнэтэй мэдээллээ, ур чадвар, туршлагаа солилцох боломжийг олгодогийг цохон тэмдэглэж байна. Сэргээн засалтын мэргэжилтэн дутмаг байгаа үед өөрөө өөртөө туслах бүлэг маш ач холбогдолтой байдаг. Өөрөө өөртөө туслах бүлэг хүмүүст шинээр авсан туслах хэрэгслээ хэрхэн өөртөө тохируулах, түүнийг хэрхэн арчлахыг зааж өгөх, мөн өөрийгөө арчлах талаар зөвлөгөө (хоёрдогч хүндрэл гарахаас сэргийлэх, үйлдлээ хэрхэн дээд зэргээр сайжруулах гэх мэт) өгч чаддаг.

### Орон нутгийн гарын ур дүй сайтай хүмүүсийг сурга

Хөдөө орон нутагт байгаа хүмүүс нарийн мэргэжлийн тусгай төв рүү явж хэрэгслээ засварлуулахгүй гэдэг нь тодорхой. Тэдэнд асуудал гармагц тэрхүү хэрэгслийг хэрэглэхээ больдог. Орон нутгийн гарын ур дүй сайтай хүмүүсийг ортодод, протез, тэргэнцэр зэрэг туслах хэрэгслийг засах (тухайлбал ортозийн уяа, шруп, хадаас зэргийг солих гэх мэт) сургалтанд хамруулж болно. ХОТСЗ хөтөлбөр орон нутгийн гарын ур дүй сайтай хүмүүсийг олж, техникчидтэй хамтран сургалт зохион байгуулж болно.

Гар таяг, суга таяг, алхуулагч, зогсоо рам, суудал зэрэг туслах хэрэгслүүдийг орон нутгийн гарын ур дүй сайтай хүмүүс хийж болно. Учир нь эдгээрийг орон нутгийн олдоц ихтэй материал ашиглаж хийхэд хамгийн хялбар. ХОТСЗ хөтөлбөр тэдгээр хэрэгслүүдийг хийхийг сонирхсон орон нутгийн гарын ур дүй сайтай хүмүүсийг олж, сургалт зохион байгуулж болно.



## Жишээ 36 Монгол

### Туслах хэрэгслийг хэрхэн хийх талаар сургах

2000 онд үндэсний ХОТСЗ хөтөлбөр нь Улаанбаатар хотод Протезийн үйлдвэр дээр төрөл бүрийн чиг хийх, суух хэрэгсэл, хөдөлгөөн дэмжих хэрэгсэл зэргийг орон нутгийн олдоц ихтэй материал ашиглан тохирох технологийн дагуу үйлдвэрлэх сургалтыг зохион байгуулсан. ХОТСЗ хөтөлбөр шинэ аймгуудыг хамруулахдаа орон нутгаас хоёр гарын ур дүй сайтай хүмүүсийг авчран сургалт зохион байгуулдаг.

### Туслах хэрэгслийн хүртээмжийг дэмжих

Туслах хэрэгслийн хүртээмж нь мэдээллийн хангалтгүй байдал, ядуурал, алслагдмал, төвлөрсөн үйлчилгээний байдлаас болж хязгаарлагдмал байдаг. ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүтэй хамтарч дараах санал болгож буй үйл ажиллагаануудыг хийж туслах хэрэгслийн хүртээмжийг чиглүүлэх хэрэгтэй:

- Туслах хэрэгслийг төрөл бүрээр нь нийлүүлдэг эсвэл үйлдвэрлэдэг орон нутгийн, бүсийн, үндэсний үйлчилгээг үзүүлэгчдийг олж илрүүлэх;
- Үйлчилгээ үзүүлэгч бүрийг тэдний илгээх механизм, үнэ, процесс (захиргааны процедур, үнэлгээний процедур, хэмжээ авахад хэдэн удаа очих шаардлагатай, тохируулах, үйлдвэрлэх хугацаа гэх мэт) зэргийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулах;
- Дээрх мэдээлэл тохирох форматаар байгаа эсэхийг баталгаажуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд мэдээлэлх;
- Туслах хэрэгслийн төлбөрийг хариуцаж чадахгүй хүмүүсийн хувьд санхүүгийн сонголт байгаа эсэхийг тодорхойлох – ХОТСЗ хөтөлбөр засгийн газар, төрийн бус байгууллагын хөтөлбөрүүдтэй танилцаж, санхүүжилт олгох тухай, эсвэл хүмүүсийг хандив өгөх ажиллагаанд уриала дуудах зэрэг ажлыг чиглүүлж болно;
- Холбогдох захиргааны процессыг гүйцэтгэхэд хүмүүст тусалснаар тэд хөгжлийн бэрхшээлийн үнэмлэхээ авч, туслах хэрэгслийг үнэгүй авах боломжтой болно;
- Илгээх төвүүд, орон нутгийн захиргааны байгууллага, болон бусад байгууллагуудтай түншилж үйлчилгээний хангамжийн төвлөрөлийг сааруулах арга замуудын (явуулын үйлчилгээ гэх мэт) тухай ярилцах;
- Хөдөө орон нутгаас илгээх төвөөр үйлчлүүлэх гэж байгаа хэсэг бүлэг хүмүүсийн тээврийн асуудлыг шийдвэрлэх. Энэхүү төв дээр очиж үйлчлүүлэх цагийг урьдчилж авч, өдөр тогтоохыг баталгаажуулах шаардлагатай.
- Хөдөө орон нутагт амьдарч байгаа хүмүүст гэрээр болон хамт олонд түшиглэсэн засварын үйлчилгээгээр хангах. Тухайлбал явуулын үйлчилгээ байгуулах эсвэл хэрэгслээ засуулах шаардлагатай хүмүүст зориулж тогтмол уулздаг цэг байгуулах.

## Жишээ 37 Ливан

### Туслах хэрэгслийг хүртэх

Ливаны Үндэсний хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага нь суга таяг, оо-ийн сандал, ортопед гутал, тусгай суултын систем зэрэг туслах хэрэгслүүд болон тэргэнцэр үйлдвэрлэх нэгжээ нээв. Мөн хэрэгслийг орон даяар хүргэхийн тулд түгээх, засвар үйлчилгээний 5 салбар байгуулсан. Үйлдвэр болон засварын газарт хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажилладаг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага туслах хэрэгсэлд зориулан улсын төсвөөс тохирох төсвийг авдаг болсон. Одоо ХОТСЗ хөтөлбөр нь туслах хэрэгсэл шаардлагатай хүмүүсийг тэрхүү төв рүү илгээдэг болсон.

### Жижиг оврын засварын цех байгуулах

Илгээх үйлчилгээ байхгүй эсвэл төлбөр, хол зай зэрэг саад бэрхшээлүүд байгаа тохиолдолд ХОТЗ хөтөлбөр орон нутгийн хэрэгцээг хангах зорилгоор жижиг оврын цех байгуулахад дэмжлэг үзүүлж болно. Энгийн хэрэгслүүдийг бэлтгэгдсэн хүмүүсээр үйлдвэрлэж болно. ДЭМБ-ын ХОТСЗ хандлагын багц гарын авлага, Эмгэг согогтой хүүхдийн гарын авлагууд дээр орон нутгийн нөөц бололцоог ашиглан туслах хэрэгсэл хийх талаар мэдээлэл байгаа.

## Жишээ 38 Монгол

### Орон нутагт жижиг оврын ортопедийн цех байгуулах

1998 онд ХОТСЗ хөтөлбөрийн урилгаар Энэтхэгийн Мобилити Индиа төрийн бус байгууллагын мэргэжилтэн ирж Монголын гарын ур дүйтэй нутгийн хүмүүс, ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд болон Сувиллын 10-р цогцолборын эмч, ажитнууд туслах хэрэгслийг орон нутгийн олдоц ихтэй материалаар хэрхэн хийх сургалт зохион байгуулснаар “Тэгш Дүүрэн” хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст энгийн туслах хэрэгслүүдийг хийх ажил эхэлсэн юм.

АИФО, Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр нийт 21 аймаг, Сэргээн засалтын үндэсний төв, Сувиллын 10-р цогцолборт жижиг оврын ортопедийн цех байгуулсан.

Жижиг оврын ортопедийн цех нь цээжний бүстэй түшлэгтэй сандал, булангийн сандал, зогсоох хэрэгсэл, хөл, гарын чиг, эрхий хуруу салгагч, хүзүүвч, налуу тавцан, өлмий өргөгч зэргийг мод, даавуу, ПВХ хоолой ашигч

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс мөн туслах хэрэгсэл хийхэд сургалтанд хамрагдаж болно. Ингэснээр тэдний орлого нэмэгдэж, хамт олондоо мөн нийгмийн сүлжээний хөгжилд идэвхтэй хувь нэмэр оруулагч болж танигдахад тус болно. Мөн тэд эрх мэдэлжиж чадавхжина.

## Жишээ 39 ЭНЭТХЭГ

### Жижиг бизнес эрхлэх

Энэтхэгийн Бангалорын хэд хэдэн ХОТСЗ хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй 10 залуу эмэгтэйг илрүүлсэн. Бүгд л ядуу, боловсролгүй дээр нь эмэгтэй учраас ялгаварлан гадуурхагдахын зэрэгцээ гэр бүл болон нийгэмдээ хүнд ачаа шиг харагддаг байв. 1998 онд эдгээр 10 эмэгтэйг ортопедийн техникчийн сургалтад хамруулж, ХОТСЗ хөтөлбөрөөс арилжааны зориулалттай цех байгуулахыг нь дэмжиж зээл олгов. Тэд бизнесээ эхлүүлснээс хойш амьдрал нь өөрчлөгдсөн (Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг сэргээн засах хэрэгслийн цех). Тэдний цех 2 дах жилээсээ ашгаа өгч, 4 дэх жилийн төгсгөл гэхэд зээлээ бүрэн төлж дууссан. Тэд туслах хэрэгсэл болон эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хэд хэдэн том компаниудын төлөөлөгч болж, томоохон хувийн эмнэлэгүүдтэй холбоо тогтоож бизнесээ өргөжүүлсэн. Одоо эдгээр эмэгтэйчүүд орлого сайн олж, чанартай амьдарч, хамт олондоо идэвхтэй хувь нэмэр оруулагч гэдгээр танигдсан. Тэд гэрлэж, гэр бүлтэй болж, олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд бишрэгч нь болсон.



### Сүлжээ ба хамтын ажиллагаа

Зарим оронд төрөл бүрийн туслах хэрэгслээр хангах үйлчилгээ бий болгох боломжгүй байдаг. Энэ нь мэдээж засгийн газрын тэргүүлэх чиглэл, хязгаарлагдмал эх үүсвэр, эсвэл хүн ам бага байх гээд олон зүйлээс шалтгаална. Мөн олон туслах хэрэгслүүд хөрш оронд илүү хямдхан, өндөр хөгжилтэй орноос импортлохгүй хялбар олддог. ХОТСЗ хөтөлбөр хөрш оронд ямар боломж байгааг судалж, боломжтой бол тэдгээр оронтой хамтран ажиллах шаардлагатай. Мөн ХОТСЗ хөтөлбөр нь үйлчилгээг тогтвортой болгохын тулд туслах хэрэгслийг үйлдвэрлэдэг, түгээдэг олон улсын болон үндэсний төрийн бус байгууллагуудтай сайн холбоо тогтоох шаардлагатай.

### Орчин тойронд тохиолдох саад бэрхшээлүүдийг арилга

Хүмүүсийг туслах хэрэгслээ ашиглахад саад бэрхшээлүүд ихэнхдээ гэр орон, сургууль, ажил эсвэл хамт олны орчинд тохиолддог. ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан эдгээр саад бэрхшээлүүдийн талаар практик мэдлэгтэй байх шаардлагатай ба хувь хүн, гэр бүлийн гишүүд, хамт олон, орон нутгийн засаг захиргаатай хамтран ажиллаж болно.

## Ашигласан материалууд

1. Constitution of the World Health Organization . Geneva, 2006 ([www.who.int/governance/eb/who\\_constitution\\_en.pdf](http://www.who.int/governance/eb/who_constitution_en.pdf), accessed 30 May 2010).
2. Convention on the Rights of Persons with Disabilities . New York, United Nations, 2006 ([www.un.org/disabilities/](http://www.un.org/disabilities/), accessed 30 March 2010).
3. Becker H. Measuring health among people with disabilities. *Community Health* , 2005, 29(1S):70S–77S.
4. The right to health (Fact Sheet No. 31). Geneva, Office of the United Nations High Commissioner for Human Rights/World Health Organization, 2008 ([www.ohchr.org/Documents/Publications/Factsheet31.pdf](http://www.ohchr.org/Documents/Publications/Factsheet31.pdf), accessed 30 May 2010).
5. Disability, poverty and development. London, Department for International Development, 2000 ([www.dfid.gov.uk/Documents/publications/disabilitypovertydevelopment.pdf](http://www.dfid.gov.uk/Documents/publications/disabilitypovertydevelopment.pdf), accessed 30 May 2010).
6. Access to basic services for the poor: The importance of good governance (Asia Pacific MDG Study Series). Bangkok, United Nations Economic and Social Commission for Asia and the Pacific/UNDP/ADB, 2007 ([www.unescap.org/pdd/prs/ProjectActivities/Ongoing/gg/access-to-basic-services.asp](http://www.unescap.org/pdd/prs/ProjectActivities/Ongoing/gg/access-to-basic-services.asp), accessed 30 May 2010).
7. From exclusion to equality: realizing the rights of persons with disabilities . Geneva, United Nations –DESA/OHCHR/IPU, 2007 ([www.ohchr.org/Documents/Publications/training14en.pdf](http://www.ohchr.org/Documents/Publications/training14en.pdf), accessed 30 May 2010).
8. The determinants of health. Geneva, World Health Organization, 2010 ([www.who.int/hia/evidence/doh/en/](http://www.who.int/hia/evidence/doh/en/), accessed 30 May 2010).
9. Health systems . Geneva, World Health Organization, 2010 ([www.who.int/topics/health\\_systems/en/](http://www.who.int/topics/health_systems/en/), accessed 30 May 2010).
10. World health report 2008: primary health care – now more than ever. Geneva, World Health Organization, 2008 ([www.who.int/whr/2008/whr08\\_en.pdf](http://www.who.int/whr/2008/whr08_en.pdf), accessed 30 May 2010).
11. Declaration of Alma Ata: International Conference on Primary Health Care, Alma Ata, USSR, 6–12 September 1978. Geneva, World Health Organization, 1978 ([www.who.int/publications/almaata\\_declaration\\_en.pdf](http://www.who.int/publications/almaata_declaration_en.pdf), accessed 30 May 2010).
12. Rimmer JH, Rowland JL. Health promotion for people with disabilities: Implications for empowering the person and promoting disability-friendly environments. *Journal of Lifestyle Medicine* , 2008, 2(5):409–420.
13. International Norms & Standards Related to Disability, Section V – Rights of special groups with disabilities. New York, United Nations, 2003–2004 ([www.un.org/esa/socdev/enable/discom500.htm](http://www.un.org/esa/socdev/enable/discom500.htm), accessed 30 May 2010).
14. CBR: A strategy for rehabilitation, equalization of opportunities, poverty reduction and social inclusion of people with disabilities (Joint position paper 2004). Geneva, International Labour Organization, United Nations Educational, Scientific and Cultural Organization, and World Health Organization, 2004 ([www.who.int/disabilities/publications/cbr/en/index.html](http://www.who.int/disabilities/publications/cbr/en/index.html), accessed 30 May 2010).
15. Understanding community-based rehabilitation . Bangkok, United Nations Economic and Social Commission for Asia and the Pacific, 2009 ([www.unescap.org/esid/psis/disability/decade/publications/cbr.asp](http://www.unescap.org/esid/psis/disability/decade/publications/cbr.asp), accessed 30 May 2010).





# ХОТСЗ ХАНДЛАГЫН МАТРИЦ

